

-А.Долгорханд, С.Амарзаяа, Б.Сувд, Б.Оюунбилэг, Н.Эрдэнэбат <b>Хачигт энцефалит өвчний тархвар зүй, ийлдэс эмчилгээний зарим үр дүнг судалсан дүн</b>	17/39	<b>-The epidemiology analysis of tick borne encephalitis</b> by A.Dolgorkhand, S.Amarzaya , B.Suvd , B.Oyunbileg and N.Erdenebat
-П.Нацагням, Ж.Амарсанаа, Б.Саяболд, Н.Лхасүрэн,Дэлгэрзаяа,Ж.Чинбүрэн,О.Баатархүү , Б.Цацралт-од , Л.Дашцэрэн , Д.Авирмэд <b>Архаг В хепатиттай өвчтөнүүдэд вирусийн серологи маркерүүдийн Монгол улс дахь өнөөгийн тархалт болон түүний ач холбогдол</b>	17/39	<b>-Current Distribution of HBV Serological Markers in Chronic HBV Patients and its Significance in Mongolia</b> by P.Natsagnyam,J. Amarsanaa, B. Sayabold ,N. Lkhasuren, Delgerzaya, J.Chinburen, O. Baatarkhuu, B.Tsatsralt-Od, L.Dashtseren and D. Avirmed
-Г.Нямаа, А.Бурмаа, Б.Тиан , С.Цацрал, Ц.Наранзул, Н.Баясгалан, Б.Ариунсанаа, Л.Энхбаатар, Б.Ганцоож, Д.Либо , Б.Дармаа, П.Нямдаваа <b>Улаанбаатар хотын хүн амын дунд томуугийн цартахлын эсрэг дархлаа тогтооны түвшинг хөөн судалсан дүн</b>	18/40	<b>-Prevalence of antibodies to the pandemic of influenza virus in Ulaanbaatar</b> by G.Nyamaa,A.Burmaa,B.Tian,Ts.Naranzul, N.Bayasgalan, B.Ariunsanaa, L.Enkhbaatar, B.Gantsooj, D.Libo, B.Darmaa and P.Nymadawa
-Р.Одбилиг, С.Коннай, К.Охashi, М.Онума <b>Монгол тэмээ (Camelus bactrianus) болон лам гөрөөс (lama glama)-ний зарим цитокиний молекул бүтцийг харьцуулан тодорхойлж, түүний вируст халдвартын эмгэг жамтай холбогдох байдлыг судалсан нь</b>	18/40	<b>-Comparative study of some selected cytokine molecular structures in Mongolian bactrian camel (Camelus bactrianus) and llama (lama glama) and its implications in pathogenesis of viral infections</b> by R. Odbileg, S. Konnai, K. Ohashi and M. Onuma
-Д.Отгонбаатар, Ж.Дуламжав, Д.Цэрэнноров <b>Вирусээр үүсгэгдэг байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний судалгааны үр дүнгээс</b>	19/41	<b>-Some study results of zoonotic and natural focus infectious diseases caused by virus</b> by D.Otgonbaatar, J.Dulamjav and D.Tserennorov
-К.Отани, А.Сузуки, К.Тома, Т.Итамура, Х. Отомару, Н.Фужи, Х.Галанг, Е. Меркадо, С.Луписан, Х.Ошитани <b>Азиин хоёр орон: Япон, Филиппин хүний метапневмонии вирусийн эргэлт</b>	19/41	<b>-Circulation of human metapneumovirus in Two Asian Countries, Japan and the Philippines</b> by K.Otani, A.Suzuki, K.Tohma, T.Imamura, H.Otomaru, N.Fuji, H.Galang, E.Mercado, S.Lupisan and H.Oshitani
-Р.Түүл, Д.Отгонбаяр, У.Наранчимэг, П.Нямдаваа, В. Лим , Г.Вүү , Ю.Жээ <b>Монгол улсад оношлогдсон улаанбурханы вирусийн генотип</b>	20/42	<b>-Measles Virus Genotypes Diagnosed in Mongolia</b> by R.Tuul , D.Otgonbayar, U.Naranchimeg, P.Nymadawa , W. Lim, G.Woo and Y. Jee
-Р.Түүл, Д.Отгонбаяр, У.Наранчимэг,П.Нямдаваа, В. Лим , Г.Вүү , Ю.Жээ <b>Өмнөговь аймагт бүртгэгдсэн гахай хавдрын халдвартын молекулын эпидемиологи</b>	21/42	<b>-Molecular Epidemiology of Mumps Virus Infection Registered in Umnugovi Province</b> by R.Tuul , D.Otgonbayar, U.Naranchimeg, P.Nymadawa , W. Lim, G.Woo and Y. Jee
Р.Түүл, Д.Отгонбаяр, У.Наранчимэг,П.Нямдаваа, В.Лим , Г.Вүү , Ю.Жээ <b>Монгол улсад эргэлдэж байгаа улаануудын вирусийн генотип</b>	21/43	<b>-Rubella Virus Genotypes Circulating in Mongolia</b> by R.Tuul , D.Otgonbayar, U.Naranchimeg, P.Nymadawa , W. Lim, G.Woo and Y. Jee
-Р.Түүл, Д.Отгонбаяр, У.Наранчимэг, П.Нямдаваа, С. Накажима <b>Монгол улсад анх удаа бүртгэгдсэн парвовирус B19-ийн халдвартын дэгдэлт</b>	22/43	<b>-Parvovirus B19 Infection Outbreak Registered for the First Time in Mongolia</b> by R.Tuul , D. Otgonbayar, U.Naranchimeg , P.Nymadawa and S.Nakajima
-Ш. Түмэнжаргал , А.Луковски, С.Геелрих, В.Стээры, П. Ваалдэн <b>Арьсны T-эст лимфомын үе дэхь хавдрын эсрэг T-эс ба T-эпитопийн өөрчлөлт</b>	22/44	<b>-Tumor-specific T cells and epitopes in cutaneous T cell lymphoma</b> by Sh.Tumenjargal , A.Lukowsky, S. Gellrich, W.Sterry , Peter Walden
Д.Сувд, Х.Цэрэнсүрэн, Д.Батжав, Х.Цацрал, Э.Золзаяа, С.Цоодол, А.Төмөрхүү,Т.Ариунаа, -Д.Отгонбаатар, Ж.Оюунбилэг <b>Вирусийн үйлчлэлээр сэдээгдсэн элэгний анхдагч өмөн үүсэх механизмыг судлах амьтны загвар</b>	23/44	<b>-Mongolian marmot as animal model for study molecular mechanisms of hepatocellular carcinoma</b> by D.Suvd, H.Tserensuren, D.Batjav, H.Tsatsral, E.Zolzaya, S.Tsoodol, L.Tumurkhuu, A.Ariunaa, D.Otgonbaatar and J.Oyunbileg
-Ж.Сэлэнгэ, И.Мөнхжаргал, А.Амбасэлмаа, Р.Түүл, П.Дэлгэрмаа, С.Амарзаяа, Ж.Байгалмаа, Б.Бямбажав <b>Өмнөговь аймагт 2011 онд бүртгэгдсэн гахай хавдрын дэгдэлтийн судалгаа, тархалтын эрсдлийн үнэлгээ</b>	24/45	<b>-Mumps outbreak in Umnugovi province in 2011 and mumps risk assessment</b> by J.Selenge, I.Munkhjarga, A.Ambaselmaa, R.Tuul, P.Delgermaa, S.Amarzaya, J.Baigelmaa and B.Byambajav

П.Сувд, З.Сайнжаргал, Т.Цэвээнсүрэн **Монгол улс дахь шочмог сүл саажилтын (ЦСС) лабораторийн тандалт судалгааны дүн 2009-2011**  
Ц. Цэвээнсүрэн, Ц. Энхмаа, З. Сайнжаргал, Б. Сайнчимэг, Д. Лхагвадолгор **Аденовирусийн халдвараар үүсгэгдсэн нүдний эмгэгийг лабораторийн аргаар оношилсон дүн**  
Д. Энхсайхан, Ч. Эрдэнэчимэг, Ж.Байгалмаа **Энгийн херпес вирус-1 ба 2 IgM-ийг ФХЭБҮ-аар тодорхойлсон дүн**

**Шинжилгээ судалгаа**

Ч.Майцэцэг, Н.Баясгалан, С.Цацрал, Б.Дармаа, П.Нямдаваа, **Мультиплекс бх-ПГҮ болон R-Mix хибрид эсийн өсгөвөрийн аргаар амьсгалын замын вирусүүдийг илрүүлсэн дүн**

**Товч мэдээ ажиглалт**

- Адууны томуугийн A(H3N8) вирусийн халдварт оношлогдов**
  - Хепацивирус нохойд амьсгалын замын шочмог халдварт сэдээдгийг илрүүлэв
  - Австралид Хендра вируст халдварт эрс нэмэгджээ

**Бодрол бясалгал**

- Гоц аюултай бүс

**Эрдэм шинжилгээний өгүүлэгийн англи товчлол**

24/45 **-Laboratory studies AFP surveillance in Mongolia 2009-2011** by P.Suvd, Z. Sainjargal and Ts Tseveensuren

25/46 **-Results of laboratory analysis of eye disease, infection adenovirus** by Ts. Tseveensuren, Ts. Enkhmaa, Z. Sainjargal, B. Sainchimeg and D. Lkhavgadolgor

25/46 **-Identification of HERPES SIMPLEX-1 and 2 IgM in patients using ELISA** by D. Enkhsaikhan, Ch. Erdenechimeg, J. Baigalmaa

**Original research articles**

47 **Comparison of detection of respiratory viruses by multiplex real-time PCR assay and by the r-mix ready cell culture** Ch.Maitsetseg, N.Bayasgalan, S.Tsatsral, B.Darma, P.Nymadawa

**Short communications and observations**

53 **-He equine influenza A(H3N8) virus infection registered in Mongolia**

53 **Hepatitis C virus is caused acute respiratory disease in dog**

**-Hendra virus infection increased in Australia**

**Contemplations and reflections**

**- Especially dangerous zone**

54

65 **English abstracts of the original research articles**

Редакцийн зурвас



1982 онд Оросын ургамал судлаач Д.И.Ивановский та м х и н ы н а в ч цоохортог өвчин үүсгэгч нь нянгын шүүрэнд шүүгэдгүй, гэрлийн микроскопт харагдадгүй бичил биетэн болох тухай анх бичиж, 1935 онд америкийн эрдэмтэн Wendell Stanley анх удаа вирусийг талст хэлбэрээр ялгаж авсанас хойш вирус судлалын шинжлэх

ухаан тасралтгүй ургашилж байгаа ч одоог хүртэл вируст халдварт нь анагаах ухааны анхаарал татсан тулгамдсан асуудлуудын нэг хэвээр байсаар байна. Вирус нь зөвхөн эсийн удамшилийн болон уураг нийлэгшүүлэгч аппаратын тусламжтайгаар л үржиж чаддаг эсийн бүтэц үйл ажиллагаа, ялангуяа удамшилын материал болох нуклейн хүчлийг “өөрчилдөг” тул зарим хавдар (элэгний, умайн хүзүүний г.м.) үүсэх нэг гол нөхцөл болдог байна. Иймээс ч сүүлийн үед вирусийн эсрэг зарим вакцинуудыг “хавдарын вакцин” гэж нэрлэх болжээ. Түүнчлэн цаг уурын өөрчлөлт, нийгэм биологийн олон хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн жилүүдэд шинэ болон сэргэж буй халдваруудын тоо эрс нэмэгдэж хүн амын эрүүл мэнд улс орны эдийн засагт асар их хохирол учруулж байгаа ба тэдгээрийн дийлэнх нь вирусийн халдварууд байгаа юм.

Монгол улсад гэхэд л зөвхөн сүүлийн 10 жилд халдварууд АЦХХШ (SARS), халдварт эритема, гар хөл амны өвчин, томуугийн A/H1N1 v –ийн, хачигт энцофалит зэрэг халдварууд шинээр бүртгэгдэн Шувууны томуу, Баруун нилийн халдварын голомт илрээд байна. Мөн ХДХВ/ДОХ, Вируст гепатит зэрэг бусад вирусээр үүсгэгдэг халдваруудын асуудлууд ч анхаарал татсан хэвээр байна. Вируст халдваруудтай тэмцэх онол арга зүйн үндэс нь вирус судлалын шинжлэх ухаан, манай вирус судлаачдын олон жилийн судалгааны үр дүн байдаг нь тодорхой.

Манай улсад анагаах ухааны вирус судлаал нь хэдийгээр 1921 оноос үндэс суурь нь тавигдсан гэж үздэг боловч, вирус судлалын лабораторийн алба

**Бид урагшилж байна**

үүсч хөгжсөн 1974 оноос эрчимтэй хөгжиж ирсэн. Чухам энэ үеэс буюу 1978 оноос манай эрдэмтэдийн судалгаа онол арга зүйн шинэ түвшинд гарч ирж “Хүн мал эмнэлгийн вирус судлалын тулгамдсан асуудлууд” –анхны онол практикийн бага хурлыг МЭЭШХ-тэй хамтран зохион байгуулж эхэлж байсан бол 5 дугаар хурлаас эхлэн анагаахын вирус судлаал бие даан зохион байгуулж ирсэн нь энэ салбар хэрхэн өргөжин хөгжиж байгаа илтгэх болов уу гэж бодож байна. Монголын анагаах ухааны вирус судлалын судалгааны цар хүрээ, арга зүйн жил ирэх тутам улам өргөжин боловсронгуй болж байгааг 2 жил тутам зохион байгуулагддаг ““Вирус судлалын тулгамдсан асуудлууд” онол практикийн бага хуралд хэлцэгдэж буй илтгэлүүд, оролцож буй судлаачдын бүрэлдэхүүнээс харж болно.

Анхны хуралд хэлэлцүүлж байсан илтгэлүүд шинжлэх ухааны тэр үеийн түвшинг илэрхийлж, Монголд элбэг тохиолдог вируст халдваруудын тархвар зүй, эмнэл зүйн судалгаанд ГТУ, ЦНУ, ФХЭБҮ зэрэг оншлогооны аргуудыг ашиглах, нэвтрүүлэх, боловсронгуй болгох болон вирусийг өсгөвөрлөх энгийн аргуудын судалгааны үр дүнгүүд хэлцэгдэж байсан бол сүүлийн үеийн судалгааны ажлуудын онол арга зүйн түвшин илт сайжирч шинэ түвшинд гарсан нь мэдрэгдэж байна.

1990 оны дунд үеэс вирусийн геномын судалгаанууд хийгдэж эхэлсэн ч голдуу гадаадын эрдэм шинжилгээний лабораториудад гүйцэтгэж байсан бол 2000-аад оны дунд үеэс Монголын анагаах ухааны вирус судлаалд полимеразын гинжин урвалын арга зэрэг молекул биологийн аргууд нэвтэрч одоо манай судлаачид вирусийг геном, нуклейн хүчлийн түвшинд бие даан судалгаа явуулж, вирусийн геномын дараалалыг тогтоож, хувирч мутацид орсон “шинэ” вирусийг илрүүлдэг болоод байгааг сүүлийн жилүүдийн хурлын илтгэлүүдээс харж болно.

Мөн манай хуралд сүүлийн жилүүдэд Япон, Герман, Франц, БНХАУ, ОХУ ын эрдэмтэд тогтмол оролцдог болсон нь энэ хурлын ач холбогдол нэр хүнд улам нэмэгдэж байгаагийн нэг жишээ мөн. Бид урагшилж байна.

**Сайн үйлс улам дэлгэрэх болтугай!**

**Монголын Вирус Судлалын Нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, ХӨСМС-ийн дэд эрхлэгч, ХӨСҮТ-ийн Нэгдсэн лабораторийн албаны дарга, Анагаах ухааны доктор М.Алтанхүү**

“ВИРУС СУДЛАЛЫН ТУЛГАМДСАН АСҮҮДЛҮҮД” Үндэсний арвангуравдугаар бага хурал, 2011 оны  
9 дүгээр сарын 9 Улаанбаатар хот

“ВИРУС СУДЛАЛЫН ТУЛГАМДСАН АСҮҮДЛҮҮД”  
Үндэсний арвангуравдугаар бага хурал  
2011 оны 9 дүгээр сарын 9 Улаанбаатар хот

## Хурал зохион байгуулах хороо

- Дарга:** **Д.Нямхүү,** Халдварт өвчин судлалын Үндэсний төвийн захирал, анагаах ухааны доктор
- Дэл дарга:** **Ж.Оюунбилэг,** НЭМХ-ийн захирал, Академич, биологийн шинжлэх ухааны доктор
- Д.Отгонбаатар,** БГХӨСҮТ ийн захирал, клиникийн профессор
- Нарийн бичгийн дарга:** **М.Алтанхүү** Монголын вирус судлалын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, ХӨСҮТ-ийн НЛА-ны дарга, анагаах ухааны доктор
- Гишүүд:** **Д.Абмэд,** ХӨСҮТ-ийн НЛА-ны Шимэгч судлалын лабораторийн эрхлэгч, биологийн ухааны доктор
- Л.Энхбаатар,** Халдварт өвчинтэй тэмцэх Монголын үндэсний холбооны гүйцэтгэх захирал, анагаах ухааны доктор
- Д.Энх-амгалан,** МАУА-ын референт
- Ш.Мягмарсүрэн,** ХӨСҮТ-ийн вирус судлалын тасгийн ХДХВ-ийн лабораторийн эмч, Анагаах ухааны магистр
- Ц.Наранзүл,** ХӨСҮТ-ийн НЛА-ны Вирус Судлалын лабораторийн эмч, Анагаах ухааны магистр

## Хурлын редакцийн зөвлөл

- Хариуцлагатай редактор П.Нямдаваа** Монголын вирус судлалын нийгэмлэгийн эрөнхийлөгч, Академич, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
- Нарийн бичгийн дарга Б.Дармаа,** ХӨСҮТ-ийн НЛА-ны вирус судлалын лабораторийн эрхлэгч, анагаах ухааны доктор
- Гишүүд:** **О.Баатархүү,** ЭМШУИС-ийн Халдварт өвчин судлалын тэнхимиийн багш, анагаах ухааны доктор
- Р.Оюунгэрэл,** ХӨСҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор
- П.Сувд,** НЭМХ-ийн Энтервирусийн лабораторийн эрхлэгч биологийн ухааны магистр
- Р.Түүл,** ХӨСҮТ-ийн НЛА-ны Улаан бурханы Үндэсний лабораторийн эрхлэгч, анагаах ухааны доктор
- Д.Энхсайхан,** ХӨСҮТ-ийн НЛА-ны вирус судлалын лабораторийн вирус судлаач, биологийн ухааны магистр
- Ч.Эрдэнэчимэг,** ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны тасгийн эрхлэгч, анагаах ухааны доктор
- Д.Цэрэнноров,** БГХӨСҮТ-ийн дэл захирал, биологийн ухааны доктор

**БАЙГУУЛЛАГУУДЫН НЭРИЙН ТОВЧЛОЛ БА ТАЙЛАЛ**

АУХ	Монгол улсын Анагаах ухааны хүрээлэн
БГХОСҮТ	Монгол улсын Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төв
ГАУТ	Монгол улс, "Гялс" Анагаах ухааны төв
MAYA	Монголын анагаах ухааны академи
MBCN	Монголын вирус судлалын нийгэмлэг
МИСМВХ	ХБНГҮ, Мюнхений их сургуулийн Молекул вирус судлалын хүрээлэн
МЭЭСХ	Монголын элэгний эмгэг судлалын холбоо
НЭМХ	Монгол улсын Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн
ОБОЭТ	Монгол улс, Орхон аймгийн бүсийн оношлогоо, эмчилгээний төв
СКХТ	АНУ, Сан Диего хот, Сидни Киммелийн Хавдар судлалын төв
ТИСВТ	Япон улсын Сендай хотын Тохоку их сургуулийн Вирус судлалын тэнхим
ТТБЭМ	Монгол улс, "Таны төлөө бид" эмэгтэйчүүдийн эмнэлэг
УМЭАЦТА	Монгол улсын Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори
ХААИС	Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургууль
ХӨСҮТ	Монгол улсын Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХСҮТ	Монгол улсын Хавдар судлалын үндэсний төв
ШУАБХ	Монгол улсын Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэн
ЭМШУИС	Монгол улсын Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

**“ВИРУС СУДЛАЛЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД”  
Үндэсний арвангуравдугаар бага хурлын хөтөлбөр**

08:30-09:00	Бүртгэл	
<b>I Хуралдаан: Модератор П.Нямдаваа, MBCH, Д.Нямхүү, XOCYT</b>		
09:00-09:10	Нээлт	Д.Нямхүү, XOCYT
09:10-09:40	Лекц 1: Монгол улсад ялгасан томуугийн вирусүүдийн хемагглотининий эволюци	П.Нямдаваа, MBCH
09:40-10:10	Лекц 2: Монгол улсад тархсан хепатитийн В вирусийн удамшлын хэвшинж ба элбэг тохиолдох мутаци	Ц.Оюунсүрэн, ШУАБХ
10:10-10:40	Лекц 3: Томуугийн эсрэг вакцин бүтээх шинэ зарчим	Д.Анхлан, МИСМВХ
10:40-11:30	Цайны завсарлага: Зураг авхуулах, Ханын илтгэлтэй танилцах	
11:30-12:15	Лекц 4: Томуугийн эсрэг эмийн бэлдмэл эрэлхийлэх шинэ чиглэл	С.Людвиг, МИСМВХ
12:45-13:00	Лекц 5: Хүний риновирус С ба энтеровирус 68 хэмээх хоёр пикорнавируст халдварын эпидемиологи	Х.Ошигтани, ТИСВТ
13:00-14:00	Үдийн хоол, Ханын илтгэлтэй танилцах	
<b>II Хуралдаан: Модератор Ж.Оюунбилэг, НЭМХ, Д.Отгонбаатар, БГХОСҮТ</b>		
14:00-14:15	Илтгэл 1: Монгол улсад ялгасан томуугийн цартахлын A(H1N1) вирусийн эмэнд тэсвэржилтийн судалгааны дүн	Ц.Наранзул, Б.Дармаа, Д.Энхсайхан, Ч.Майцэцэг, Г.Нямаа, Н.Баясгалан, П.Нямдаваа, XOCYT, МАУА

**ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН МОНГОЛЫН СЭТГҮҮЛ №4(41) 2011 ОН**

14:15-14:30	Илтгэл 2: Монгол улсад илрүүлсэн аденохирусийн ийлдээс судлалын хэвшинжийг нүклейн хүчлийн аргаар тодорхойлсон дүн	<u>Н.Баясгалан</u> , К.Тоома, Ц.Наранзул, Г.Нямаа, Б.Дармаа, С.Цогтсайхан, А.Сузуки, П.Нямдаваа, <i>ХӨСҮТ, ТИСВТ, ЭМШУИС, МАУА</i>
14:30-14:45	Илтгэл 3: Сорьц авалт болон томуугийн вирусийн илрэлтийн хамаарлыг судалсан дүн	<u>Э.Эрдэнэжаргал</u> , Л.Баяржаргал, М.Баттувшин, Б.Дармаа, <i>ОБОЭТ, ХӨСҮТ</i>
14:45-15:00	Ретровирусийн эсрэг эмчилгээний дүнг ХДХВ-ийн тоон хэмжээгэр хянах нь	<u>Б.Уянга</u> , Ш.Мягмарсүрэн, Ч.Байгальмаа, М.Алтанхүү, <i>ХӨСҮТ</i>
15:00-15:15	Хепатитийн В ба С вирусийн нүклейн хүчлийн тоон үзүүлэлт сорьцын хэлбэр болон урвалын нөхцлөөс шалтгаалах нь	<u>Н.Наранбат</u> , Г.Өнөрсайхан, П.Нямдаваа, <i>ГАУТ, МАУА</i>
15:15-15:30	В вируст хепатитийн онош, эмчилгээний Монгол улс дахь өнөөгийн байдал ба парадокс	<u>Ж.Амарсанаа</u> , П.Нацагням, Б.Саяболд, Н.Лхасүрэн, Ж.Чинбүрэн, О.Баатархүү, Б.Цацрагт-од, Л.Дашцэрэн, Д.Авирамд, <i>МЭЭСХ, АУХ, ХСҮТ, ЭМШУИС, ХӨСҮТ</i>
15:30-16:00	Цайны завсарлага, Ханын илтгэлтэй танилцах	

**III Хуралдаан : Модератор М.Алтанхүү, МВСН, П.Нямдаваа, МАУА**

16:00-16:15	Сэргтэнт эсийн наажилтын өөрчлөлтүүдийг томуугийн вирусийн хемагглютинин эскпресслэгч трансген хулганын загвар дээр судласан дүн	<u>Ш.Түмэнжаргал</u> , Ф.Линтон, <i>ХААИС, СКХТ</i>
16:15-16:30	Бог малын зарим лентивирусийн эсрэгбиесийн тархалтыг монгол малд судласан дүн	<u>С.Сугар</u> , Э.Базаррагчаа, Ш.Энхээ, <i>УМЭАЦТЛ</i>
16:30-16:45	Хепатитийн А вирусийн эсрэгтөрөгч илрүүлэх ФХҮ-ын оношуулж үйлдвэрлэх технологийн туршилтын дүн	<u>Л.Алтантуяа</u> , П.Сувд, Б.Энхтуяа, О.Дуламсүрэн, Б.Сайнчимэг, Ж.Оюунбилэг, Б.Энхжаргал, Ч.Цэнпил, С.Лхагва, <i>НЭМХ</i>
16:45-17:00	Хепатитийн А вирусийг хүний анхдагч эсийн өсгөвөрт өсгөвөрлөсөн дүн	<u>Э.Алтанцэцэг</u> , Ц.Цэвээнсүрэн, Э.Мөнгөнчөдөр, Д.Сувд, Р.Туул, Ч.Энхтайван, А.Ариунаа, Ж.Оюунбилэг, <i>НЭМХ, ХӨСҮТ, ТТБЭМ</i>
17:00-17:20	Асуулт хариулт, ярилцлага	
17:20-17:25	Хаалт	П.Нямдаваа
17:30-18:30	МВСН-ийн бүх гишүүдийн хурал	П.Нямдаваа

## ТОВЧЛОЛ

Нэг. АЕКЦҮҮД

### 1.1. Монгол улсад ялгасан томуугийн вирусүүдийн хемагглютитний гений эволюци

П.Нямдаваа

Монголын вирус судалалын нийгэмлэг

Томуугийн вирусийн гадаргуугийн гликопротеин сэргэн болох хемагглютинин нь вирусийн эмгэгтөрөх чадвар, эзэн организмын сонголтона чухал үүрэгтэй бөгөөд томуугийн эсрэгтөрөгчийн хурдан хувьслын шалтгаан болдог тул сүүлийн 20-30 жилд нэн эрчимтэй судлагдсан юм.

Монгол улсад ялгасан томуугийн вирусийн хемагглютитний генийн 150-аад нүклеотидын дараалал олон улсын нээлттэй мэдээллийн сан GenBank-д бүртгэгдсэн бөгөөд энэхүү лекцэнд тэдгээрийн эволюцийг био-информатикийн аргаар судласан дүнг танилцуулах юм.

Монголд ялгасан томуугийн вирусийн төлөөлөл омгуудын GenBank-д бүртгэгдсэн хемагглютитиний генийн нүклеотидын дарааллаас MEGA4 ба GENEOUS программын тусламжтайгаар филогенетикийн дендрограммыг PAUP сорилоор хийж, A(H1) (M.I.Nelson, C.Viboud, L.Simonsen et al., 2008), A(H3) (C.A.Russel, T.C.Jones, I.G.Barr et al., 2008) ба B (J.Shen et al., 2009), хемагглютитиний эволюцийн судалгааны дүнтэй жишжээ. Гарсан үр дүнг Монгол дахь томуугийн эпидемиологийн судалгаанд ашиглаж болох боломжийг мөн авч үзсэн болно.

### 1.2. Монголд тархсан хепатитийн В вирусийн удамшлын хэв шинж ба элбэг тохиолдох мутаци

Ц.Оюунсүрэн

ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн  
Молекул Биологийн Лаборатори

Хепатитийн В вирус(HBV)-т халдварт нь дэлхий дахинь эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг бөгөөд элэгний архаг үрэвсэл, хатуурал, элэгний өмөн үүсч, хөгжихөд хүргэдэг голлох хүчин зүйлийн нэг юм.

HBV-ийг одоогоор уг вирусийг 8 (A-H) генотип буюу удамшлын хэвшинж болгон ангиж байна. HBV-ийн удамшлын хэвшинжүүд нь Дэлхийн газарзүйн бүсүүдэд харилсан адилгүй тархсаны зэрэгцээ тэдгээрийн элэгний эмгэг үүсгэх эрсдэл нь ч өөр өөр гэж үздэг.

HBV нь Монголын хүн амын дунд өргөн тархсан вирусийн нэг юм. Монголд илрүүлсэн HBV-ийн нийт 2 мяняга гаруй дээжид геномынх нь болон, зарим генийнх нүклеотидын дараалал тогтоо судалгааг олон арга ашиглан хийж, үр дүнг нь нийтлүүлжээ. Эдгээр судалгаануудын дунд манай хүн амын дунд HBV-ийн D генотип зонхилон (93%-97%) тархсныг нь тогтоосон байна. Мөн Б.Цацралт-Од нар [2005] HBV-ийн A генотип монголчуудад тохиолдож байгааг тодорхойлсон бол, Азид ховор тохиолддог F генотипийг М.Такахаши нар [2004] илрүүлжээ. Д.Даваалхам нар [2007] HBV халдварт авсан 57 хүүхдийн 5.3%-д A генотип илрүүлсэн байна.

Эдүгээ HBV-ийн D генотипийг дотор нь D1-D4 гэсэн 4 субгенотип буюу дэд хэвшинж болгон ангиж байгаа. Монголын хүн амын дунд HBV-ийн D1 ба D3 субгенотип зонхилон тохиолдож буйн дотор D3 дэд хэвшинжийн тархалт 78.6% байна.

Мөн уг вирусийн хэд хэдэн генотипийн давхар халдварт авах явдал элбэг тохиолдох ба тэдгээрийн 10% орчимд рекомбинант омог олддог. Манай хүүхдүүдийн дунд HBV A/C рекомбинант генотип, насанд хүрэгсэдийн дунд C/D рекомбинант генотип омгуудыг илрүүлжээ. Генотип хооронд болон субгенотипүүдийн хооронда явагдах рекомбинаци нь вирусийн генетикийн шинэ хувилбарыг бий болгож, Дэлхий дахинда тархсан HBV-ийн генетик олонлогийг улам баяжуулж байдаг.

Генетикийн хувьд тогтвортой вирусийн популяци үүсчбуй болоход рекомбинацийнүзэгдлээсгадна HBV-ийн бүх генотипүүдэд тохиолдох мутаци ба мутантын шалгарал чухал байр эзэнтэй. Вакцин болон эмчилгээ, эмийн бодисуудын үйлчлэл, дархалын урвал зэрэгээс “дайжих” замаар төрөл бүрийн мутантууд үүсдэг. Зарим орны хүн амын дунд HBV-ийн гадаргуугийн (S) ургийн генийн мутаци оношлогоо, эмчилгээнг хүндрүүлдэг тухай бичигдсэн байдаг. Харин манай хүүхдүүдийн 30%-д S генийн мутаци илэрсэн ч энэ нь дархлаажуултын үр дүнд онцын нөлөөгүй байна. Харин HBV-ийн зохицуулагч хэсгийн, тухайлбал, цөмийн суурь промотер (BCP: basal core promoter) ба цөмийн уураг хариуцсан генийн мутаци нь HBeAg ургийн нийлэгжлийг багасгах, саатуулахаас гадна элэгний өвчний явцад ихээхэн нөлөөтэй байдаг байна.

HBV-ийн мутацийн элэгний анхдагч өмөн (ЭАӨ) үүсэхэд хэрхэн нөлөөтэйг тогтоохын тулд BCP ба цөм генийн мутацийн судалгаа хийсэн. Судалгааны дунд геномын A1752C/T1753V гэсэн нүклеотидын дан болон давхар мутаци нь элэгний архаг үрэвсэл (ЭАҮ) оноштой өвчтөний 20.0%-д тодорхойлогдсон бол ЭАӨ бүхий бүлгийн 52.2%-д илэрсэн. HBeAg эерэг дээжтэй харьцуулахад сөрөг дээжинд A1896 болон T1764/G1766 мутацийн тохиолдол их байв. Харин A1762T/G1764A-ийн мутацийн давтамж ЭАҮ ба ЭАӨ

бүлэгт ижил бага (15%) байсан хэдий ч вирус, ДНХ –ийн агууламж ихтэй ( $>5 \log \text{copies/ml}$ ) ЭАΘ оноштой өвчтөний 75.0%-д уг мутаци тодорхойлогдсон. Дээрх мутаци HBV тээгчдийн 4.2%-д, харин ЭАΘ бүлгийн 34% илэрсэн нь A1762T/G1764A болон A1752C/T1753V мутаци элэгний өвчин даамжирахад нөлөөтэй байж болзошгүй харууллаа.

Дээрхи судалгаануудаас үзэхэд Монголын хүн амын дотор HBV-ийн удамшлын нэг хэвшинж (D) голлон тархсан байна. ВСР ба цөмийн гений мутаци нь HBV хамааралт ЭАΘ үүсэхэд нөлөөтэй байж болзошгүй бөгөөд эдгээр мутацийг HBV-ийн D генотипийн халдварт авагсадын эмгэг архагших болон өвчин даамжрах явцыг таамаглах молекул маркер болгон ашиглах боломжтой гэж үзнэ.

### **1.3. Томуугийн эсрэг вакцин бүтээх шинэ зарчим**

Д.Анхлан

Мюнстерийн Их сургуулийн Молекул вирус судалын хүрээлэн, ХБНГУ

Вакцинжуулалт нь дэлхий дахинд томуугийн вирусийн халдвартай тэмцэх, сэргийлэх шилдэг арга хэрэглэл болсоор байна. Нэн саяхан гэхэд дэлхийн эрүүл мэндийн хамтын нийгэмлэг 2009 онд „гахайн томуу“ гэж нэрлэгдсэн томуугийн цартахлын эсрэг вакциныг бүтээж үйлдвэрлэсэн билээ. Энэ вакциныг амжилттай хэрэглэсний ачаар уг цартахлыг бүрэн хяналтандaa авч, зогсоож чадсан. Томуугийн A вирусийн удамшлын төрх асар их хувисамтгайн улмаас дараагын цартахал хэзээ гарахыг урьдчилан мэдэх боломжгүй юм. Бид томуугийн WSN/33 вирусийн NP генд амин хүчлийн өөрчлөлтгүй цэгчилсэн мутаци үүсгэн, эмгэгөрөх чадваргүй вакцины омгыг урвуу генетикийн аргаар бүтээсэн. Энэхүү рекомбинант эмгэгтөрөгч бус омгоор вакцинжуулсан туршлагын хулганыг зэрлэг омгийн WSN/33 вирусийн үхүүлэх тунгаар халдаахад өвчлөхгүй дархлаатай байлаа. Томуугийн вирусийн NP ген дээр хийгдсэн туршилтын үр дүн нь томуугийн эсрэг амьд, судруулсан вакцин бүтээх цоо шинэ зарчим нээж өгч байгаа төдийгүй, энэ технологийг сегмэнтэт геномтой бусад бүх вирусийн вакцин бүтээхэд ашиглаж болох юм. Мөн энэ лекцэнд одоогийн зөвшөөрөгдөн хэрэглэгдэж байгаа томуугийн вакцинаас гадна улам илүү найдвартай, үр дүн сайтай вакцин нэн шуурхай бүтээн үйлдвэрлэх бололцоог тавьж буй урвуу генетикийн шинэ технологийн давуу талыг танилцуулахыг зорилоо.

### **1.4. Томуугийн эсрэг эмийн бэлдмэл эрэлхийлэх шинэ чиглэл**

С.Людвиг,  
Мюнстерийн их сургуулийн Молекул вирус судалын хүрээлэн, ХБНГУ

Томуу өвчин Дэлхий нийтийг хамарсан цартахал үүсгэдэг халдвартын нэг байсаар байна. Хүнтөрөлхтөн одоогоор энэ халдвартын эсрэг томуугийн вирусийн нейраминидазын саатуулуур оселтамиивир, занамиивир, M2-ионы сувгийн саатуулуур амантадин, римантадин гэсэн дөрөвхөн өвөрмөц эмчилгээний бэлдмэлтэй байна. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд эдгээр эмийн бэлдмэлд тэсвэржсэн омог бий болон тархаж буй мэдээлэл ихэсч байгаа билээ. Иймээс шинээр тархан дэлгэрч болзошгүй томуугийн тахалт тархалтын үед хэрэглэх бололцоотой шинэ эмийн бэлдмэл хайх нь томуу судлаачдын нэгэн тулгамдсан зорилт юм. Томуугийн ямар шинэ омог цартахал үүсгэн тархаж болохыг урьдчилан тааварлах боломжгүй тул томуугийн вирусийг эсрэгтөрөгчийн төрхөөс нь хамааралгүйгээр саатуулж чадах эмийн бэлдмэл хайх нь одоо чухал болоод байна.

Томуугийн вирус нь эсэд нэвтрэн орсныхоо дараа эсийн дохиоллын хэдхэдэн тогтолцоог идэвхижүүлдэг. Эсийн эдгээр дохиоллын тогтолцоонууд нь нян, вирусийн эсрэг эсийн төрөлх (innate) дархлаа ажиллаж эхэлсний илрэл гэж үздэг. Томуугийн вирус төрөлх дархлааны энэ механизмыг өөрийн репродукцид ашиглах хандлагатай тул эсийн доторхи дохиоллын эдгээр тогтолцоо нь шууд вирус дээр үйлчлэлгүйгээр вирусийн репродукцийг саатуулж болох эмийн бэлдмэлийн бай болгон ашиглаж болох шинэ бололцоо нээж байгаа юм.

Сүүлийн хэдэн жил манай судлагааны баг эсийн дохиоллын зарим тогтолцоонд нөлөөлөх замаар томуугийн эсрэг шинэ бэлдмэл хайх судалгаа хийж байна. Тухайлбал, вирусийн рибонуклеопротеин эсээс экспортлогдох процессийг зохицуулдаг митогенээр идэвхижигч, микротиобултой холбоот протеин киназийн хэлхээг (MAPK or microtubule-associated protein kinase cascade), болон эсийн апоптозын зохицуулалтанд оролцдог. В лимфоцит идэвхижүүлэгч цөмийн каппа факторын хэлхээг (NF-каппаB pathway) тасалдуулах нь томуугийн вирусийн репродукцийг эс хордуулах үйлчлэлгүйгээр саатуулдаг болохыг бид судлан тогтоогоод байна. Энэ саатуулах үйлдэл нь томуугийн вирусийн тэсвэржсэн омог үүсгэх хандлагагүй нь судлаачдын анхаарлыг ихээхэн татаж буй болно.

Бид ДЭМБ-ын зөвлөмжийг удирдлага болгон дээрхи үйлдэл бүхий ургамлын гаралтай химиийн нэгдлүүд хайхад ихээхэн анхаарч байна. Энэ лекцэнд

томуугийн эсрэг эмийн бэлдмэл хайх дээрхи шинэ чиглэлүүдийн тухай шүүмжлэлт тоймыг тусгах юм.

## 1.5. Хүний риновирүс С ба энтеровирүс 68 хэмээх хоёр пикорнавирүст халдвартын эпидемиологи

X.Ошитани

Япон улс, Сендай хотын Тохоку их сургуулийн  
Анагаах ухааны сургуулийн Вирүс судалын тэнхим

Амьсгалын замын цочмог халдварт (АЗЦХ) Дэлхий нийтийн нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал хэвээр байсаар байна. АЗЦХ-ын судалгаанд молекул биологийн арга техник эрчимтэй нэвтэрч байгаа нь АЗЦХ сэдээгч шинэ вирусүүд нээх буюу өмнө нь мэдэгдэж байсан үүсгэгчийн шинэ төрхийг илрүүлэхэд хүргэж байна. Манай судалгааны бағ сүүлийн жилүүдэд Филиппин улсын Лейте хот дахь Зүүн Визавасын Бүсийн анагаах ухааны төвийг түшиглэн амьсгалын замын хүндэрсэн халдварт(A3xX - sARI: severe acute respiratory infection)-ын этиологи, эпидемиологийг судлаж байгаа бөгөөд энэ лекцэнд уг судалгааны зарим үр дүнг нэгтгэн илтгэх юм.

Хүний риновирүс С (HRV-C) бол риновирүсийн шинэ төрөл зүйл бөгөөд АЗЦХ-ийн үүсэл гүйцэтгэх үүрэг нь бүрэн тодроогүй байгаа болно. Бид 2008 оны 5 дугаар сараас 2009 оны 5 дугаар сарын хооронда A3xX оноштой 816 өвчтөнөөс хамар-залгиурын арчдас цуглувулж, ПГҮ-аар HRV илрүүлэх судалгаа хийхэд 243(29.8%) сорьцонад риновирүс илэрсэн бөгөөд нүклеотидын дарааллаараа өөр хоорондоо ихээхэн ялгаатай омгууд олдсон юм. Мөн цусны 30 сорьцонад HRV-ийн эсрэгбие ихэссэн байлаа. Эсрэгбие ээрэг сорьцны 3% (4/131) нь HRV-A, 0% (0/25) нь HRV-B, 31% (26/83) нь HRV-C ээрэг байв. Энэ нь HRV-C илүү эмгэгтөрөх чадавхитай байж болзошгүйг баталж байгаа юм.

Энтеровирүс 68 (EV68) анх 1962 онд АЗЦХ бүхий хүүхдээс илэрсэн байна. Хэдүйгээр энэ вирусийг пикорнавирүсийн овгийн энтеровирүс төрөлд хамааруулсан боловч хүчил тэсвэртэй зэрэг зарим төрхөөрөө риновирүстэй төстэй болно. Дээрхи судалгаанд хамрагдсан HRV-C халдварт оношлогдсон өвчтөний 21-д нь EV68 давхар оношлогдсоны 2 нь нас барсан юм. EV68 нь ховор тохиолдох энтеровирүст тооцогдог бөгөөд бидний энэ судалгаа нь уг халдвартын хамгийн олон тохиолдол бүхий дэгдэлтийн анхны бичиглэл болсон билээ. Энэ судалгааны үр дүн нийтлэгдсэний дараа АНУ, Япон, Нидерландад EV68 халдвартын томоохон дэгдэлтүүдийг илрүүлсэн юм.

## ХОЁР. АМАН ИЛТГЭЛҮҮД

### 2.1. Монгол улсад ялгасан томуугийн цартахлын A(H1N1) вирусийн эмэндэгдэлтийн судалгааны дүн

Ш.Наранзүй<sup>1</sup>, Б.Дармаа<sup>1</sup>, Д.Энхсайхан<sup>1</sup>, Ч.Майшээцэг<sup>1</sup>,

Г.Нямаа<sup>1</sup>, Н.Баясгалан<sup>1</sup>, П.Нямдаваа<sup>1,2</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв,

<sup>2</sup>Монголын Анагаах Ухааны Академи

Томуугийн вирусийн хими заслын бэлдмэлд тэсвэржилтийг судлах нь уг халдвартыг хянах, сэргийлэх, эмчилэхэд шийдвэрлэх нөлөөтэй юм. Бид Монгол улсад идэвхитэй эргэлтэнд байгаа томуугийн цартахлын вирусийн эмийн бодист тэсвэржилтийг тандан судлах зорилгоор 2009-2011 онд ялгасан цартахлын A(H1N1) вирусийн 292 омгийн нейраминидазын саатуулуур (HAC) (оселтамивир)-т, 7 омгийн M2 уургийн саатуулуур (амантадин) –т тэсвэржилтийг судаллаа

HAC-д тэсвэржилтийн тоон үзүүлэлтийг NA-Star (Applied Biosystems, Foster City, CA) цомог, Hoffman-La Roche Ltd компаниас авсан оселтамивир карбоксилат, ДЭМБ-ын Томуугийн Хамтын Ажиллагааны Төв (TXAT) өөс ирүүлсэн HAC-д мэдрэг болон тэсвэржсэн хяналтын омгуудыг ашиглан Veritas Microplate Luminometer үншигч машинаар, HAC-д тэсвэржсэн H274Y мутац илрүүлэх шинжилгээг нэг шатлалт бх-ҮТ-ПГҮ-аар хийв. Нейраминидаз(NA) болон M2 генийн нүклеотидын дараалал тогтоох шинжилгээг Applied Bio system Big-Dye TerminatorV3.1 cycle Sequencing цомог, ДЭМБ-ын TXAT-ийн праймеруудыг ашиглан ABI 3130 x1 Genetic analyzer-аар хийж, үр дүнгийн боловсруулалтыг MEGA 5.01 программаар гүйштгэлээ.

HAC-т тэсвэржилтийг тодорхойлсон 292 омгоос нэг омог (A/Dundgovi/381/2010(H1N1)v)-т вирусийн NA-ын идэвхийг 50% (IC50) саатуулах эмийн төвшрүүлэг 65.6 nM (мэдрэг хяналт 31.6 nM байхад) илэрч, энэ омогт бх-ҮТ-ПГҮ болон NA генийн нүклеотидын дараалал тогтоох шинжилгээгээр NA генийн 274 дүгээр байрлалд гистадин тирозинаар (H274Y) солигдсон мутаци тодорхойлогдсон нь оселтамивирт тэсвэржсэн болохыг баталж байна (ген банкны дугаар: ADM33443). Энэ омгийн NA генийн 106, 248, 274 дугаар амин хүчлийн байрлалд мөн мутаци тодорхойлогдсон болно.

M2 генийн нүклеотидын дараалал тогтоох шинжилгээ хийсэн 7 омогийн (Ген банкны дугаар: CY053364, CY053365, CY054547, CY054549, CY055171, CY065990, CY065998) 6-д нь 31 дүгээр амин хүчил серин аспаргинаар солигдсон [S31N]) мутаци, харин нэг омогт 31 дүгээр амин хүчил серин аспартатаар солигдсон [S31D]) мутаци илэрч буга амантадинд тэсвэржсэн байна.

## 2.2. Монголд илрүүлсэн адено-вирусийн ийлдэс судалалын хэвшинжийг нүклейн хүчлийн аргаар тодорхойлсон дүн

Н.Баясгалан<sup>1,3</sup>, К.Тоома<sup>2</sup>, Ц.Наранзүл<sup>1</sup>,  
Г.Нямаа<sup>1</sup>, Б.Дармаа<sup>1</sup>, С.Цогтсайхан<sup>3</sup>,

Х.Ошишани<sup>2</sup>, П.Нямдаваа<sup>1,4</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судалалын Үндэсний Төв,

<sup>2</sup>Япон улсын Сендай хот Тохоку их сургууль,

<sup>3</sup>Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

<sup>4</sup>Монголын Анаагаах Ухааны Академи

Хүний адено-вирус (HAdV's) бол хос утаслаг ДНХ агуулсан, бүрхүүлгүй вирус бөгөөд генетикийн болон эсрэгтөрөгчийн төрхөөрөө 7 бүлэг, 52 ийлдэс судалалын хэвшинжид хуваагддаг. Сүүлийн жилүүдэд адено-вирусийн зарим шинэ дэд хэв шинжүүдийг тодорхойлсон байна [H. Ishiko et al., 2008, CM. Robinson et al., 2011, MP. Walsh et al., 2009, MP. Walsh et al., 2010.]. HAdV нь амьсгалын замын болон хodoод-гэдэсний цочмог үрэвсэлт өвчин, коньюнктивит үүсгэдэг

Манай судлаачдын судалгаагаар ТТӨ-ний сэжигтэй өвчтөнүүдээс цуглуулсан хамар-залгиурын арчдасанд иммунфлюоресцент микроскоп(ИФМ)-ын шууд аргаар 5.7%-д [П.Нямдаваа ба бусад, 1988], R-Mix(DHI) хибрид эсийн өсгөвөр ашигласан ИФМ-ын шууд аргаар 9.6%-д [С.Цацрал ба бусад, 2009], FTD компанийн оношлуур ашигласан, олон сорьцот, бодит хугацааны ПГҮ(multiplex, real-time PCR)-аар 5.4%-д [С.Цацрал ба бусад, 2011] адено-вирус илэрсэн байна.

Бид Монгол улсын хүн амын дунд амьсгалын замын цочмог халдварт(АЗЦХ), коньюнктивит үүсгэн идэвхитэй эргэлтэнд байгаа хүний адено-вирусийн дэд хэвшинжүүдийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийллээ.

R-Mix (DHI, USA) хибрид эсийн өсгөвөрт (2010 онд XOCYT-ийн Вирус судалалын лабораториид нийт n=1288; зөрөг n=20) ИФМ-ын шууд аргаар адено-вирус эерэг тодорхойлогдсон 20 сорьцонд вирусийн генетик хэвшинжийг тодорхойлов. Хамар залгиурын болон нүдний арчдас сорьцноос QIAamp DNA mini Kit (QIAGEN) цомог ашиглан вирусийн ДНХ-ийг ялгаж, QIAGEN one step PCR цомог, Primus-96 plus термосайклер ашиглан ПГҮ, Applied Bio system BigDye Terminator V3.1 cycle Sequencing цомог, ABI 3130 x1 Genetic analyzer ашиглан гексон генийн нүклеотидын дараалал тогтоох шинжилгээг тус тус хийж, үр дүнгийн боловсруулалтыг MEGA 5.01 программаар хийллээ. Сорьцны 80% нь хамар залгиурын арчдас 20% нь нүдний арчдас байлаа. Шинжилгээгээр адено-вирусийн 3 бүлэгт хамаарах 7 дэд хэвшинжийг илрүүлснээс 6(30%) нь HAdV B7,

5(25%) нь HAdV B3, 4(20%) нь HAdV D8, 2(10%) нь HAdV C1, 1(5%) нь HAdV C5, 1(5%) нь HAdV C2, 1(5%) нь HAdV C6 хэвшинжид тус тус хамаарч байлаа. Эмнэлзүйн шинж тэмдэгээр нь авч үзвэл адено-вирусийн хүний дэд хэвшинжүүд (HAdV B7, HAdV B3, HAdV C1, HAdV C2, HAdV C5, HAdV C6) нь АЗЦХ-ыг сэдээсэн байна. Монголын хүний амын дунд орчиж байгаа адено-вирусийн ийлдэс судалалын тархалтын бүрэн дүр зургийг гаргахын тулд нэмэлт судалгаа шаардлагатай.

## 2.3. Сорьц авалт болон томуугийн вирусийн илрэлтийн хамаарлыг судалсан дүн

Э.Эрдэнэжаргал<sup>1</sup>, Л.Баяржаргал<sup>1</sup>, М.Баттувшин<sup>1</sup>,  
Б.Дармаа<sup>2</sup>

<sup>1</sup>Орхон аймгийн Бүсийн Оношлогоо Эмчилгээний Төвийн Вирус Судалалын Лаборатори,

<sup>2</sup>Халдварт Өвчин Судалалын Үндэсний Төв

Лабораторийн шинжилгээний үнэн зөв хариу нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тархвар судал, нийгмийн эрүүл мэндийн олон үйл ажиллагаанд шийдвэрлэх нөлөөтэй. Шинжилгээний үр дүн нь мэргэжилтний арга техник, ажлын гүйцэтгэлээс гадна сорьцын төрөл, түүнийг зөв цуглуулах, хадгалах, зөөвөрлөх ажиллагаанаас ихээхэн хамаардаг бөгөөд энэ талын судалгаа мэдээлэл манай улсын лабораторийн практикт ховор байна. 2010-2011 томуугийн улиралд Орхон аймгийн вирус судалалын лабораториид шинжилсэн сорьцыг өвчин эхэлснээс хойш цуглуулсан хугацаа, сорьцийн төрөл зэрэг үзүүлэлтийг вирус илрэлтийн харьцуулан судлах зорилго тавилаа.

Энэ судалгаанд Орхон аймгийн вирус судалалын лабораториид 2010 оны 11 сараас 2011 оны 3 дугаар сард тус аймгийн өрхийн эмнэлгүүд болон нэгдсэн эмнэлгээс хүлээж авсан 429 сорьцыг хамрууллаа

Сорьцоос вирусийн PHX-g Солонгос улсын Bioneer компаны RNA ялгах цомгоор ялгаж, томуугийн вирусийн дэд хэвшинж илрүүлэх шинжилгээг бодит хугацааны полимеразийн гинжин урвал(бхПГҮ)аар AccuPower Real time PCR цомог ашиглан Bioneer, EX-ICYCLER 96 машин дээр хийж гүйцэтгэлээ.

Судалгааны үр дүнда томуу гэсэн оноштой 186 сорьцноос 25(13.4%)-д, ТТӨ гэсэн оноштой 200 сорьцноос 17(8.5%)-д, АЗХХ оноштой 22 сорьцноос зөрөг хариу байхгүй, бусад гэсэн оноштой 14 сорьцноос 2(14.2%)-д, онош тавиагүй 7 сорьцноос 1(14.3%)-д нь томуугийн вирус тодорхойлогдов.

Өвчин эхэлсэн хугацаа болон сорьц авсан хугацааг харьцуулж үзэхэд өвчин эхэлсэнээс 1-3 хоногийн дотор цуглуулсан 321 сорьцны 40(12.5%) нь зөрөг, 3-7 хоногт цуглуулсан 68 сорьцны 4(5.9%) нь зөрөг, 7

дээш хоногийн дараа цуглуулсан 22 сорынны 1 (4.5%)-д нь эерэг хариу гарсан байна.

Сорын төрөл болон вирус илрэлтийн хувийг харьцуулахад хамрын арчдас авсан 338 сорынноос 36(10.6%) эерэг, хоолойн арчдас авсан 91 сорынноос 9(9.8%) эерэг гарсан байна..

Томуугийн вирус илрүүлэх шинжилгээний дүн нь өвчин эхэлснээс хойш сорьцийг цуглуулсан хугацаа болон сорьцийн төрлөөс хамааралтай байна.

## **2.4. Ретровирусийн эсрэг эмчилгээний үр дүнг ХДХВ-ийн тоон хэмжээгээр хянах нь**

*Б.Уянга, Ш.Мягмарсүрэн, Ч.Байгалмаа, М.Алтанхүү  
Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв*

Монгол улсад хүний дархлал хомсдлын вирус (ХДХВ)-ийн ачаалал тодорхойлох шинжилгээг ХДХВ-ийн халдвартай хүмүүст 2009 оноос хийж эхэлсэн. ХДХВ-ийн ачаалал хэмжих УТ-ПГҮ, branched DNA, NASBA аргуудыг голчлон ашигладаг бөгөөд манай улсад NASBA аргыг ашиглаж байна. ХДХВ-ийн ачааллыг хэмжих нь өвчний явц, эмчилгээг хянах үр дүнтэй юм.

Бид ХДХВ-ийн халдвартай монгол хүмүүст ХДХВ-ийн ачааллыг тодорхойлж, эмчилгээний үр дүнд вирусийн ачаалал хир зэрэг буурч байгааг тогтоох зорилгоор энэ судалгааг хийлээ.

2009-2011 онуудад Biomerieux компанийн NucliSens EasyQ HIV-1 QT оношуулур ашиглан NASBA аргаар нийт 77 хүний вирусийн ачааллын тоон хэмжээг тодорхойллоо. Эдгээр хүмүүсээс ретровирусийн эсрэг эмчилгээ (РВЭЭ)-нд хамрагдсан 15 хүнд эмчилгээний өмнө болон эмчилгээ хийгдэж эхэлснээс хойш 3-6 сарын дараа вирусийн ачааллыг тодорхойлсон. Олон улсын хэмжээнд вирусийн ачааллын түвшинг маш бага (target not detected /<20 хуулбар/мл - 400 хуулбар/мл), бага (10 000-80 000 хуулбар/мл), өндөр (>100 000 хуулбар/мл) гэж ангилан үздэг.

Бидний судалгаагаар ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн цусанд вирусийн ачаалал нь өвчний үе шат, тухайн хүний дархлалын байдлаас хамаарч янз бүр байсан ба судалгаанд хамрагдсан 77 хүнд ХДХВ-1-ийн ачаалал дунджаар 118 600 хуулбар/мл байв.

РВЭЭ-нд хамрагдсан 15 (19.5%) хүнд эмчилгээний өмнө ХДХВ-1-ийн ачааллын тоон хэмжээ дунджаар 426 926 хуулбар/мл байсан ба вирусийн ачааллын түвшингээр ангилвал: ХДХВ-1-ийн ачаалал "маш бага"-тай хүн байхгүй, 5 (33.3%) хүнд вирусийн ачаалал бага, 10 (66.6%) хүнд вирусийн ачаалал өндөр байв.

Харин РВЭЭ-ний дараа ХДХВ-1-ийн ачааллын дундаж тоон хэмжээ 54 722 хуулбар/мл болж багассан

ба дээрх ангилаар бүлэглэж үзвэл: 11 (73.4%) хүнд маш бага 3 (20%) хүнд, - бага 1 (6.6%) хүнд өндөр хэвээр байлаа.

Үүнээс үзэхэд РВЭЭ эхэлснээс хойш 3-6 сарын дараа вирусийн ачааллын тоон хэмжээ дунджаар 8 дахин буурсан байв.

NASBA нь ХДХВ-1-ийн ачаалал хэмжих нь эмчилгээний үр дүнг хянах, эмчилгээний тактикийг боловсруулахад үр дүнтэй, тохиромжтой арга гэдэг нь харагдаж байна.

РВЭЭ нь ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн цусандах ХДХВ-ийн ачааллыг үлэмж хэмжээгээр бууруулж үр дүнтэй болох нь харагдаж байна.

## **2.5. Хепатитийн В ба С вирусийн нуклейн хүчлийн тоон үзүүлэлт сорыцын хэлбэр болон урвалын нөхцлөөс шалтгаалах нь**

*Н.Наранбат, Г.Өнөрсайхан, П.Нямдаваа  
"Гялс" Анаагаах ухааны төв, ХХК, Монголын анаагаах  
ухааны академи*

Хепатитийн В (HBV) болон С (HCV) вируст халдвартын эмчилгээний дэглэм сонгох, өвчний тавилангтаамаглахад цусандах эдгээр вирусийн тоон хэмжээг тодорхойлох нь зарчмын ач холбогдолтой гэж судлаачид үзэж буй бөгөөд, хөгжингүй орнуудад бол нийтээр баримтлах зөвшөлцсөн удирдамж (consensus guideline) боловсруулан хэрэглэдэг байна [A.S.Lok and B.J.McMahon, 2007; M.G.Ghany et al., 2009;].

Манай орны хувьд хепатитын вирус тоолох шинжилгээ эхлэл шатнаа яваа, лабораторийн болон эмчилгээний зөвшөлцсөн удирдамж байхгүй байгаа нь шинжилгээний дүнг жишигэхд ихээхэн бэрхшээл учруулж, заримдаа өвчтөнийг чирэгдүүлэхэд хүрч байна. "Гялс" Анаагаах ухааны төв (ГАУТ)-д 2009 оноос эхлэн HBV болон HCV-ийн нуклейн хүчил (HX)-ийн тоон үзүүлэлтийг шинжилгээнд сорыцын төрөл, болон хадгалах хугацаа, нуклейн хүчил ялгах арга шинжилгээний эцсийн үр дүн ямар нөлөөтэйг судлах зорилт тавьсан болно.

Бид судалгаандаа түргэвчилсэн иммуунхроматографын шинжилгээний "Acon", USA оношуулураар HBsAg эрэг гарсан 41 шинжлүүлэгч, мөн пүүсийн оношуулураар anti-HCV эрэг гарсан 44 шинжлүүлэгчийн сорьш авч бүхэл цус, сийвэн, ийлдээс HX-ийг БНСҮ-ын Bioneer компаниы ExiPrep 16 (автомат) арга, изопропанолоор тундасжуулах гар аргаар ялган авч, Bioneer Exicycler 96 багаж, уг пүүсийн оношуулур ашиглан бх-ПГҮ-аар HBV болон HCV-ийн нуклейн хүчлийн тоон үзүүлэлтийг тодорхойлох шинжилгээ хийж, харьцуулсан юм.

Бүхэл цусанд хийсэн шинжилгээгээр HBV-ийн ДНХ эерэг үзүүлэлт ийлдэс болон сийвэнд хийснээс 2.2-4.5 дахин цөөн, харин HCV-ийн РНХ эерэг үзүүлэлт сийвэнгийнхтэй ойролцоо, ийлдэсэнд хийснээс 3.3-3.4 дахин бага байгаа нь HBV-ийн ДНХ илрүүлэхэд ийлдэс буюу сийвэнг, HCV-ийн РНХ илрүүлэхэд ийлдсийг ашиглах нь зүйтэй болохыг харуулсан болно. Гар болон автомат аргаар ялгасан НХ-ийн хэмжээ нь хоёр вирусийн аль алинд 2.2%-16% зөрөөтэй гарч байсан боловч зөрөө нь статистикийн хувьд үнэн магадтай байж чадсангүй. Харин сорьцын вирусийн НХ-ийн тоон хэмжээ бага байвал автомат аргаар НХ илрүүлэх нь статистик магадлалтай илүү байлаа.

Сорьц хадгалалтын хугацаа вирусийн НХ илрүүлэхэд нөлөөлж буй эсэхийг судлахдаа бид сийвэн ялгасан сорьц авч: 1) сийвэн хэвээр нь, 2) сийвэнгээс ялгасан ялгасан НХ-ийг 1-3 долоо хоног -70° С-д хадгалж НХ-ийн тоон үзүүлэлт өөрчлөгдөх эсэхэд ажиглалт хийлээ. Сийвэн болон ялгасан НХ хоёр хоёулаа -70° С-д нэн бага өөрчлөлттэй хадгалагдаж байсан бөгөөд вирусийн НХ-ийн тоо эхнээсээ цөөн байсан бол хадгалагдах явцад багасах нь илүүтэй байдаг бололтой.

Мөн лабораториуд шинжилгээний хариуг copies/ml(dl, l) болон IU/ml(dl, l)-ээр илэрхийлдэг, багаж бүрт copies/ml(dl, l)-ийг IU/ml(dl, l)-д шилжүүлэх өөр өөр коэффициент хэрэглэдэг нь зарим тохиолдолд өвчтөнүүд төдийгүй, эмч нар төөрөлдөх шалтаг болдог ажээ.

Иймээс HBV болон HCV-ийн нүклейн хүчлийн тоон үзүүлэлтийн шинжилгээ хийж байгаа лабораториуд болон эмчлэгч эмч нар хамтран манай нөхцөлд тохирсон зөшилцөн удирдамж боловсруулах нэн шаардлагатай болжээ хэмээн бид үзэж байна.

## 2.6. Вируст хепатитийн онош, эмчилгээний Монгол улс дахь өнөөгийн байдал ба парадокс

Ж.Амарсанaa<sup>1,2</sup>, П.Нацагням<sup>1</sup>, Б.Саяболд<sup>1</sup>, Н.Лхасүрэн<sup>1</sup>, Дэлгэрзаяа<sup>1</sup>, Ж.Чинбүрэн<sup>1,3</sup>, О.Баатархүү<sup>1,4</sup>, Б.Цацралт-од<sup>1,5</sup>, Л.Дашшэрэн<sup>1</sup>, Д.Авирамэд<sup>1,2</sup>,

<sup>1</sup> Монголын Элэгний Эмгэг Судалын Холбоо,

<sup>2</sup> Анаагаах ухааны Хүрээлэн,

<sup>3</sup> Монголын Хавдар судалын Үндэсний Төв,

<sup>4</sup> Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их сургууль,

<sup>5</sup> Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв

Монгол орон нь В гепатитын тархалт өндөртэй орнуудын тоонд ордог ба хүн амын 10 орчим хувь нь HBV-н халдвартай . Хавдрын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан нь вирусын шалтгаантай гепатит бөгөөд тэдгээрийн тал орчим хувийг В гепатитын вирус эзлэж

байна . Бидний судалгаа нь HBV вирусын тоо болон серологи маркерын шинжилгээг нэгтгэж хийсэн Монгол дахь анхны судалгаа юм. Элэгний өвчлөлийн өнөөгийн байдлыг архаг В гепатиттай өвчтөнүүдэд үнэлэхэд аль шинжилгээний арга нь ач холбогдол өндөр байгааг илрүүлэхэд бидний судалгааны зорилго оршино. Happy Veritas, клиник оношлогооны лабораториид HBV вирусын тоо шинжилгээсэн , тохиолдоор сонгосон 300 өвчтөнүүдэд статистик дүн шинжилгээ хийсэн. Taqman Real-Time PCR , HBV-combo rapid tests болон Биохиоми , Цусны дэлгэрэнгүй шинжилгээг энэхүү судалгаанд ашигласан болно.

300 HBsAg эерэг хүмүүсийн вирусыг тоолж үзэхэд 40.6% нь вирусын тоо >500 copies/ml байсан . Ийлдсийн HBV DNA сөрөг үзүүлэлт циррозтой өвчтөнүүдэд 58% , харин циррозгүй өвчтөнүүдэд 51% байсан ба 2 бүлэгт онцын ялгаа ажиглагдаагүй . HBsAg эерэг хүмүүсийн 5.3% нь HBeAg эерэг үзүүлэлттэй байв . HBV эерэг хүмүүсийн дундаж нас нь 38 байсан бол HBeAg эерэг хүмүүсийн 22 байлаа.

Хэдийгээр вирусыг тоолох нь архаг В гепатиттай өвчтөнүүдэд эмчилгээний үр дүнг тооцоход чухал шинжилгээ болдог хэдий ч элэгний архаг өвчлөлийн явцыг тогтооход ач холбогдолгүй байсан . HBsAg эерэг хүмүүсийн 40%-ны HBV DNA эерэг хүмүүс байсан . HBV DNA сөрөг хүмүүсийн АлАТ өндөр , элгэнд фиброзтой байсан учраас тэдгээрийг эрүүл зөөвөрлөгч гэж үзэхэд хүндрэлтэй юм. Энэ тохиолдолд тэдгээр хүмүүст HBsAg ны тоо хэмжээг тодорхойлох нь ашиг тустай байж болно . HBsAg-ийг эмчилгээний үр дүнг хянахад төдийлөн хэрэглэдэггүй . Тийм учраас мэдрэг чанар сайн , өргөн хүрээний шинжилгээ зайлшгүй шаардлагатай байна . Хэдийгээр барууны орнуудад HBeAg- эерэг үзүүлэлт HBV-н халдвартыг илрүүлэх болон шийдвэр гаргахад чухал үүрэгтэй байдаг боловч , бусад Азийн орнуудтай адил Монголын хувьд энэ нь өөр тохиолдол юм. Учир нь HBeAg(+) хүмүүс HBV-ын халдвартай хүмүүсийн өчүүхэн хувийг л эзлэж байна.

## 2.7. Сэргээнт эсийн үйл ажиллагааны насжилтын өөрчлөлтийг томуугийн вирусийн хемагглютинин экспрессслэгч трансген хулганын загвар дээр судалсан дүн

Ш.Түмэнжаргал<sup>1</sup>, Фюлис Лиинтон<sup>2</sup>

<sup>1</sup>ХААИС, Мал эмнэлэг - Биотехнологийн сургууль,

Халдварт өвчин - Микробиологийн тэнхим

<sup>2</sup>Сидней Киммелийн Хавдарын Төв, Санниего,

Калифорни, АНУ

Өндөр настай хүн, амьтад нь хорт хавдар болон халдварт өвчинд өртөмтгийг байдаг. Үүний шалтгаан болох сэрээ булчирхай, гэнэн/насжилттай Т эсүүдийн тухай бусад судлаачид бичиж нийтлүүлсэн. Бид Т

эсийн насжилтын өөрчлөлтийн бас нэг шалтгаан нь сэргээнт эсийн насжилттай холбоотой өөрчлөлтөд байж болох юм гэж үзсэн.

CD8+ ба CD4+ Т эсүүдийн удааширан үржилтийг насжилттай хулганад CFSE будагийн тусlamжтайгаар харуулсан. Харин залуу сэргээнт эсийг насжилттай хулганад тарихад энэ удаашралт буурсан. Мөн насжилттай хулгана дахь сэргээнт эсийн гажигтай шилжилтийг иммунофлоурсценц мөн Флуо сютометрийн тусlamжтайгаар харуулсан. Насжилттай хулганы дэлүүнд Gr-1+, B220+, CD11cintermediate сэргээнт эсүүдийн тоо багасч харин CD4-, CD11b+, CD11cbright эсүүдийн тоо нь ихэссэн байсан.

Насжилттай сэргээнт эсийн тэвчил өөрчлөгдөөгүй байсныг InsHA- транженик хулгана дээр харуулсан. Томуугийн вирусийн гадаргууны хемагглютинин /HA/ уураг нь инсуulin промоторын хяналтан доор цөсний бета эсүүдэд трансгенээр хийгддэг бөгөөд үүний эсрэг Т эсүүд нь тэвчилтэд орсон байдал.

Бид HA – пептидийн эсрэг Клон-4 трансген CD8+ Т эсүүдийг залуу болон насжилттай InsHA хулганад шилжүүлэх туршилт хийсэн. HA ургийг кодлосон томуугийн A/PR8 (H1N1) вирусээр тариагүй үед тэвчил бий болж InsHA хулганууд сахарын өвчин үүсгэхгүй. Харин тухайн вирусээр тарихад бүх залуу хулганууд сахарын өвчтэй болж байхад насжилттай хулгануудын зөвхөн тал нь сахарын өвчтэй болж байсан.

## **2.8. Бог малын зарим лентивирусийн эсрэгбиенийн тархалтыг монгол мадл судалсан дүн**

*С.Сугар, Э.Базаррагчаа, Ш.Энхээ  
УМЭАЦТА*

Бог малын Маеди-Висна, Ямааны үе-тархины үрэвсэл өвчин нь Retrovirus-овог, Lentivirus-ийн төрлийн Маеди-Виснагийн вирус (MBB), Ямааны үе-тархины үрэвсэлийн вирус (ЯYTYB)-ээр үүсгэгдэнэ. Бид өөр өөр эсрэг төрөгч бүхий ЭЛИЗА урвалаар эдгээр өвчиний эсрэг биенийг ялан илрүүлэхийг зорив.

Төв, Увс, Завхан, Архангай аймгийн нутгаас цуглуулсан хонины 45, ямааны 14 цусны ийлдсийг MBB-gag ба ЯYTYB\_gp135 эсрэг төрөгч бүхий хоёр янзын ЭЛИЗА урвалын цомгийг ашиглан шинжлэв. MBB-gag-ЭЛИЗА цомгийг Францын ID VET, ЯYTYB\_gp135-ЭЛИЗА цомгийг АНУ-ын VMRD компанид тус тус үйлдвэрлэсэн.

MBB-gag-ЭЛИЗА урвалаар хонины 12 ийлдэс эерэг, хонины 33, ямааны 14 ийлдэс тус тус сөрөг байв. ЯYTYB\_gp135-ЭЛИЗА урвалаар хонины 10,

ямааны нэг ийлдэс тус тус эерэг, бусад ийлдэс сөрөг гарав. MBB-gag-ЭЛИЗА урвалаар 5, ЯYTYB\_gp135-ЭЛИЗА урвалаар 4, хоёр урвалаар 7 эерэг дүн үзүүлж, 43 ийлдэс энэ хоёр урвалаар сөрөг байв.

Маеди-Виснагийн вирус болон Ямааны үе-тархины үрэвсэлийн вирусийн халдвэр нэг сүрэгт хам байхын зэрэгцээ нэг мадл холимог тохиолдож байна. Маеди-Висна болон Ямааны үе-тархины үрэвсэл өвчиний эсрэг биенийг илрүүлэхэд MBB-gag-ЭЛИЗА ба ЯYTYB\_gp135-ЭЛИЗА урвал тус бүрдээ өвөрмөц байна. Бог малын Lentivirus-ийн халдвартыг ялан илрүүлэхэд MBB-gag-ЭЛИЗА ба ЯYTYB\_gp135-ЭЛИЗА-г хослон хэрэглэхийг санал болгож байна.

## **2.9. Хепатитийн А вирусийн эсрэгтөрөгч илрүүлэх ФХҮ-ын оношлуур үйлдвэрлэх технологийн туршилтын дүн**

*Л.Алтантуяа, П.Сувд, Б.Энхтуяа, О.Дуламсүрэн,  
Б.Сайнчимэг, Ж.Оюунбилэг, Б.Энхжаргал, С.Лхагва,  
Ч.Цэнэпил*

*Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн, Биотехнологийн  
Үйлдвэр, Судалгаа, Сургалтын Төв*

Монголын хүн амын дунд түгээмэл тархсан халдварт өвчиний нэг нь хепатитийн А вирусийн халдвартын нэг учир ХАВ илрүүлэх, эх орны үйлдвэрийн оношлогооны бэлдмэл үйлдвэрлэх технологи боловсруулах зорилго тавин, анти-HAV IgG эерэг түүхий эд сонгож, IgG ялан илрүүлэх бэлтгэхэд ашиглах, цомгийн бусад иж бүрдлийг бэлтгэж, шалгах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Сонгосон IgG –ээр урвалын самбарыг мэдрэгжүүлж, глутаръалдегидын хоёр шатлалт аргаар (Avrameas, Ternynck. 1971, Engvall.1978 нар) пероксидаза ферменттэй холбож коньюгат бэлтгэн, оношлуурыг шалгах сорьшуудыг ПГҮ-аар шинжлэв.

ФХҮ-аар шинжлэхэд ихсийн ийлдсийн 75 сорьцын 67 нь /89.3%/, санамсаргүй сонголтоор сонгосон 64 хүний ийлдсийн 62 /96.9%/ нь анти HAV IgG эерэг тодорхойлогдов. Мөн ХӨСҮТ-д Анти-HAV IgM эерэг тодорхойлогдож эмчлүүлсэн 7 хүүхдийн ийлдсэнд анти-HAV IgG үзэхэд бүгд эерэг байлаа. Насанд хүрэгсдийн ийлдсийн хэмжээ болон анти-HAV IgG-ийн титр бага байсан учир ихсийн ийлдсийг ашиглан иммуноглобулин тундасжуулах 3 аргыг ашиглан харьцуулан туршив.

Ихсийн ийлдсээс тус бүр 3 мл-ийг авч аммони сульфатын болон натри сульфатын өөр өөр концентрацтai 3 аргаар тундасжуулж тундсыг хэмжихэд 1,3-р аргын тундасжуулалтаас тус бүр 0,059гр, 2-р аргын тундасжуулалтаас 0,005 гр тундас гарлаа. Эдгээр тундсыг 25% болгон БФҮ-д уусгаж, "batch" аргаар цэвэрлээд ФХҮ-аар шинжилэхэд гэрлийн шингээлт anti-HAV IgG 1-р аргынх 0,726, 2-р аргынх 0,894 3-р аргынх 1,926 байлаа, Мөн

спектрофотометрээр хэмжин E280 :1,35 томъёогоор тооцоход уургийн хэмжээ 1-р аргынх 0,331 мг/мл, 2-р аргынх 0,301 мг/мл байсан ба 3-р аргынх хэмжээ бага учир хэмжигдээгүй. Гарсан тундас, IgG-ийн титрээс үндэслэн 1-р аргыг илүү зохистой гэж үзлээ.

ХӨСҮТ-д анти-HAV IgM ээрэг тодорхойлогдож эмчлүүлсэн хүүхдийн ийлдсээс Аммони сульфатын /(NH4)2SO4/ усмалаар IgG тундасжуулж, хроматографын “batch” болон клонкын аргаар цэвэрлэж IgG-ийн хэмжээг ФХҮ -ын аргаар тодорхойлж оношлуур бэлтгэхэд сонгож авлаа.

“Batch” болон колонк ашиглан цэвэрлэсэн IgG -ээр пероксидаза ферменттэй холбож бэлтгэсэн коньюгатыг 1:200.....1:5000 хүртэл шингэрүүлэлт хийж ажлын концентрацыг тогтооход 1:50 байлаа.

Тетраметилбензидин, этанол, устэрөгчийн хэт исэл ашиглаж субстрат бэлтгэв.

Оношлуурыг шалгахад 64 өтгөний сорьшыг авч ПГҮ-ын аргаар ХАВ /PHX/-ыг шинжлэхэд 36 /56,2%/ нь эерэг байлаа.. Боловсруулалт хийсэн сорьцуудад бэлтгэсэн оношлуураар урвал тавихад ПГҮ-аар эерэг 36 сорьшын 4-ийг илрүүлээгүй байсан нь ПГҮ-аар сул эерэг урвал өгсөн сорьцууд байлаа.

Энэхүү судалгаан дээр тулгуурлан анти-HAV IgG, анти-HAV IgM илрүүлэх оношлуур туршин хийх боломжтой бөгөөд дараах зүйлсийг анхаарах нь зөв болов уу гэсэн дүгнэлтэнд хүрлээ. Үүнэдээ:

1. Ихсийн ийлдсээс IgG ялгасан туршилтын дүнд аммони сульфатын 80%-ийн усмалаар тундасжуулах нь илүү үр дүнтэй байна.

2. Иммуноглобулиныг цэвэрлэхэд “batch” болон “колонк”-ийн аргаас гарах үр дүн ойролцоо, “batch” арга нь хугацаа, “колонк”-ийн арга нь төхөөрөмж илүү шаардагдах талтай.

3. Хепатит А өвчинөөр ихэвчлэн хүүхэд өвддөг, насандаа хүрэгсэд хэдийгээр халдварт авсан ч эмнэлзүйн тодорхой илрэлгүй өнгөрдөг учир эмнэлэгт оношлогдоггүй, анти-HAV IgG-ийн титр бага байдаг

нь ажиглагдлаа. Иймээс түүхий эдийн сонголтыг онцгой анхаарах нь зүйтэй байна.

## **2.10. Хепатитийн А вирусийг хүний анхдагч эсийн өсгөвөрт өсгөвөрлөсөн дүн**

Э.Алтанцэцэг<sup>1</sup>, Ц.Цэвээнсүрэн<sup>1</sup>, Э.Мөнгөнчөдөр<sup>1</sup>,

Д.Сувд<sup>1</sup>, Р.Түүл<sup>2</sup>, Ч.Энхтайван<sup>3</sup>,

А.Ариунаа<sup>1</sup>, Ж.Оюунбилиг<sup>1</sup>

<sup>1</sup>Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн, БҮССТ

<sup>2</sup>Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв

<sup>3</sup>“Таны төлөө бид” Эмэгтэйчүүдийн эмнэлэг

Хепатитийн А вирус (ХАВ) нь хүнсний бүтээгдэхүүн, үндны ус зэргээр дамжин халдвартлахаас гадна халдвартай өвчтнөөс хүнд шууд халддаг. Манай орны хувьд ХАВ-ийн халдварт, нийт халдварт өвчний 22,3%, вируст хепатитийн 84,9%-ийг тус тус эзэлж байна.

ХАВ-ийг эсийн өсгөвөрт өсгөвөрлөн ялгаж, уг вирусийг молекул биологийн шинжилгээгээр илрүүлэх нь энэ судалгааны гол зорилт байв. Хепатит А оноштой 24 өвчтнөөс өтгөний сорьц цуглуулав. Эсийн өсгөвөр гарган авахын тулд 7–10 долоо хоногтой хүний үр хөврөлийн булчинлаг эдийг салган, фибробласт эсийн анхдагч өсгөвөрийг бэлтгэв. ХАВ-ийн халдвартай өвчтөнүүдээс цуглууљ, боловсруулалт хийсэн өтгөний сорьцийг хүний үр хөврөлийн фибробластын анхдагч эсийн өсгөвөрт халдвартуулж, 8 удаа зорчуулан дасгаж өсгөвөрлөлөө. Зорчуулалт бүрийн дараа ПГҮ-ын аргаар шинжилгээ хийхэд 3 дахь удаагийн зорчуулалтаас эхлэн ПГҮ-аар эерэг гарч байв. Шинжилгээнд ОХҮ-д үйлдвэрлэсэн Ампли-Синс ® HAV-Eph оношлуур ашиглов. Хүний үр хөврөлийн фибробластын анхдагч эсийн өсгөвөрийг бэлтгэж, улмаар уг эсийг ашиглан ХАВ-ийг өсгөвөрлөх боломжтой нь энэ судалгаагаар батлагдлаа. Ингэснээр ХАВ-ийн генотипийг нарийвлан тогтоох, вакцины нутгийн омог гарган авах боломж бүрдэж байна.



**ГУРАВ. ХАНЫН ИЛТГЭЛҮҮД**

**3.1. Хүнд хэлбэрийн хачигт энцефалитын үүсгэгчийг судалсан дүн**

Д.Абмэд<sup>1</sup>, Ж.Батсаа<sup>1</sup>, М.А.Хаснатинов<sup>2</sup>, Г.А.Данчинова<sup>2</sup>,  
Б.Оюунбилэг<sup>1</sup>, У.Өнөрсайхан<sup>3</sup>, Мягмар<sup>4</sup>, С.Ариунаа<sup>4</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв

<sup>2</sup> ОХУ-ын Анагаах ухааны академийн  
Дорнод сибирийн салбарын

Эрхүүгийн Халдварт Нян Судаллын Хүрээлэн

<sup>3</sup>Байгалийн голомтот халдварт Өвчин

Судаллын Үндэсний Төв

<sup>4</sup>Булган аймгийн нэгдсэн эмнэлэг

Хачигт энцефалитын вирус (ХЭВ)-ийн Баруун Европын, Урал-Сибирын ба Алс дорнодын хэвшинжийн вирусүүд Евразид тархсан ба тэдгээр нь харилцан адилгүй эмнэлзүйтэй хачигт энцефалит (ХЭ)-ын өвчлөл үүсгэдэг байна (Борисов, 2000). Сэлэнгэ аймгийн нутгаас түүвэрлэсэн хачгаас ялгасан вирусүүд нь ХЭВ-ийн Урал-Сибирын хэвшинжтэй төстэй вирус болохыг бид судлаж тогтоосон бөгөөд энэ аймагт ХЭ-аар өвчлөгсдийн эмнэлзүй нь ихэнхдээ дунд зэргийн хүндрэлтэй, эндэгдэл гарсан тохиолдолгүй байв (Абмэд, Батсаа нар 2006, 2009). Бид Булган аймагт гарсан хүнд хэлбэрийн ХЭ-ийн тохиолдлыг судалсан дүнг үндэслэн энэ өгүүлийг бэлтгэлээ. Булган аймгийн нэгдсэн эмнэлэгт 50 настай өвчтөн Р өндөр халуурна, толгой хүчтэй өвдөж, хоёр хөл явж чадахгүй байна гэсэн зовиуртай ирж “ХЭ-ын мэнэн энцефалит ба саатай хэлбэр” оноштой хэвтэж эмчлүүлсэн байна. Өвчтөн 10 хоногийн өмнө ойн хачигт хазуулж, түүнээс хойш 6 хоногийн дараа эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн бөгөөд бодит үзлэгээр 39-40 хэм халуунтай, унтаа байдалтай, хүүхэн хараа гэрлийн урвал суларсан, хүзүүний булчингүүд 3-4 см чангараалттай, доод мөчдийн мэдрэхүй суларч, хоёр хөл дээрээ зогсож чадахгүй байв. Фермент холбоот урвалаар хийсэн шинжилгээгээр онош батлагдаж, стандарт эмчилгээ хийсэн боловч өвчтөн 6 хоног ухаангүй байсаар нас барсан байна. Түүний тархины эдээс авсан сорьшноос ХЭВ-ийг ялгаж авсан. Филогенетикийн судалгаар уг вирус нь ХЭВ-ийн Алс дорнодын хэвшинжд хамарагдаж байгааг тогтоосон юм. Алс дорнодын хэвшинжийн ХЭВ нь хүнд хэлбэрийн эмнэлзүйтэй, нас баралт өндөртэй ХЭ-ын өвчлөлийг үүсгэдэг нь тогтоогдсон ба ОХУ-ын Алс дорнодын зарим нутагт хүнд, голомтот хэлбэр 30-60%-тай, нас баралт 30-35% хүрсэн ХЭ-ын өвчлөл тохиолдог байна (Леонова, 1987). Манай оронд хүнд хэлбэрийн ХЭ оношлогдож, үүсгэгчийг нь хожим тогтоосон ба цаашид ХЭВ-ийн тархсан нутгуудад уг вирусийг зөөвөрлөгч хачиг болон өвчлөгсдөөс ялгаж хэвшинжийг нь тогтоох ажлыг хийх шаардлагатай

байна. Шинжилгээний аргууд: Вирус ялгах-эсийн өсгөвөр, Молекул биологи-ХЦ-ПГУ, сиквенс, Тархвар судалал-эргэмж судалгаа, асуумж, өвчтний түүх.

**3.2. Хепатитийн С вирусийн тоог тодорхойлох шинжилгээг Монгол оронд оношлогоонд нэвтрүүлэхийн ач холбогдол болон сургамжтай тал**

Ж.Амарсанаа<sup>1,2</sup>, П.Нацагням<sup>1</sup>, Б.Саяболд<sup>1</sup>, Н.Лхасүрэн,  
Дэлгэрзаяа<sup>1</sup>, Ж.Чинбүрэн<sup>1,3</sup>, О.Баатархүү<sup>1,4</sup>, Б.Цацралт-од<sup>1,5</sup>, Л.Дашцэрэн<sup>1</sup>, Д.Авири мэд<sup>1,2</sup>

<sup>1</sup> Монголын Элэгний Эмгэг Судаллын Холбоо,

<sup>2</sup>Анагаах ухааны Хүрээлэн,

<sup>3</sup>Хавдар судаллын Үндэсний Төв ,

<sup>4</sup> Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль,

<sup>5</sup>Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв

Монголын нийт хүн амын 17% нь HCV-р халдвартлагдсан . Энэ нь манай орныг HCV-н халдварталт хамгийн өндөр орнуудын нэг болгодог . HCV-н тоо хэмжээг тодорхойлох шинжилгээ нь бараг 10 гаруй жилийн өмнө үүсч хөгжсөн хэдий ч Монголд анх удаа 2009 онд нэвтэрсэн байна . Нийт 212 HCV халдвартай өвчтөнүүд энэхүү судалгаанд оролцсон ба бүгд Happy Veritas клиник лабораторид HCV-н тоо хэмжээг тодорхойлох шинжилгээг (Taqman Real-Time PCR method) АНҮ-ын AB17000 , Applied Biosystems машинаар хийсэн Судалгаанд хамрагдсан хүмүүсээс 35 нь анти-HCV тодорхойлуулсан . Шинжилгээний дүнгээр нь вирусийн тоо өндөр >2 сая HCV copies/ml болон бага-дунд <2 сая HCV copies/ml гэж хуваасан . Энэ 2 групптээ элэгний үйл ажиллагааг шинжлэхэд вирусийн тоо бага-дунд группт элэгний ферментүүд хэвийн (AlAT<30 IU) өвчтөн 47% байхад , вирусийн тоо өндөр группт ердөө 3,1% байна . Вирусийн тоо бага-дунд группт AlAT-н дундаж 70 IU AcAT-н дундаж 45 IU байхад, вирусийн тоо өндөр группт AlAT-н дундаж 109 IU AcAT-н дундаж 74 IU байна . Мөн тромбоцитын дундаж вирусийн тоо бага-дунд группт 213,000 , өндөр группт 198,000 . HCV RNA болон anti-HCV хоюуланг нь шинжилүүлсэн 35 өвчтөний 68,5% нь (n=24) Anti-HCV and HCV-RNA хоюул эерэг, харин 31,5% anti-HCV эерэг, HCV-RNA сөрөг байна . Эдгээр өвчтөнүүдэд HCV-ийн дархлаа тогтсон гэж үзнэ . HCV-н тоо хэмжээг тодорхойлох шинжилгээг Монгол орны оношлогооны арга зүйд нэвтрүүлснээрээ өмнө нь HCV-ийн халдвартайд тооцогдож байсан өвчтөнүүдийг халдвартай юу эсвэл HCV-ийн дархлаатай юу гэдгийг яланг оношлох боломжтой болох юм. Бид мөн HCV вирусийн тоо болон элэгний ферментүүдийн хооронд шуудхамаарал байгааг тогтоолоо . Мөн энэхүү оношлогооны арга нь Монголд анх удаа вирусийн эсрэг эмчилгээний хяналтыг хийх боломж олгож байгаа юм .

### 3.3. Томуугийн цартахлын А(H1N1) вирусийн эсрэг вакцины үр ашгийг судалсан дүн

Д.Бадрал<sup>1</sup>, Ч.Уртнасан<sup>2</sup>, Н.Баясгалан<sup>2</sup>, А.Бурмаа<sup>2</sup>

<sup>1</sup>“Монголын Талбарын Тархвар Судалал”  
сургалтын хөтөлбөр,

<sup>2</sup> Халдварт өвчин судалалын үндэсний төв

Манай улс Эрүүл Мэндийн Яамнаас тодорхойлсон зорилтол бүлгийн хүмүүсийг дархлаажуулах бодлогын хүрээнд сүүлийн 2 жилийн хугацаанд нийт 723.625 буюу хүн амынхaa 27%-ийг цартахлын вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулсан. Бид вакцины үр ашгийг тохиолдол-хяналтын судалгааны аргад түшиглэн 2011 оны 1 дүгээр сарын 1-нээс 3 дугаар сарын 31-нийг дуусталх хугацаанд Улаанбаатар хотын харуулдан тандалтын нэгжүүдэд томуу, томуу төст (ТТӨ)-тэй гэж оношлогдон, ХӨСҮТ-ийн Вирус судалалын лабораториид сорьц ирүүлсэн тохиолдлуудаас сонгон хийлээ.

Тохиолдлын бүлэгт лабораториор томуугийн цартахлын А(H1N1) вирус зэрэг тодорхойлогдсон 82, хяналтын бүлэгт томуугийн вирус сөрөг тодорхойлогдсон 1209 тохиолдлоос санамсаргүй түүврийн аргаар 271 (22.4%) тохиолдлыг тус тус сонгон авч биечлэн ярилцах, утсаар харилцах хэлбэрээр асуумж судалгааг хийсэн.

Дээрхи хугацаанд томуугийн харуулдан тандалтын нэгжүүдээс ХӨСҮТ-ийн Вирус судалалын лабораториид ирүүлсэн 1910 сорьцона томуугийн вирусийн PHX илрүүлэх шинжилгээ хийхэд 122 (6.4%)-д томуугийн цартахлын А(H1N1) вирус ээрэг тодорхойлогдсоно 82 (67%) нь Улаанбаатар хотоос цуглувулсан сорьц байлаа. Шинжилгээнд сорьц өгсөн хүмүүсийн дундаж нас тохиолдлын бүлэгт 11, хяналтын бүлэгт 15 байж, тохиолдлын бүлгийнхний 54% нь эрэгтэй, 46% эмэгтэй, харин хяналтын бүлгийнхний 46% эрэгтэй, 54% нь эмэгтэйчүүд байна. Мөн тохиолдлын бүлгийн 77 (87.5%), хяналтын бүлгийн 180 (66.4%) нь цартахлын эсрэг вакцинд хамрагдаагүй байсан ба вакцины үр ашиг 82.6% (95% ИХ: 0.05-0.33)-тай байна.

Томуугийн цартахлын А (H1N1) вакцин тухайн вирусийн эсрэг 82.6%-ийн хамгаалах дархлааг бий болгосныг судалгааны үр дүн харуулж байна.

### 3.4. ЭМШУИС-ийн Сувилахуйн сургуулийн эх барихуйн ангийн оюутнуудал гепатит В, С вирусийн халдварын тархалтыг судалсан нь

З.Батицэг<sup>1</sup>, Ж.Сарантуяа<sup>1</sup>, Н.Бира<sup>2</sup>

1. ЭМШУИС-ийн Молекуу биологи-Үдам зүйн тэнхим

2. ЭМШУИС-ийн Хоол боловсруулах эрхтний эмгэг судалалын тэнхим

Вируст гепатит нь дэлхийд өргөн тархсан хадварт өвчин бөгөөд энэ өвчиний эсрэг эрчимтэй тэмцэж байгаа ч өвчлөлт буурахгүй байна. 2005 оны байдлаар дэлхий даяар 2 тэрбум хүн гепатит В вирус(HBV)ийн халдвараар өвдөөд байгаа ба тэдгээрийн 350 сая нь архаг халдвартай амьдарч байна. (О.Баатархүү 2006)

Манай оронд жил дунджаар 8000 хүн өвчиж, үүнээс гепатит В вирусийн тархалт 9,9%, гепатит С вирус(HCV)ийн тархалт 1.71% (Д. Даваалхам 2001), ажил мэргэжлийн хувьд эрсдэлт бүлгийн хүмүүсийн дунд гепатит С вирусийн илрэлт 20.8% (О.Баатархүү 2006) гэж судлаачид тодорхойлсон байдаг. Эрсдэлт бүлэг болох ЭМШУИС-ийн Сувилахуйн сургуулийн (СС) эх барихуйн ангийн оюутнуудын дунд HBV, HCV-ийн халдварын тархалтыг тогтоон, цаашид түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэлийг тогтоох зорилгоор энэхүү судалгааг хийж байна.

Судалгаанда ЭМШУИС-ийн СС-ийн эх барихуйн ангийн 1-3 курсийн 62 оюутнуудыг хамруулан асуумж судалгаа авч, ийлдсэнд HBsAg, анти-HBsAg, анти-HCV IgG илрүүлэх шинжилгээг DRG Int., (USA) компанийн ELISA (мэдрэг чанар 99,9%) цомог ашиглан хийлээ.

Нийт 62 сорьцноос 10(16.1%)-д нь анти-HCV IgG, 2(3.2%)-д нь HBsAg, 19(30.6%)-д нь анти-HBsAg эзэрэг тодорхойлогдов. Манай оронд эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилчдын дунд HBsAg 28.3%, анти-HCV 18.3% илэрсэн судалгаа байна. (Д. Отгонбаяр., 2010)

Элэгний архаг өвчнөөс урьдчилан сэргийлэх гол арга бол гепатит В вирусийн эсрэг дархлаажуулалт юм. Хөгжингүй орнуудад эмч, эмнэлгийн ажиллагсад мэргэжлээс шалтгаалан HBV-ийн халдвар нийт халдварын тохиолдлын 10% -аас бага хувийг эзэлдэг ба энэ нь халдвар хамгаалах дэглэм ба вакшин болон вирусийн эсрэг эм хэрэглэсэнтэй холбоотой юм. Бидний судалгаанд хамрагдагсад нь 1992 буюу түүнээс хойш төрсөн бөгөөд орон даяарх гепатит В вирусийн дархлаажуулалтанд хамрагдсан байх ёстой бүлэг боловч анти-HBsAg 30,6 % байгаа нь HBV-ийн эсрэг дархлал тогтоц бага байгааг харуулж байна. Судалгаанд оролцогчдоос асуумж судалгаагаар дархлаажуулалтанд хамрагдсан байдлыг тодруулахад 62 оюутны 60 нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн тул халдварын дараахи дархлаа эсвэл дархлаажуулалтын

дараахи дархлаа гэдгийг ялгах боломжгүй байлаа.  
Судалгааг үргэлжлүүлэн хийх шаардлагатай байна.

### **3.5. Адууны томуу өвчний шинэ тохиолдол**

*Д.Батчулуун<sup>1</sup>, Х.Бодьсайхан<sup>1</sup>, Ш.Энхээ<sup>1</sup>,  
Ж.Бэх-Очир<sup>2</sup>, С.Сугар<sup>1</sup>, Х.Ганзориг<sup>1</sup>*

<sup>1</sup>Улсын Мал Эмнэлэг Ариун Цэврийн Төв Лаборатори,

<sup>2</sup>Мал Эмнэлгийн Хүрээлэн

2011 оны 7 дугаар сарын 05-нд Хүй долоон худаг орчмын уяачдын уяж байгаа морьдод ханиах, хамраас усархаг, өтгөн идээтэй гоождос гарах шинж тэмдэгтэй өвчин илэрсэн юм. Уг өвчний шалтгааныг тогтоох зорилгоор дээжийг Улсын Мал Эмнэлэг Ариун Цэврийн Төв Лабораторийн малын гоц халдварт өвчний оношлогоо, тандалтын лабораториид шинжилгээ хийв. Эмнэлзүйн шинж тэмдэг бүхий 8 адуунаас цус, хамрын арчдас авч вирус өсгөвөрлөх, Буцаан хувиргах-Полимеразын гинжин урвал (БХ-ПГҮ), Бодит хугацааны-Полимеразын гинжин урвал, Цус наалдалт саатуулах урвал (ЦНСҮ), Цус наалдуулах урвал (ЦНҮ)-аар шинжлэв. Арчдасны дээжийг тахианы хөврөлжүүлсэн өндгөн 3 хоног өсгөвөрлөөд ЦНҮ-аар шинжилэхэд 7 дээж 1:8-1:64 таньштай байв. Цусны ийлдэсийг Италийн Венецийн Мал Эмнэлгийн Хүрээлэнд үйлдвэрлэсэн адууны томуугийн H3N8, H7N7 хэвшил тодорхойлох стандарт эсрэгтөрөгч ашиглан ЦНСҮ-аар шинжлэхэд бүх ийлдэс 1:8-1:16 таньштай байв. Адууны томуугийн хэвшил өвөрмөц праймер (Invitrogen, USA) ашиглан БХ-ПГҮ, Бодит хугацааны ПГҮ-аар шинжилсэн дүнгээр A/H3N8 хэвшил вирусийн ген илрэв.

Хүй долоон худаг орчмын уяачдын адуунд илэрсэн ханиах, хамраас усархаг, өтгөн идээтэй гоождос гарах шинж тэмдэг бүхий өвчин нь A/H3N8 хэвшэл вирусээр үүсгэгдсэн томуу өвчин болохыг тогтоов.

### **3.6. Хачигт энцефалит өвчний тархвар зүй, ийлдэс эмчилгээний зарим үр дүнг судалсан нь**

*А.Долгорхана<sup>1</sup>, С.Амарзаяа<sup>1</sup>, Б.Сува<sup>1</sup>,  
Б.Оюунбилиг<sup>2</sup>, Н.Эрдэнэбат<sup>3</sup>*

<sup>1</sup>Монголын "Талбарын Тархвар Судал" сургалтын хөтөлбөр

<sup>2</sup> Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв,

<sup>3</sup>Сэлэнгэ аймгийн БГХӨСТ

Хачигт энцефалит өвчин нь Flaviviridae овгийн Flavivirus-ийн төрлийн вирусээр үүсгэгддэг халдварт өвчин.

Монгол Улсад 2004-2009 онд бүртгэгдсэн хачигт энцефалит өвчний 72 тохиолдлын өвчний түүхэнд

тархвар зүйн бичиглэл судалгаа хийсэн.

2005-2009 онд хүний өвчний 72 тохиолдол тэмдэглэгдэж, 2007 онд хамгийн олон тохиолдол бүртгэгдсэн байна. Хачигт энцефалит өвчнөөр бүх насыхан өвчилснөөс 15-29 насны, эрэгтэйчүүд зонхилон өвчиж, хамгийн бага нь 4 настай, хамгийн их нь 60 настай хүн ба өвчлөгсдийн дундаж нас  $29.4 \pm 11.8$  байна. Нийт өвчлөгсдийн ихэнх нь хачигт халдвартын голомтот нутагт албан томилолтоор ажиллах, мод бэлтгэх, бугын эвэр, эмийн ургамал түүх үедээ халдварт авч өвчилсөн байна. Эргэмж судалгаанд хамрагдсан 46 хүний 25 (54.3%) хүнд ямар нэг үлдэц шинж тэмдэг илэрсэн байсан. Хачигт энцефалитын иммуноглобулин эмчилгээ хийлгэсэн өвчтний 81.1%, хийлгээгүй өвчтний 66.6%-д ямар нэг үлдэц шинж тэмдэг илэрсэн боловч статистикийн хамаарал бүхий ялгаа ажиглагдсангүй ( $P=0.6$ ).

2005-2009 онд 5 аймгийн 19 сумаас нийт 72 хүн халдварт авч, 15-29 насны эрэгтэйчүүд зонхилон өвчиж, хамрагдсан 46 хүний 25 (54.3%-д ямар нэг үлдэц шинж тэмдэг илэрсэн хэдий ч иммуноглобулин эмчилгээнд хамрагдсан болон хамрагдаагүй өвчтнүүдэд илэрсэн үлдэц шинж тэмдэг статистикийн хувьд ялгаагүй байна.

### **3.7. Архаг В хепатиттэй өвчтөнүүдэд вирусийн серологи маркеруудын Монгол улс дахь өнөөгийн тархалт, ач холбогдол**

*П.Нацагням<sup>1</sup>, Ж.Амарсанаа<sup>1,2</sup>, Б.Саяболд<sup>1</sup>,  
Н.Лхасүрэн<sup>1</sup>, Дэлгэрзаяа<sup>1</sup>, Ж.Чинбүрэн<sup>1,3</sup>, О.Баатархүү<sup>1,4</sup>,  
Б.Цацралт-од<sup>1,5</sup>, А.Дашцэрэн<sup>1</sup>, Д.Авирамд<sup>1,2</sup>*

<sup>1</sup> Монголын Элэгний Эмгэг Судалын Холбоо,

<sup>2</sup> Анагаах ухааны Хүрээлэн,

<sup>3</sup> Хавдар судалын Үндэсний Төв ,

<sup>4</sup> Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль,

<sup>5</sup> Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв

HBsAg серопозитив түвшин Монголын эрүүл хүн амын дотор ойролцоогоор 10% байна . Хэдийгээр вирусийн халдвартын тархалтын талаар олон судалгааны ажил хийгдэж байсан ч вирусийн бусад маркерыг үзсэн нарийвчилсан судалгааны ажил өмнө нь хийгдэж байгаагүй . Бид HBV-н бүх 5 маркерын серопозитив түвшинг тогтоох зорилгоор энэ судалгааг хийв. 2009 оны 1 сараас 10 сар хүртэлх хугацаанд HBV-ийн 5 серологи маркерууд HBsAg, HBeAg,HBsAb болон HBeAb,HbcAb шинжлүүлсэн 1,961 хүнийг судалгаанд хамруулсан . АНҮ-н ACON Laboratories-с худалдан авсан HBV combo test болон цусны дэлгэрэнгүй шинжилгээг Японы Sysmex, XS800i hematology analyzer ашиглан хийсэн. Microsoft Excel программаар боловсруулав.

1,961 хүнээс HBsAg ээрэг байсан 381 өвчтөн

дээр дүн шинжилгээ хийхэд HBV-ээр халдвартлагсан эрэгтэйчүүд 53,2% (n=203), эмэгтэйчүүд 46,8% (n=178). HBsAg эерэг хүмүүсийн 3,6% нь HBeAg эерэг(хүйсийн харьцаа ижил) байна. HBeAb эерэг өвчтөнүүд 19,9% (n=76), HBcAb болон HBeAb хоюул эерэг 77,6% (n=59) байна. HBcAb эерэг өвчтөнүүд нийт өвчтөнүүдийн 39,3%(n=150)-г эзэлж байна, үүний 59,4% (n=89) нь эрчүүд. Ямар нэг эсрэг бие илрээгүй, зөвхөн HBsAg эерэг 203 хүн(53,2%) байсан. Бид мөн элэгний циррозын нэг илтгүүр болох тромбоцитын тоог тодорхойласон ба энэхүү судалгаагаар цусны дэлгэрэнгүй шинжилгээ бүрэн хийлгэсэн (n=90) өвчтөнүүдийн 8,8% (n=8) нь циррозтой байна. Эдгээр циррозтой өвчтөнүүдэд альбумины хэмжээ <3,4 g/dl. HCV (anti-HCV) болон HBV (HBsAg) давхар халдвартай өвчтөнүүд нийт өвчтөнүүдийн 3,6% (n=14)-г эзэлж байна.

HBV-ийн халдвартай хүмүүсийн ойролцоогоор 9% циррозтой ба нийт хүн амын 0,8% (n=24,000) нь циррозтой. HBV болон HCV-ийн хам халдвартай бол элэгний цирроз үүсэх эрсдэл бусад орны судалгааны үр дүнтэй харьцуулахад 7,1 vs. 1,9% харьцангуй өндөр . HBeAg-ны эерэг түвшин барууны орнуудтай харьцуулахад маш бага 3,7% байна.

## 3.8. Улаанбаатар хотын хүн амын дунд томуугийн цартахлын эсрэг дархлаа тогтоцын түвшинг хөөн судалсан дүн

Г.Нямаа<sup>1,2</sup>, А.Бурмаа<sup>1</sup>, Б.Тиан<sup>3</sup>, С.Цацраа<sup>1</sup>, Ц.Наранзуу<sup>1</sup>, Н.Баясгалан<sup>1</sup>, Б.Ариунсанаа<sup>2</sup>, Л.Энхбаатар<sup>1</sup>, Б.Ганцоож<sup>4</sup>, Д.Либо<sup>3</sup>, Б.Дармаа<sup>1</sup>, П.Нямдаваа<sup>1,4</sup>

<sup>1</sup>Халдварт өвчин судалын үндэсний төв,

<sup>2</sup>ЭМШҮИС, БАС-ийн Бичил амь дархлаа судалын тэнхим,

<sup>3</sup>БНХАУ-ийн өвчиний хяналт сэргийлэлтийн төв,

<sup>4</sup>Монголын анагаах ухааны академи

Улаанбаатар хотын 6 дүүргийн оршин суугчидас цар тахал бүртгэгдэхээс өмнө 2009 оны 6 дугаар сард 1109, цартахлын оргил үед 2009 оны 11 дүгээр сард 1121, цартахлын эхний давалгаа зогссоны дараа 2010 оны 6 дугаар сард 1120, нийт 3350 ийлдэс цуглувуж шинжлэв. Бүх ийлдсийг томуугийн цартахлын вирусийн A/California/07/09(H1N1) лавлагaa омгийг ашиглан цус наалдахыг саатуулах урвал (ЦНСҮ)-ын бичил хувилбараар БНХАУ-ийн өвчиний хяналт сэргийлэлтийн төвд эсрэг биеийн таньцыг тодорхойллоо.

2009 оны 6-р сард цуглувулсан 1109 ийлдсэнд цартахлын эсрэг дархлаа тогтоцын түвшин 12 наслын ангилалд хамгийн бага ( $\geq 40\%$  эсрэг биеийн титертэй хүн амын давхрага 1,1%) байлаа ( $P<0,001$ ). Халдвартын өмнөх эсрэгтөрөгч өвөрмөц эсрэгбиеийн таньц 10-

19, 20-29 наслыханд 2,1%, 1,6%, харин 70 ба түүнээс дээш наслын бүлгийн хүмүүст хамгийн өндөр буюу 3,1% байлаа. 2009 оны 11-р сард цуглувулсан 1121 ийлдсэнд цартахлын эсрэг дархлаа тогтоцын түвшин бүх наслын ангилал ( $\geq 40\%$  эсрэг биеийн титертэй хүн амын давхрага 24,1%) болж өссөн байлаа ( $P<0,001$ ). Халдвартын болон вакцины дараах 2010 оны 6-р сард цуглувулсан 1120 ийлдсэнд цартахлын эсрэг дархлаа тогтоцын түвшин 12 наслын ангилалд хамгийн өндөр ( $\geq 40\%$  эсрэг биеийн титертэй хүн амын давхрага 56,6%) 2 хүртэл наслын хүүхдэд 39,4%, 5-9 настай хүүхдэд 65,0%, харин 60-69 наслыханд 34,2%, 70 ба түүнээс дээш наслын бүлгийн хүмүүст 31,4% байлаа. Судалгаанд хамрагдсан 1120 хүний 39,6% нь цартахлын эсрэг дархлаажуулалтанд хамрагдсан гэсэн өгүүлээмжтэй байлаа.

Бидний энэ судалгааны дүн нь Монголд бүртгэгдсэн A(H1N1) 2009 томуугийн цартахлын дэгээрт 2009 оны 10 дугаар сараас эхэлсэн гэсэн эпидемиологийн дүгнэлтийг баталж байна.

### Талархал

Энэхүү судалгааг хийхэд үнэлж барашгүйтуслалцаа үзүүлсэн “Томуугийн тандалтын тогтолцоо байгуулан хөгжүүлэх” төслийн хүрээнд санхүүжүүлсэн АНУ-ын засгийн газарт, БНХАУ-ийн өвчиний хяналт сэргийлэлтийн төвийн хамт олонд зохиогчид баярлаж талархсанаа илэрхийлж байна.

## 3.9. Монгол тэмээ (Camelus bactrianus) болон лам гөрөөс (lama glama)-ний зарим шитокиний молекул бүтцийг харьцуулан тодорхойлж, түүний вируст халдвартын эмгэг жамттай холбон судалсан нь

Р. Одбилэг<sup>1,2</sup>, С.Коннай<sup>2</sup>, К.Охаш<sup>2</sup>, М.Онума<sup>2</sup>

<sup>1</sup>Монгол улс, Улаанбаатар хот, Мал эмнэлгийн хүрээлэн, Вирус судалын лаборатори,

<sup>2</sup>Япон улс, Саппоро хот, Хоккайдогийн их сургууль, Мал эмнэлгийн магистр, доктор, мэргэшлийн сургууль

Тэмээ, лам гөрөөс нь Camelidae бүлэгт багтдаг. Хоёр бөхт тэмээг уналаа эдэлгээ, тээвэрт ашиглаж, тэдгээрийн ноос, арьс шир, мах, сүүг хэрэглэж байгаа нь үйлдвэрлэлийн болоод Монголын мал эмнэлэгт чухал ач холбогдолтой. Ерөнхийдөө, тэмээ болон лам гөрөөс нь зарим халдварт өвчинд тэсвэртэй байдаг боловч адлуу, үхэр, хонь зэрэг амьтад өвчилдөг вируст халдварт ба бусад өвчин үүсгэгчээр өвчилдөг.

Монгол тэмээ болон лам гөрөөсний зарим шитокиний молекул бүтцийн харьцуулсан судалгааг хийхдээ гарал үүслийн шинжилгээ, амин хүчлийн дараалалыг тогтоох ба молекул колоны аргыг ашиглав.

Тэмээний зарим шитокиний нуклеотид ба амин

хүчлийн дараалал, гарал үүсэл нь лам гөрөөс, гахай, үхэртэй адил төсөөтэй болох нь шинжилгээгээр тогтоогдсон. Тэмээ болон лам гөрөөсний цитокиний амин хүчлийн дараалалыг тогтоосон нь өвчний гаралтын үе дэхь, ялангуяа тэмээ, лам гөрөөсний вируст халдвартын үеийн шингэнний болон эсийн дархлааны хариу урвалын мөн чанарыг тайлбарлахад голлох үүрэгтэй юм. Өнөөгийн байдлаар, *Camelidae* бүлгийн тэмээ болон лам гөрөөсний вируст халдвартын үе дэхь цитокиний зохицуулалтын талаар мэдээлэл бага байгаа бөгөөд, цаашид цитокиний нийлэгжүүлэлт ба вируст халдвартын эмгэг жамын хоорондын харилсан холбоог үргэлжлүүлэн судлах шаардлагатай байна.

### 3.10. Вирусээр үүсгэгддэг байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний судалгааны үр дүнгээс

Д.Отгонбаатар, Ж.Дуламжав, Д.Цэрэнноров  
БГХӨСҮТ

Олонуулсын нийгмийн эрүүлмэндийн байгууллагууд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хяналтанд аавсан шинээр тархаж буй халдварт өвчнүүдийн 75 хувь нь зоонозын буюу зэрлэг болон гэрийн тэжээвэр амьтдын дундаас үүссэн халдвартууд байсан.

1991-2008 онд шинээр хяналтанд аавсан вирусээр үүсгэгдсэн 20 өвчний халдвартын эх үүрхай нь тэмээ, хонь ба харх зэрэг мэрэгч амьтад, зэрлэг болон тэжээвэр шувууд байнсныг тогтоосноор нотогоо болгож, цаашид жил тутамд нэмэгдэх хандлагатайг хүрээлэн буй орчин, байгаль, уур амьсгалын өөрчлөлт, хүн амын хэт төвлөрөлт, шилжилт хөдөлгөөн зэрэг нийгэм-эдийн засгийн хүчин зүйлүүдтэй холбон тайлбарлаж байна.

Монгол улсын хэмжээнд вирусээр үүсгэгддэг зоонозын халдвартуудаас хүн амыг урьдчилан сэргийлэх, эртилрүүлэлт, хариу аргах хэмжээг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор 2007 онд БГХӨСҮТ-д вирус судаллын лабораторийг байгуулснаас хойш 2011 оны байдлаар вирусийн эсрэгбие, эсрэгтөрөгчийг илрүүлэх хурдавчилсан сорил, дархан түяарах урвал, фермент холбоот урвал, иммуноблотингийн урвал, УТ-ПГУ болон бодит цагийн УТ-ПГУ зэрэг шинжилгээний аргуудаар галзуу, хачигт энцефалит, баруун Нилийн халуурал, бөөрний хам шинжит цусархаг халуурал, Японы энцефалит, Крым-Конгын цусархаг халуурал, шувууны томуу зэрэг вирусээр үүсгэгддэг халдвартуудын шинжилгээ, судалгааг хийж байна.

Вирусээр үүсгэгддэг зоонозын халдвартын шинжилгээ, судалгаанд гадаад орнуудтай хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлснээр Монголын

нутагт орчиж буй зарим вирусийн гарал үүслийг тодорхойлсон. Монголын нутагт орчиж буй галзуугийн вирус нь Steppe бүлгийн OXY-ын Тывагийн 765(w) (генийн сангийн °AY352483) омогтой ойр төрлийн, цогцосны тархинаас яланг авсан хачигт энцефалитын вирус нь Буриадад хээрийн оготноос (*Clethrionomys glareolus*) илрүүлсэн 740-84 (генийн сангийн °EU878282) вирустэй төрөл ойрын Алс Дорнодын дэд хэв шинжийн вирус болохыг тус тус тодорхойлж, мөн генийн санд шувууны томуугийн H13N8 хэв шинжийн вирусийг (*A/herring gull/Mongolia/454/2008(H13N8)*) бүртгүүлсэн. Түүнчлэн Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн нутагт шувууны томуугийн AH3N6 AH4N6, AH1N1, AH13N8 хэв шинжийн вирусүүдийг 11 зүйлийн зэрлэг шувуунаас яласан нь хамтын ажиллагааны үр дүн төдийгүй анагаах ухааны нотолгоонд суурилсан шинжилгээ, судалгааг өргөжүүлэх үйл ажиллагаанд чухал ач холбогдоо өгч байна. Байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний вирус судаллын асуудлыг эхлүүлэн тодорхой үр дүнд хүрч байгаа ба цаашид вирус судаллын илрүүлэх, тодорхойлох шинжилгээг өргөжүүлэх, нарийвчилсан судалгааг эхлүүлэх, лабораторийн биоаюулгүй ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

### 3.11. Азийн хоёр орон: Япон, Филиппинд хүний метапневмонии вирусийн эргэлт

К.Отани<sup>1</sup>, А.Сүзукі<sup>1</sup>, К.Тома<sup>1</sup>, Т.Итамура<sup>1</sup>, Х.Отомару<sup>1</sup>, Н.Фужі<sup>1</sup>, Х.Галанг<sup>2</sup>, Е.Меркадо<sup>2</sup>, С.Луписан<sup>2</sup>, Х.Ошитани<sup>1</sup>

<sup>1</sup>Япон улсын Сендай хот, Тохоку их сургууль, Вирус судаллын тэнхим

<sup>2</sup>Филиппин улсын Халуун орны Өвчин Судалын Хүрээлэн

Хүний метапневмонии вирус(hMPV) нь парамиксовирусийн ангилалд хамаардаг, бүтэц, эмнэл зүйн илрэлээрээ респиратор синцитиаль вирустэй төстэй. Томуу өвчний хувьд халуун орнуудаас дэлхийн бөмбөрцгийн өмнөд ба хойд хэсгийн сэргүүн бүсийн орнуудад дамжин улирлын чанартай тархдаг зүй тогтолтой байдаг. Харин дэлхий нийтэд hMPV-ийн тархалтын талаар судалгаа хомс байна. Иймээс бид Япон, Филиппин улсуудад өвчлөл үүсгэн эргэлтэнд байгаа hMPV-ийн генотипийг 6 сарын давтамжтайгаар тогтоож, харилсан хамаарлыг судлахыг зорилоо.

Филиппин улсын, Таклобанд хүүхдийн уүшигны хүнд хэлбэрийн хатгалгааны улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсэдээс хамар, залгиурын арчдас цуглуулсан.

Японы Синдай хотын хувийн эмнэлгүүдэд үзүүлсэн болон гурав дахь шатлалын эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн амьсгалын замын цочмог халдвартай хүмүүсээс хамар, залгиурын арчдас цуглуулж, LLC-

МК2 эсийн өсгөвөрт халдааж вирус өсгөвөрлөв. Хоёр улсад цуглуулсан бүх сорьшноос PHX-ийг ялгаж, хоёр шаталт урвуу транскриптазат полимеразийн гинжин урвал(ҮТ-ПГҮ) болон нэг шаталт бодит хугацаа(бх) ны ҮТ-ПГҮ-ын шинжилгээ, F генийн хэсэгчилсэн сиквенси хийж, генетик хэвшинжийг тодорхойлов.

Филиппин улсын, Таклобанаас 2008 оны 5 дугаар сараас 2011 оны 6 дугаар сарын хооронд цуглуулсан 1,514 сорьшны 45-д нь hMPV илэрсэн. Энд hMPV-ийн генотипийн 2 өөр бүлэглэл тодорхойлогдов: эхнийх буюу A-2; B-1 генотип нь 2009 оны 3-4 дүгээр сард, харин B-1 генотип нь 2010 оны 10-11 дүгээр сард тус тус эргэлтэнд байсан байна. B-1 генотипийн вирус нь маш бага өөрчлөлттэйгөөр дор хаяж турван жил тасралтгүй эргэлтэнд байсан нь харагдаж байна.

Синдайд 2010 онд 127 сорьшноос 1-д нь, 2011 онд 387 сорьшноос 18-д нь hMPV ээрэг тодорхойлогдох, 2011 оны 5 -6 дугаар сард уг халдвартын дэгдэл болсон нь ажигдагдав. 2010 онд A-2, 2011 онд A-2, B-2 генотипийн вирусүүд эргэлтэнд байж, 2010 ба 2011 оны A-2 генотип нь нүклейтидиин дараалалаараа ялгаагүй байлаа. 2010 онд Филиппинд илэрсэн вирус, 2011 онд Японд илэрсэн вирусээс генотипээрээ ялгаатай байна. А генотип нь 2 орон хоёуланд нь 2 жилийн давтамжтайгаар илэрсэн. Эдгээр A генотипийн вирусүүд нь ялгаатай боловч нэг бүлэглэлд хамаарч байна. 2010 ба 2011 онд Азийн хоёр оронд илэрсэн hMPV-ийн генотипийн бүлэглэлүүд нь хоорондоо холбоогүй байна. hMPV-ийн эволюци нь томуугаас өөр байж магадгүй.

## 3.12. Монгол улсад оношлогдсон улаанбурханы вирусийн генотип

P.Түүл<sup>1</sup>, Д.Огтонбаяр<sup>1</sup>, У.Наранчимэг<sup>1</sup>, П.Нямдаваа<sup>1</sup>,  
В.Лим<sup>2</sup>, Г.Үүг<sup>2</sup>, Ю.Жээ<sup>3</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв,  
<sup>2</sup>Хонг Конгийн Нийгмийн Эрүүл Мэндийн  
Төв Лаборатори,  
<sup>3</sup>ДЭМБ-ын Номхон Далайн Баруун Бүс

Улаанбурханы халдвартын тархалтыг хянах тандалтын судалгаанд уг вирусийн генотипийг тогтоошинаа шинжилгээг улам өргөнөөр ашиглах болж байна. Улаанбурханы вирус нь ийлдэс судалалын хувьд зөвхөн нэг хүрээнд багтаж боловч генетикийн хувьд найман клейд (A–H), 23 генотипэд хуваагддаг билээ[ДЭМБ, 2007]. Улаанбурханы вирусийн тодорхой нэг генотип газарзүйн тодорхой нэг бүсэд нутагшмал байдааар голлон тархдаггүй ч давамгайлан тархсан генотип байдаг. 2002 онд Монгол улсад бүртгэгдсэн улаанбурханы дэгдэлтийн үүсгэгч нь тухайн үед Хятадад оношлогдож байсан омгуудтай адилхан H1 генотипийн вирус байсан юм [Р.Түүл, 2007]. 2003 оноос хойш манайд улсад улаанбурханы алаг цоог

өвчлөл бүртгэгдсээр байна.

Улаанбурханы халдвартыг таслан зогсоох хөтөлбөрийн үр дүнг үнэлэхийн тулд, Монгол улсад эргэлдэж байгаа улаанбурханы вирусийн генотипийг тогтоошинаа гол зорилт байв. 2006–2010 онуудын хооронд улаанбурхан оноштойгоор хэвтэж эмчлүүлсэн өвчтнүүдээс цуглуулсан 73 ийлдсийг шинжлэв. Эдгээр ийлдсэнд улаанбурханы эсрэг өвөрмөц IgM эсрэгбиенеийг илрүүлэх шинжилгээг ФХҮ-ын оношлуур ашиглан (Dade Behring Enzygnost/Siemens, Marburg, Germany)-аар хийлээ. Цуглуулсан сорьшноос QIAamp Viral RNA Kit (Qiagen, Hilden, Germany)-ийг ашиглан нийт рибонуклеин хүчил (PHX)-ийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу ялгаж гадаад праймерууд (MVN1: 5'-GCT ATG CCA TGG GAG TAG GA-3'; MVN2R: 5'-GGC CTC TCG CAC CTA GTC TA-3'), ПГҮ-ын эм урвалж (SuperScriptTM III One-Step RT-PCR Kit), Platinum Taq DNA Polymerase (Invitrogen, Carlsbad, CA) зэргийг ашиглан, ҮТ-ПГҮ-аар нүклеопротеин уургийн N генийн С-төгсгөлийн 590 хос сууриас тогтсон фрагментийг олшруулав. Эхний ПГҮ-ын бүтээгдэхүүнээс авч, дотоод праймерууд (MVN3: 5'-CCA TGG GAG TAG GAG TGG-3'; MVN4R: 5'-CTC TCG CAC CTA GTC TAG-3')-ыг ашиглан, үүрэн ПГҮ-аар 581 хос сууриас тогтсон фрагментийг олшруулаваа. ПГҮ-ыг тавих бүрдээ GeneAmp 9700 PCR system-ийн термоциклер (Applied Biosystems, Foster City, CA)-ийг ашиглав. ПГҮ-аар эерэг гарсан бүтээгдэхүүнүүдийг QIA quick PCR Product Purification Kit (Qiagen, Germany) ашиглан цэвэрлэв. Цэвэрлэсэн бүтээгдэхүүнүүдийн нүклеотидийн дарааллыг тогтооходоо, тусгай цомог (ABI PRISM Big Dye Terminator cycle sequencing kit) болоод MVN3, MVN4R праймеруудыг хамт ашиглаж, ABI PRISM 3100/3130xl DNA sequencer (Applied Biosystems)-ээр шинжлэв. Тогтоосон бүх нүклеотидүүдийн дарааллаас праймеруудын бүсийг хасч, үлдсэн нүклеотүүдийн дараалалд филогенетикийн шинжилгээ хийхдээ BioEdit (version 7.0.5.3), SIMMONIC (version 1.5), MEGA (version 4.1 beta) зэрэг программыг ашигласан болно. MEGA (version 4.1 beta) программыг ашиглан зэрэгцүүлэн нийлүүлэх аргаар (1,000 bootstraps) N генийн С-төгсгөлийн 444 хос суурийн нүклеотидийн дараалалд үндэслэн филогенетикийн модны зургийг байгуулав (генотипийн шинжилгээ хийх цонхны 450 хос суурийн 3' төгсгөлийн 6 хос нүклеотид ороогүй болно).

Улаанбурханы онош батлагдсан 73 өвчтөнөөс 6 хүнд нь улаанбурханы вирусийн омгууд илэрч, тэдгээрийн генотипийг нь амжилттай тогтоолоо. Улаанбурханы вирусийн 3 омог нь D6 генотип байсан бөгөөд цөм 2006 онд хэвтэж эмчлүүлсэн турван өвчтөнөөс, тууралт эхэлсний дараах 2 хоногт багтаан цуглуулсан ийлдсэнд илрэв (Сорьшны дугаар: 167, 175, 179). Нөгөө 3 омог нь H1 генотипийн вирус байсан

бөгөөд цөм 2008 буюу 2009 онд хэвтэж эмчлүүлсэн гурван өвчтөнөөс, тууралт эхэлсний дараах 2 хоногт багтаан цуглувсан ийлдсэнд илэрсэн юм (Сорьцын дугаар: 102, 103, 300).

Улаанбурханы вирусийн халдварын алаг цоог хэлбэрүүд өөр өөр генотипээр үүсгэгдэж болох нь энэ судалгаанаас харагдаж байна. Монгол улсад 2006 онд бүртгэгдсэн улаанбурханы өвчлөл тухайн үед Европын улсуудад илэрч байсан D6 генотипийн вирусээр үүсгэгдэж байжээ. Гэтэл манай улсад 2008 болон 2009 онд бүртгэгдсэн улаанбурханы алаг цоог хэлбэрийг H1 генотипийн вирус үүсгэж байсан нь тогтоогдов. H1 генотипийн вирус урьд өмнө нь Хятад болон Монгол улсад оношлогдож байсан юм.

### **3.13. Өмнөговь аймагт бүртгэгдсэн гахай хавдрын халдварын молекулын эпидемиологи**

*Р.Туул<sup>1</sup>, Д.Огтонбаяр<sup>1</sup>, У.Наранчимэг<sup>1</sup>, П.Нямдаваа<sup>1</sup>,  
В. Лим<sup>2</sup>, Г.Вүү<sup>2</sup>, Ю.Жээ<sup>3</sup>*

<sup>1</sup>Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв,

<sup>2</sup>Хонг Конгийн Нийгмийн Эрүүл Мэндийн  
Төв Лаборатори,

<sup>3</sup>ДЭМБ-ын Номхон Далайн Баруун Бүс

Улаанбурхан-улаанууд-гахай хавдрын хавсарсан вакцин (MMR vaccine)-ыг 2009 оны есдүгээр сараас эхлэн Монгол улсад хэрэглэж эхэлсэн ч, гахай хавдрын вирус хүн амын дунд эргэлдсээр байна. Тухайлбал, 2011 оны гуравдугаар сард Өмнөговь аймгийн Гурван тэс сумд гахай хавдрын дэгдэл бүртгэгдсэн билээ.

Өмнөговь аймгийн Гурван тэс сумд бүртгэгдсэн гахай хавдрын үүсгэгчийн генотипийг тогтоож, молекулын эпидемиологийг тодруулах нь энэ судалгааны гол зорилт болно. Өмнөговь аймгийн Гурван тэс сумын халдвартын тасаг болон аймгийн нэгдсэн эмнэлэгт гахай хавдар оноштойгоор хэвтэж эмчлүүлсэн 18 өвчтөнөөс ийлдсийн 18, хамар залгиурын арчdasын 15, шээсний 18, нийт 51 сорьцыг цуглувуж, шинжилгээнд ашиглах хүртэл -70оС-ийн хэмд хадгалж байв. Цуглувсан бүх 18 ийлдсэнд гахай хавдрын эсрэг өвөрмөц IgM эсрэгбиесийг илрүүлэх шинжилгээг ФХҮ-ын оношлуураар (Novatech, Germany)-аар хийхэд, 10 сорьцонд эерэг гарав. Цуглувсан сорьцоос QIAamp Viral RNA Kit (Qiagen, Hilden, Germany)-ийг ашиглан нийт рибонуклеин хүчил (PHX)-ийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу ялгаж (Qiagen One Step RT-PCR kit)-ийг ашиглан эхний шатны УТ-ПГҮ-аар олшруулав. SH генийн 639 хос суриас тогтсон фрагментийг бүхлээр нь олшруулахдаа 2 өөр цогц праймеруудыг ашигласан юм. Тухайлбал, SH1 (5'-AGTAGTGTGAT-GATCTCAT-3') болон SH2R (5'-GCTCAAGCCTTGAT-CATTGA-3') праймеруудыг эхний шатны УТ-ПГҮ-д ашигласан бол, SH3 (5'-GTCGATGATCTCATCAG-

GTAC-3') болон SH4R (5'-AGCTCACCTAAAGT-GACAAT-3') праймеруудыг үүрэн ПГҮ-д ашиглалаа. ПГҮ-ыг тавих бүрдээ GeneAmp 9700 PCR system-ийн термоциклер (Applied Biosystems, Foster City, CA)-ийг ашиглов. ПГҮ-аар эерэг гарсан бүтээгдэхүүнүүдийг QIA quick PCR Product Purification Kit (Qiagen, Germany)-ашиглан цэвэрлэв. Цэвэрлэсэн бүтээгдэхүүнүүдийн нүклеотидийн дарааллыг тогтоохдоо, (ABI PRISM Big Dye Terminator cycle sequencing kit) цомог болон SH1, SH2R праймеруудыг хамт ашиглаж, ABI PRISM 3100/3130xl DNA sequencer (Applied Biosystems)-ээр шинжлэв. Тогтоосон бүх нүклеотидүүдийн дараалалд филогенетикийн шинжилгээ хийхээ BioEdit (version 7.0.5.3), SIMMONIC (version 1.5), MEGA (version 4.1 beta) зэрэг программыг ашигласан болно. MEGA (version 4.1 beta) программыг ашиглан зэрэгцүүлэн нийлүүлэх аргаар (1,000 bootstraps) SH генийн 316 хос суурийн нүклеотидийн дараалалд үндэслэн филогенетикийн модны зургийг байгуулаа.

Эмнэлзүйн 51 сорьцийг шинжлэхэд 4 өвчтөний хамар залгиурын арчдаст гахай хавдрын вирусийн PHX УТ-ПГҮ-аар илрэв. SH генийн 316 хос суриас тогтсон нүклеотидийн дараалалд үндэслэн филогенетикийн модны зургийг байгуулнаар эдгээр 4 омог нь цөм гахай хавдрын вирусийн F генотипэд хамрагдаж байлаа. Өмнөговь аймагт бүртгэгдсэн гахай хавдрын дэгдэлтийн үүсгэг нь гахай F генотипийн вирус байсан нь батлагдаа.

### **3.14. Монгол улсад эргэлдэж байгаа улаануудын вирусийн генотип**

*Р.Туул<sup>1</sup>, Д.Огтонбаяр<sup>1</sup>, У.Наранчимэг<sup>1</sup>, П.Нямдаваа<sup>1</sup>,  
В. Лим<sup>2</sup>, Г.Вүү<sup>2</sup>, Ю.Жээ<sup>3</sup>*

<sup>1</sup>Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв,

<sup>2</sup>Хонг Конгийн Нийгмийн Эрүүл Мэндийн  
Төв Лаборатори,

<sup>3</sup>ДЭМБ-ын Номхон Далайн Баруун Бүс

Монгол улсын хэмжээнд улаанбурхан-улаанууд-гахай хавдрын хавсарсан вакцин (MMR vaccine)-ыг 2009 оноос эхлэн есөн сартай бүх хүүхдэд тарьдаг болсон билээ. Гэвч улаанууд өвчний алаг цоог тохиолдол манай улсад тасралтгүй бүртгэгдсээр байгаа юм.

Монгол улсын хүн амын дунд эргэлдэж байгаа улаануудын вирусийн генотипийг тогтоох нь энэ судалгааны гол зорилт мөн. 2008–2010 онуудад улаанууд оноштойгоор хэвтэж эмчлүүлсэн өвчтөнүүдээс цуглувсан 109 ийлдсэнд улаануудын эсрэг өвөрмөц IgM эсрэгбиесийг илрүүлэх шинжилгээг ФХҮ-ын оношлуур (Dade Behring Enzygnost/Siemens, Marburg, Germany)-аар хийлээ. Сорьцоос QIAamp Viral RNA Kit (Qiagen, Hilden, Germany)-ийг ашиглан нийт рибонуклеин хүчил (PHX)-ийг ялгаж (Qiagen One

Step RT-PCR kit) -ийг ашиглан эхний шатны УТ-ПГУ-аар олшруулав. ДЭМБ-аас зөвлөмж болгож байгаа зааврын дагуу E1 генийн 739 хос сууриас тогтсон фрагментаар генотипийг тогтооходоо үүрэн ПГУ-д гурван өөр цогц давхисан дараалалтай праймеруудыг ашигласан бөгөөд ПГУ-ыг тавих бүрдээ GeneAmp 9700 PCR system-ийн термоциклер (Applied Biosystems, Foster City, CA)-ийг ашиглав. ПГУ-аар эерэг гарсан бүтээгдэхүүнүүдийг QIA quick PCR Product Purification Kit (Qiagen, Germany) ашиглан цэвэрлэв. Цэвэрлэсэн бүтээгдэхүүнүүдийн нүклеотидийн дарааллыг тогтооходоо, тусгай цомог (ABI PRISM Big Dye Terminator cycle sequencing kit), праймеруудыг хамт ашиглаж, ABI PRISM 3100/3130xl DNA sequencer (Applied Biosystems)-ээр шинжлэв. Тогтоосон бүх нүклеотидүүдийн дараалалд филогенетикийн шинжилгээ хийхдээ BioEdit (version 7.0.5.3), SIM-MONIC (version 1.5), MEGA (version 4.1 beta) зэрэг программыг ашигласан болно. Генотипийг тогтоох цонхны хэсэг нүклеотидийн дараалалд (<739 хос суурь) үндэслэн MEGA (version 4.1 beta) программыг ашиглан зэрэгцүүлэн нийлүүлэх аргаар (1,000 bootstraps) филогенетикийн модны зургийг байгуулав.

2009-2010 онд эмчлүүлсэн 4 өвчтөнөөс тууралт гарсны дараах 2 хоногт багтаан цуглувулсан 4 ийлдсэнд улаануудын вирусийн 1E генотип оношлогдов (Сорьцын дугаар: 20, 40, 39, 50). Монгол улсын хүн амын дунд улаануудын вирусийн 1E генотип идэвхтэй эргэлдэж байгаа нь тогтоогдов. Улаанууд өвчиний эрт оношлох, лабораторийн шинжилгээний дүнг батлахад молекулын шинжилгээний арга чухал ач холбогдолтой нь энэ судалгаагаар батлагдаж байна.

### **3.15. Монгол улсад анх удаа бүртгэгдсэн парвовирус B19-ийн халдвартын дэгдэлт**

Р.Түүл<sup>1</sup>, Д.Отгонбаяр<sup>1</sup>, У.Наранчимэг<sup>1</sup>,  
П.Нямдаваа<sup>1</sup>, С.Накакима<sup>2</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв  
<sup>2</sup>Японы Нагояя Хотын Их Сургуулийн Вирус  
Судалын Танхим

Халдварт эритем буюу тавдугаар өвчин, “алгадуулсан хацар” өвчин гэх зэргээр нэрлэгддэг энэ халдварт нь гол төлөв 4–10 наасны хүүхдүүдийг өвчлүүлдэг бөгөөд парвовирус B19-өөр үүсгэгдэнэ. Хэдийгээр халдварт эритемийн эмнэлзүйн онцлог төрх бараг хоёр зууны турш тодорхой мэдэгдэж байсан боловч уг өвчин парвовирус B19-өөр үүсгэгддэг нь дөнгөж 1980-аад оны эхээр тогтоогдож эхэлжээ. Өнөөгийн байдлаар, халдварт эритемийн цорын ганц үүсгэгч нь парвовирус B19 мөн гэдэг нь гаршаагүй батлагдаад байна. Монгол улсад парвовирус B19-ийн халдвартын анхны дэгдэлт 2005 оны дөрөвдүгээр сард

Улаанбаатар хотын Багануур дүүрэгт бүртгэгдсэн билээ.

Халдварт эритем өвчиний түргэн оношлогоонаа ПГУ-ыг хэрэглэсний ач холбогдлыг судлах гол зорилт тавив. Монгол улсад анх удаа бүртгэгдсэн парвовирус B19-ийн халдвартын талаарх нарийвчилсан мэдээлэл нь түүхийн үүднээс чухал ач холбогдолтой юм.

Багануур дүүрэгт бүртгэгдсэн халууралт, тууралттай өвчиний дэгдэлтийн үеэр өвчтөнүүдээс цуглувулсан 22 ийлдсийн сорьцонд улаанбурханы эсрэг өвөрмөц IgM болон улаануудын эсрэг өвөрмөц IgM-ийг тодорхойлох шинжилгээг зах зээл дэх ФХҮ-ын оношлуурууд (Dade Behring Enzygnost/Siemens, Marburg, Germany)-аар тус тус хийхэд энэ хоёр халдварт огт илрээгүй тул, эдгээр сорьцонд энтеровирус болон хүний парвовирус B19-ийн геномын нүклеотидүүд илрүүлэх шинжилгээг ПГУ-аар хийсэн болно. Цуглувулсан сорьцуудаас Isogen-LS (Nippon gene, Japan)-ийг ашиглан ΔΗΧ болоод PHX-ийг ялгав. Энтеровирусийн геномыг илрүүлэхийн тулд VP4 болон VP2 бүсүүдийн үндэсэн хоёр праймер (EVP4F: 5'>CTACTTGGGTGTCCTGTT (551-570) ба OL68-1R: 5'>GGTA AYTTCCACCACCANCC (1197-1178)-ыг ашигласан бол, хүний парвовирус B19-ийн геномыг илрүүлэхийн тулд NS1 болон VP1 бүсүүдийн нүклеотидийн дараалалд үндэслэн бүтээсэн шинэ хоёр праймер (B19-2612F: 5'>GCTTT GTAGATTATGACTAA (2612-2631) ба B19-2894R: 5'>GGTGGTCAGATA ACTGTCCA (2894-2875)-ыг ашиглав. Дээрх праймерууд дахь N-ийн оронд C/G/T, Y-ийн оронд C/T байж болно. ПГУ-ын бүтээгдэхүүний QIA quick PCR Purification Kit (Qiagen, Germany)-ээр цэвэрлэсэн бөгөөд Capillary SEQ 3100 аппарат (Applied Biosystems)-аар нүклеотидүүдийн дарааллыг тогтоолоо.

ПГУ-аар, хүний парвовирус B19-ийн 300 орчим хос сууриас тогтсон нүклеотидийн судал 4 өвчтөний ийлдсэнд илэрсэн бөгөөд эдгээр ийлдсийг тууралт эхлэхээс 7–13 хоногийн өмнө цуглувулсан байв. VP1 бүсийн 2632-aas 2874 дахь нүклеотидүүдийн хоорондох 243 сууриас тогтсон хэсгийн дарааллыг судлан үзэхэд дөрвөн өвчтөнд илэрсэн вирусүүдийн генийн дараалал нь үндсэндээ адилхан боловч, зургаан нүклеотид болон гурван амин хүчлээр хоорондоо ялгаатай, өмнө нь Хшу нарын мэдээлж байсан парвовирус B19-ийн омогтой төсөөтэй вирус болох нь тогтоогдов (Hsu et al., J Gastroenterol Hepatol 20, 733-738, 2005). Монгол улсад анх удаа бүртгэгдсэн халдварт эритем өвчиний үүсгэгч нь хүний парвовирус B19 байсан нь батлагдав. Халууралт болон тууралтай өвчнүүдийг яланг оношлоход орчин үеийн молекул биологийн арга чухал ач холбогдолтойг энэ судалгаа батлан харуулж байна.

### 3.16. Арьсны Т-эст лимфомын үе дэхь хавдрын эсрэг Т-эс ба Т-эпитопийн өөрчлөлт

Ш. Түмэнжаргал<sup>1</sup>, Аансгар Луковски<sup>2</sup>, Сюлке Геерих<sup>2</sup>, Воолфрам Стээры<sup>2</sup>, Пиитр Ваалдэн<sup>2</sup>  
<sup>1</sup>ХААИС, Мал эмнэлэг - Биотехнологийн сургууль,  
Халдварт өвчин - Микробиологийн тэнхим  
<sup>2</sup>Клиникийн судалгааны групп “Өмөн үүгийн дархлаа”  
Шарите, Гүмбодлын анагаахын их сургууль,

Берлин, Герман

Арьсны лимфомийн өмөн үүгийн эсрэг Т эсийн эпитопийг/ӨҮТЭ/ илрүүлэн шинээр нээх болон өмөн үүг устгач Т эсийн дархлааны хариу урвалыг тодорхойлох асуудал нь бидний судалгааны гол зорилго юм. Бид арьсны люмфоматай өвчтөнгийн өмөн үүгийн орчмоос өмөн үүгийн эсрэг устгач Т эсийн 2 клонийг эсийн есгөөвөрт үргүүлж авсан. Клонуудийн таньцын байгалийн болон нийлэг эпитопуудийг пэптид сангийн тусламжтайгаар тодорхойлоход нийлэг эпитоп/мимотоп-ийн Т эсийг идэвхжүүлэх чадвар өндөр гарсан. Эдгээр мимотопоос заримыг нь өмөн үүгийн эсрэг эмчилгээний вакцина хэрэглэсэн. Вакцины эхний үе шатуудад мимотопийн эсрэг Т эсийн тоо олширч мөн тэдгээрийн өмөн үүг устгах чадвартайг ин витро туршлагаар нотолсон.

Өмөн-үүгийн эсрэг энэхүү Т эсийн хариу урвал нь өвчтөний арьсан дахь өмөн-үүг устгаж байсан. Мимотопийн эмчилгээний вакцин нь өмөн-үүгийн эсрэг дархлааны сул хариу урвалыг идэвхжүүлэх боломжтойг харууллаа.

Бидний тодорхойлсон ӨҮТЭ өмөн-үүг доторхи болон захын Т эсийн хариу урвалуудыг тодорхойлох боломжтойг нээж өглөө. Өмөн-үүгийн хүндэрсэн шатны үед эсрэг Т эсүүд нь эфектор санамжтай устгач шинж чанартай байсан боловч устгач эсийн молекулууд дутуу болон бараг байхгүй байсан.

### 3.17. Вирусийн үйлчлэлээр сэдээгдсэн элэгний анхдагч өмөн үсэх механизмыг судлах амьтны загвар

Д.Сувд<sup>1</sup>, Х.Цэрэнсүрэн<sup>1</sup>, Д.Батжав<sup>2</sup>, Х.Цацрал<sup>1</sup>,  
Э.Золзаяа<sup>2</sup>, С.Цоодол<sup>1</sup>, А.Төмөрхүү<sup>1</sup>, Т.Ариунаа<sup>1</sup>,  
Д.Огтонбаатар<sup>2</sup>, Ж.Оюунбилэг<sup>1</sup>  
<sup>1</sup>НЭМХ, <sup>2</sup>БГХӨСҮТ

Монголын хүн амын дунд тохиолдож буй элэгний архаг өвчний тохиолдлын 96,4% нь вирусийн шалтгаантай байна. Мөн элэгний хорт хавдраар өвчлөгсдийн 73.4%-д /Ж. Оюунбилэг, 1996/ гепатит В вирусийн маркер илэрсэн байдаг нь энэ өвчин зонхилон В гепатитын халдвараас үүдэлтэй болохыг

харуулж байна. Иймээс бидний судалгааны зорилго нь элэгний HBV, монгол тарваганы Хепадна (MMHV) вирусийн халдвараас улбаатай вируст гепатит болон түүний даамжрал болох архаг гепатит, элэгний хатуурал, элэгний анхдагч өмөн (ЭАӨ)-гийн явц, механизмыг судлах, мөн эм, эмчилгээ, сэргийлэлтийн зориулалттай бэлдмэлүүдийг турших амьтны *in vivo* загвар гаргаж авахад чиглэгдсэн юм. Монгол тарваганы хепаднавирусийг (MTXB, MMHV) байгаль дахь тарваганы ийлдэсний 42, элэгний 76 сорьц цуглуулж боловсруулалт хийн, ОХҮ-д үйлдвэрлэсэн хүний гепатит В вирусийг оношлоход зориулагдсан “Ампли Сенс HBV-Eph” оношлуурыг ашиглан ПГҮ-ын аргаар шинжлэв. MTXB-ийн халдвэр илэрсэн сорьцуудыг цельсийн -20 хэмд хадгалаж, гаршуулсан тарвагыг халдвартуулах туршилтад ашиглагв.

Гаршуулах хоёр тарвагыг хээрийн судалгаагаар тохиromжтой гэж тогтоосон Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хэрлэн Баян Улааны “Гаталын Хөх Ханан” уул орчим 33249015 сектороос хавх тавьж барин БГХӨСҮТ-д тусгайлан бэлдсэн байранд байршуулж, 5 сарын турш гаршуулан тэжээж, тэжээх явцдаа идэш тэжээлийн бодит орц норм, биеийн жин, халуун, хөдөлгөөн, зан үйлдэл зэрэг үзүүлэлтүүдийг тогтмол хянаж байв.

Тарваганы ийлдэс, элэгний нийт 118 сорьцона хепаднавирусийн ДНХ тодорхойлох шинжилгээг ПГҮ-ийн аргаар хийхэд 9 сорьц нь (+) зэрэг тодорхойлогдов. Гаршуулж тэжээсэн тарвагыг эдгээр сорьцуудаар халдвартуулалт хийхийн тулд амьтантай харьцах халдвэр хамгаалалын дэглэм, эмжүүлэлт хийх, зүрхнээс цус авах, булчинд халдвэр хийх, халдвартгүйжүүлэх зэргийг багтаасан аюулгүй ажиллагааны аргачлалыг боловсруулан ажиллав. Энэ аргачлалын дагуу хоёр тарваганд тус бүр булчин сулруулагч болон нойрсуулагчийг тарьж харзсаны дараа хепаднавирус зэрэг тодорхойлогдсон сорьцоор далны булчинд тарьж халдвартуулалт хийсэн. Халдвартуулатын өмнө тарвага тус бүрээс ‘0’ цусны сорьц авсан. Халдвартуулалт хийснээс хойш хоорондоо сарын зйтайгаар 4-5 удаа цусыг авч ийлдсийг ялан шинжилгээг ПГҮ-аар хийж халдвартын явцыг хянасан болно. Шинжилгээний дүнгээс хархад халдвартуулалт хийснээс хойшхи 1-2 сард халдвэр авсан магадлал илүү байсан. Мөн олон улсын болон НЭМХ дээр Монгол тарваганы хепаднавирусийн талаар урьд хийгдэж байсан судалгаануудын үр дүн, хуримтлуулсан мэдлэгийг энэхүү төслийн хүрээнд хийсэн туршилт судалгааны үр дүнтэй уялдуулан боловсруулж архаг гепатит, элэгний анхдагч өмөнг судлах тэдгээрийн эсрэг үйлчлэлтэй эм биобэлдмэлийг *in vivo* турших амьтны загварыг гарган авав. Амьтны загвар гарган авах судалгааны ажилд дараах ажлуудлыг хамруулан гүйцэтгэв.

Үүнд:

1. Тарвагыг хээрийн бус нөхцөлд байршуулах, тарвага барих, гаршуулах аргачлал боловсруулав.

2. Тарвага дээр туршилт явуулах, тарвагатай харьцах аюулгүй байдлын аргачлал боловсрууж, судалгаа хийв.

3. Эрүүл тарвагыг халдвартуулах чадвар бүхий Монгол тарваганы хепаднавирүс /МТХВ/ яланг МТХВ-ээр халдвартуулах аргачлал боловсруулан тарьж, хэрэглэв.

4. Архаг халдвартыг хянах, хепаднавирүсийн "Х" гений бүтээгдэхүүн болох WHx- ийн нийлэгжлийг шалгах аргачлал боловсруулав.

5. МТХВ-ийн архаг халдвараас үүдэлтэй элгэнд үүсэх хавдрын өөрчлөлтүүдийн маркерууд болох тарваганы элэгний эсийн зохицуулагын p-Myc болон IGF-II генүүдийн нийлэгжлийг шалгах аргачлал боловсруулж, халдвартуулсан тарваганы элэгний эсийн өөрчлөлтийг хянах.

Eye disease caused by adenovirus occupy a large part among the other infectious diseases caused by virus being registered among the population. In our country annually about 11850 patients visited the ophthalmology cabinet of the State Central Clinical Hospital, and from them 1290 cases or 10.89% were diagnosed to have viral infections, including 95% were sick of adenovirus infection, 3.7% had a herpes virus infection, 1.3% infection of other species respectively. We aimed to diagnose eye disease caused by adenovirus infection using the laboratory method. In the research 50 patients aged 18-55 who visited the ophthalmology cabinet of the State Central Clinical Hospital and diagnosed that they were infected with adenovirus were involved. We took the samples from the sediment from eye mucosa, blood, and excrements of the patients and analyzed them using the method of polymerases chain reaction to reveal adenovirus. Totally 50 samples are subjected to the laboratory test and subsequently adenovirus was detected in 43 samples or 86%. Including, adenovirus is detected in 14 samples (or 93%) from 15 samples taken from eye sediment; in 12(80%), from 15 blood samples; in 17(85%) –from 20 samples from excrement respectively. According to age classification: 16(80%) person from 20 people aged 18-30, 13(86.6%) from 15 patients aged 31-40, 14(93.3%) person from 15 people aged 41-50 were infected with adenovirus.

As shown the research result the level of eye disease cases caused by adenovirus is relatively high among the population of our country. In most cases adenovirus is detected in eye sediment or in 93%, which shows that

it is most appropriate to take samples in sediment of eye for laboratory analyze to identify viruses. Also it is assumed that people aged 41-50 are mostly subjected to adenovirus. Diagnosing adenovirus using laboratory method is significant for identifying at the latent period and prove the diagnose.

### 3.21. Identification of Herpes simplex-1 and 2 IgM in patients using ELISA

D. Enkhsaikhan, Ch. Erdenechimeg, J. Baigalmaa  
National Center for Communicable Diseases

Herpes simplex virus infection is commonly spread worldwide. In Mongolia, from 1996 sero-studies to identify virus stain of herpes virus has been undertaken. According Ch. Erdenechimeg (2001), herpes simplex was diagnosed in 78.6% of 607 patients enrolled in the study and it was identified that 76,5% of the diagnosed patients were infected with herpes simplex virus 2 (HSV2). This indicates that herpes infection is commonly spread in the population.

Study participants were selected randomly from the clients of HIV, STI department of the National Center for Communicable Diseases. Total of 230 clients were recruited and serum of the clients were obtained. Serum were tested for HSV 1 and 2 IgM using reagent NovaL-isaTM Herpes Simplex Virus 1+2 (HSV) IgM-ELISA.

No clinical signs were presented in 230 study participants. The participants were age of 18-42 years. HSV 1 and 2 IgM were positive in 18,7 % (43) of all participants in serologic testing. This indicates presence of asymptomatic herpes simplex virus infection in the participants.

In 18,7 % of study participants, HSV 1 and 2 IgM positive and herpes simplex virus presented asymptomatic infection in these patients.



ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА

Мультиплекс бх-ПГҮ болон R-Mix хибрид эсийн өсгөвөрийн аргаар  
амьсгалын замын вирусүүдийг илрүүлсэн дүн

Ч.Майцээг<sup>1</sup>, Н.Баясгалан<sup>1</sup>, С.Цацрал<sup>1</sup>, Б.Дармаа<sup>1</sup>, П.Нямдаваа<sup>1,2</sup>

Халдварт өвчин судаллын үндэсний төв, Вирус судаллын лаборатори<sup>1</sup>

Монголын анагаах ухааны академи<sup>2</sup>

Монгол улсад 2003-2007 онд бүртгэгдсэн ТТӨ оноштой өвчтөнүүдээс цуглуулсан эмнэлзүйн 7073 сорьшны 691(6.8%)-д л томуугийн вирус илэрсэн байна [1]. Нүклейн хүчилд суурьласан арга хэрэглэснээр томуугийн вирусийн илрэлт 20-25% хүртэл нэмэгддэг тул ДЭМБ 2009 оноос энэ аргыг өдөр тутмын оношлологоонд ашиглаж эхлэхийг ТҮТ-үүдэд зөвлөмж болгосон билээ (ДЭМБ). Гэвч ТТӨ үүсгэгчийн 70-80% нь тодорхой бус байсаар байгаа бөгөөд судлаачид түргэвчилсэн оношлолын олон аргуудыг туршин хэрэглэсэн боловч тулхтай үр дүн хүрч чадахгүй байгаа юм.

Харин сүүлийн үед олон төрлийн вирусийг нэгэн зэрэг илрүүлэх ПГҮ-ын (мультиплекс бх-ПГҮ) аргыг энэ зорилгоор хэрэглэж буй нь судлаачдын анхаарлыг татаж байна. Тухайлбал J.Mahony, S.Chong, F.Merante нар 20 төрлийн амьсгалын замын үүсгэгч илрүүлэх боломжтой ПГҮ-ын аргыг туршин 294 хамарзалгиурын арчдасанд судалгаа хийж үзэхэд уг арга нь дархан тяяаралт бичил харуурын арга болон эсийн өсгөвөрөөс илүү мэдрэг төдийгүй клиникийн лабораториод уламжлалт аргуудаар илрүүлэх боломжгүй амьсгалын замын өвчин үүсгэгчийг 43%-аар нэмж илрүүлж байна гэдгийг тогтоосон байна [2].

Манай лабораториод ТТӨ оноштой өвчтөнөөс авсан хадгалагдаж буй (архивын) сорьсонд үүсгэгчийн бүрэлдэхүүнийг тодорхойлох шинжилгээг мультиплекс бх-ПГҮ-аар тодорхойлж туршсан С. Цацрал нарын судалгаагаар уг аргыг хэрэглэснээр ТТӨ-тэй хүний амьсгалын замын сорьшны 40-70%-д нь үүсгэгчийг илрүүлэх боломжтой [3] гэсэн нааштай үр дүн гарсанд үндэслэн энэ аргыг ТТӨ-ний вирус судаллын байнгын тандалтанд нэвтрүүлэх бололцоог турших зорилгоор бид энэ судалгааг хийсэн юм.

**Материал, арга зүй:**

Эмнэлзүйн сорьц: 2010 оны 10 дугаар сараас 2011 оны 7 дугаар сарыг дуусталх хугацаанд томуугийн харуулдан тандалтын нэгжүүдээс (TXTN) цуглуулсан, бх-ПГҮ-ын аргаар шинжлэхэд томуугийн вирус илрээгүй 661 хамар, залгиурын арчдасыг эмнэлзүйн сорьц болгон авч шинжлэгдэхүүнийг 4°C-ын температурт хамгийн удаандаа 24 цаг (шинжилгээний явцад), уг шинжилгээг хийх хүртэл -70°C-д хадгалав.

Сорьшнуудаас нийт нүклейн хүчлийг ExiPerg™( Pioneer, Korea) автомат ялгач ашиглан ялагв.

I хэсэг: Мультиплекс бх-ПГҮ-ын арга ашиглан амьсгалын замын вирус илрүүлэх: Люксембургийн Fast Track Diagnostics пүүсийн амьсгалын замын өвчин үүсгэгч (томуугийн А ба В вирус, цар тахалын A(H1N1) вирус, иж томуу 1, 2, 3, 4 вирус, риновирүс, коронавирүс (NL63, OC43, 229E, HKU1), амьсгалын замын синциталь вирус, хүний метапневмовирүс, аденоирүс, бокавирүс, энтеровирүс, парэховирүс болон Mycoplasma pneumoniae) илрүүлэх шинжилгээг мультиплекс ПГҮ-ын аргыг ашиглан үйлдвэрлэгчийн зааврын дагуу Applied Biosystems-ийн Fast Real-Time PCR System 7500 машинаар хийж гүйцэтгэв.

Урвалын нийт холимог 25 мкл: 1 мкл '25x RT PCR enzyme mix', 12.5 мкл '2xRT PCR buffer' ( AgPath-ID One-Step RT-PCR Kit ), 1.5 мкл PP mix ( FTD respiratory pathogens 21 kit ) байв.

ПГҮ-ын программ : Реверс транскрипцын шат 50°C-д 15 мин, денатурац 95°C-д 10 мин, нийт 40 цикл 95°C-д 8 сек, 60°C-д 34 сек урвал явагдана.

II хэсэг: ΔТБХ-ын аргаар ТТӨ үүсгэгч вирус илрүүлэх: 2010 оны 10 дугаар сараас 2011 оны 4 дүгээр сарыг дуусталх хугацаанд томуугийн харуулдан тандалтын нэгжүүдээс (TXTN) цуглуулсан 274 сорьсонд "DIAGNOSTIC HYBRIDS" пүүсийн хурдавчилсан R-Mix эсийн өсгөвөр болон амьсгалын замын вирус илрүүлэх оношлуурын цомгийг ашиглан ΔТБХ-ын аргаар ТТӨ үүсгэгч вирус илрүүлэх шинжилгээг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хийв.

Үнэсэн зарчим: R-mix хибрид эсийн өсгөвөрт сорьцоо халдааж 24-72 цаг өсгөвөрлөсний дараа 'DFA respiratory virus screening reagent' ашиглан будаж флюресцент микроскопоор харж үр дүнг тодорхойлно.


**Судалгааны үр дүн:**

I хэсэг: Судалгаанд 661 эмнэлзүйн сорьшыг шинжлэгдэхүүн болгон авч нүклейн хүчлийг ExiPerg™( Pioneer, Korea) автомат ялгачаар яланг Applied Biosystems-ийн Fast Real-Time PCR System 7500 машинаар оношлогоог хийж гүйцэтгэв. Нийт 661 сорьшны [хүйсийн харьцаа эр/эм=321/340; дундаж нас 10 нас; насны хязгаар 0.2-78 нас] 310(46.9%)-д нь 19 үүсгэгч ээрэг тодорхойлогдсон байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

## Мультиплекс бх-ПГҮ-аар илрүүлсэн ТТӨ-ний үүсгэгчийн бүрэлдэхүүн

Үүсгэгчийн төрөл	Илрэлт		Хүйсийн харьцаа эр/эм	Дундаж нас
	тоо	%		
Амьсгалын замын синциталь вирус	59	8.9	31/28	2.3
Хамсарсан халдвэр	46	7	20/26	5.4
Риновириүс	45	6.8	23/22	9.1
Иж томуугийн вирус	39	5.9	19/20	5.1
I хэвшинж	3	7.7	1/2	5.6
II хэвшинж	1	2.6		
III хэвшинж	25	64	12/13	6.2
IV хэвшинж	10	26	5/5	2.3
Томуугийн вирус	30	4.5	16/14	6.8
A(H1N1)Pnd	6	20	4/2	1.3
Коронавириүс	27	4	12/15	13
229E	5	18.5	3/2	16
NL63	3	11	2/1	1.3
OC43	12	44	4/8	19.9
HKU1	7	26	2/5	4.1
Хүний метапневмовириүс	24	3.6	12/12	2.7
Аденовириүс	20	3	12/8	4.6
Энтеровириүс	10	1.5	7/3	3.5
Хүний бокавириүс	8	1.2	1/7	11.5
<i>Mycoplasma pneumonia</i>	2	0.3	1/1	3
Эрэг	310	46,9	155/155	5,9
Сөрөг	351	53,1	166/185	14,1
Нийт сорьц	661	100	321/340	10




Зураг 1. 2010 оны 10-р сараас 2011 оны 07-р сар хүртэл хугацаанд цуглүүлсэн сорьшноос илрүүлсэн үүсгэгчийн эзлэх хувь

2010/2011 оны томуугийн улирлын туршид амьсгалын замын синциталь вирус, риновириүс, иж томуугийн вирус давамгайлан тохиолдсон байна. Амьсгалын замын синциталь вирус, хүний метапневмовириүс, иж томуугийн вирус, адено-вириүс болон *Mycoplasma pneumonia* нь бага насны хүүхдэд; риновириүс, томуугийн А вирус, коронавириүс, хүний бокавириүс нь сургуулийн насны хүүхдэд голчлон амьсгалын замын өвчин үүсгэж байгаа зураглал ажиглагдаж байна. Судалгааны үр дүнгээс харахад амьсгалын замын өвчин үүсгэгчид нь наснаас хамааралтайгаар өвчлөл үүсгэж байна. ( $\square=.0001$ )


Мультиплекс бх-ПГҮ-ын арга нь эмнэлэгийн нэг сорьсон дахь үүсгэгчидийн хамсарсан халдвартыг нэг цаг үед илрүүлэх боломжтой юм. Манай судалгаанд авсан нийт сорьцны 7% нь 2 үүсгэгчээр хам халдвартасан байна. Үүний 28.3% нь амьсгалын замын синциталь вирус бусад вирустэй, 17.4% нь томуугийн

А вирүс бусад үүсгэгчтэй, 17.4% нь риновирыс бусадвирустэй, 17.4% нь адено-вирус бусад үүсгэгчтэй, 13% нь хүний бокавирыс бусад вирүстэй, 6.5% нь иж томуугийн вирүс коронавирыс, энтеровирыстэй хамсарсан халдварт үүсгэнээс голчлон риновирыс нь хүний бокавирыстэй; хүний метапневмовирыс нь адено-вирустэй; амьсгалын замын синциталь вирүс нь риновирыс, иж томуугийн вирүс 3-р хэвшинж, адено-вирустэй хам халдвартаж байгаа зүй тогтол харагдад. (Зураг-2)




Зураг 2. 2010 оны 10-р сараас 2011 оны 07-р сар хүртэл хугацаанд цуглувансорьшноос илрүүлсэн вирүсийн хамсарсан халдварт

Амьсгалын замын өвчин үүсгэгч вирүсүүд болох томуугийн А вирүс, коронавирыс, иж томуугийн вирүс, хүний метапневмовирыс нь өвлийн саруудад; амьсгалын замын синциталь вирүс нь хаврын сар, зуны эхний сард; адено-вирус, риновирыс нь жилийн туршид; энтеровирыс хаврын саруудад эргэлтэнд байсан зураглал харагдаж байна. (Зураг-3 )



Зураг 3. 2010 оны 10-р сараас 2011 оны 07-р сар хүртэлх хугацаан дахь амьсгалын замын өвчин үүсгэгчийн хөдлөлзүй


Дүнг нэгтгэн үзвэл 2010 оны 40-43 дугаар долоо хоногт иж томуугийн вирүс, риновирыс, адено-вирус; 2010 оны 44 дүгээр долоо хоногоос 2011 оны 5 дугаар долоо хоногт томуугийн дэгдэлтэй зэрэгцэн коронавирыс, метапневмовирыс; 2011 оны 6-18 дугаар долоо хоногт амьсгалын замын синциталь вирүс, риновирыс; 2011 оны 19-26 дугаар долоо хоногт иж томуугийн вирүс, амьсгалын замын синциталь вирүс давамгайлан тохиолдсон байна. (Зураг-4)



Зураг 4. Монгол улсад 2010-2011 онд бүртгэгдсэн өвчлөлтэй харьцуулсан байдал


II хэсэг: Нийт цуглувансон 661эмнэлзүйн сорьшноос 2010 оны 10 дугаар сараас 2011 оны 4 дүгээр сар хүртэлх хугацааны 274 сорьшонд амьсгалын замын өвчин үүсгэгчийг мультиплекс бх-ПГҮ-ын арга болон R-mix хибрид эсийн өсгөврийн арга ашиглан илрүүлж тус хоёр аргын мэдрэг болон өвөрмөц чанарыг харьцуулж үзлээ.

I бүлэг: Мультиплекс бх-ПГҮ-ын аргаар нийт 274 эмнэлзүйн сорьшонд үүсгэгч үзэхэд [хүйсийн харьцаа эр/эм=116/158; дундаж нас 10 нас; насын хязгаар 0.2-73 нас] 137(50%) сорьшонд 13 үүсгэгч эерэг тодорхойлогдсон байна. Үүнд 21(7.7%) нь томуугийн А вирүс, 17(6.2%) нь адено-вирус, 14(5.1%) нь амьсгалын замын синциталь вирүс, 23(8.4%) нь иж томуугийн вирүс, 12(4.4%) нь коронавирыс, 4(1.5%) нь энтеровирыс, 5(1.8%) нь хүний бокавирыс, 15(6.0%) нь хүний метапневмовирыс, 1(0.4%) нь Mycoplasma pneumoniae, 20(7.3%) нь риновирыс, 5(1.8%) нь хамсарсан халдварт тус тус байлаа. (Зураг-5)



Зураг 5. Мультиплекс бх-ПГҮ-ын аргаар илэрсэн үүсгэгч

II бүлэг: R-mix хибрид эсийн өсгөврийн аргаар нийт 274 эмнэлзүйн сорьшонд амьсгалын замын өвчин үүсгэгч 4 төрлийн 7 хэвшинжийн вирүс үзэхэд [хүйсийн харьцаа эр/эм=116/158; дундаж нас 10 нас; насын хязгаар 0.2-73 нас] 30(11%) сорьшонд амьсгалын замын өвчин үүсгэгч 4 төрлийн вирүс эерэг тодорхойлогдсон байна. Үүнд 7(2.6%) нь томуугийн А вирүс, 7(2.6%) нь адено-вирус, 7(2.6%) нь амьсгалын замын синциталь вирүс, 9(3.2%) нь иж томуугийн вирүс байлаа. (Зураг-6)



Зураг-6. R-mix хибрид эсийн өсгөвөрийн аргаар илэрсэн вирус

Оношлогооны аргуудын харьцуулалт: Судалгааны материал болох 274 шинжлэгдэхүүнд амьсгалын замын өвчин үүсгэгч 4 төрлийн 7 хэвшинжийн вирусийг R-Mix хибрид эсийн өсгөвөрт тодорхойлсон үр дүнг мультиплекс бх-ПГУ-ын аргаар тодорхойлсон үр дүнтэй харьцуулахад дараах үзүүлэлттэй байна. (Хүснэгт 2 )

Хүснэгт 2

ТТӨ үүсгэгч вирус	R-Mix эсийн өсгөвөр	Мультиплекс бх-ПГУ
Томуугийн A вирус	7	21
Томуугийн B вирус	0	0
Амьсгалын замын синциталь вирус	7	14
Аденовирус	7	17
Иж томуугийн вирус 1	0	2
Иж томуугийн вирус 2	0	0
Иж томуугийн вирус 3	9	19
Эрэг	<b>30 (11%)</b>	<b>73 (26.6%)</b>
Сөрөг	<b>244(89%)</b>	<b>201(73.4%)</b>
<b>Нийт сорьц</b>	<b>274(100%)</b>	<b>274(100%)</b>

#### R-Mix эсийн өсгөвөрт өсгөвөрлөгдсөн үр дүнг мультиплекс бх-ПГУ-н үр дүнтэй харьцуулсан байдал

R-mix хибрид эсийн өсгөвөрт өсгөвөрлөн ДТБХ-ын аргаар тодорхойлсон үр дүнг мультиплекс бх-ПГУ-ын аргаар тодорхойлсон үр дүнтэй харьцуулсан хүснэгтээс харахад томуугийн А хүрээний вирус 33.3%, амьсгалын замын синциталь вирус 50%, аденоовирус 41.2%, иж томуугийн вирус 3-р хэвшинж 47% тус тус тохирч байна. Харин иж томуугийн 1-р хэвшинжийн вирусийн хувьд R-mix эсийн өсгөвөрт өсгөвөрлөгдсөн үр дүн нь мультиплекс бх-ПГУ-ын аргаар тодорхойлсон үр дүнтэй нийцэхгүй байна. Мультиплекс бх-ПГУ-ын мэдрэг болон өвөрмөш чанар, ээрэг болон сөрөг үр дүнгийн үзүүлэлтийг 100% гэж тооцвол R-mix хибрид эсийн өсгөвөрийн хувьд мэдрэг чанар нь 41%, өвөрмөц чанар нь 100%, ээрэг үр дүнгийн үзүүлэлт 100%, сөрөг үр дүнгийн үзүүлэлт 82% байна. Мультиплекс бх-ПГУ-ын арга нь R-mix хибрид эсийн өсгөвөрийн аргаас үүсгэгч илрүүлэх чадварын хувьд давуу байна гэсэн дүгнэлтийн үнэн магадтай эсэхийг статистикийн Хи-квадрат ( $\chi^2$ ) -ын шалгуураар шалгаж үзэхэд  $p=0,001$  буюу 99.9%-ийн үнэн магадтай байна.

#### Хэлшэмж:

Судалгааны I хэсэгт бил ТТӨ гэж оношлогдсон

эмнэлзүйн сорьцонд амьсгалын замын өвчин үүсгэгчид болох томуугийн А вирус, цар тахалын A(H1N1) вирус, иж томуу 1, 2, 3, 4 вирус, риновирус, коронавирус ( NL63, OC43, 229E, HKU1 ), амьсгалын замын синциталь вирус, хүний метапневмовирус, аденоовирус, бокавирус, энтеровирус, болон Mycoplasma pneumoniae-г мультиплекс бх-ПГУ-ын аргаар илрүүлээ. Судалгааны үр дүнг харахад 2010/2011 оны томуугийн улирлын туршид манай оронд тогтмол 5-9 төрлийн үүсгэгч нэг цаг хугацаанд зэрэгцэн эргэлтэнд байсан бөгөөд амьсгалын замын синциталь вирус, риновирус, иж томуугийн вирус давамгайлан тохиолдсон байна. Бидний өмнө нь хийсэн эргэмж судалгаагаар 2008/2009 оны томуугийн улиралын туршид риновирус, иж томуугийн вирус, бокавирус давамгайлан тохиолдож байсан [3] нь манай энэ удаагийн судалгааны үр дүнтэй ерөнхийдөө тохирч байна. Мөн бидэнтэй төстэй судалгаа хийсэн зарим орны судлаачдын үр дүнтэй манай үр дүн ойролцоо гарч байна. Тухайлбал Хонг Конгд амьсгалын замын өвчиний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүүхдүүдээс 12 сарын хугацаанд цуглуулсан 475 сорьцонд мультиплекс ПГУ-ын аргаар 20 амьсгалын

замын өвчин үүсгэгч илрүүлсэн судалгааны үр дүнгээр 47% нь эерэг үр дүнтэй байснаас томуу, иж томуугийн вирус болон амьсгалын замын синциталь вирус 51%-ийг нь эзэлж байсан [4] бол Германда хийгдсэн судалгаанд 1995 оны 11-р сараас 1998 оны 4-р сар хүртэлх хугацаанд цуглуюулсан сорьцноос амьсгалын замын өвчин үүсгэгч илрүүлэхэд 395(35%) нь эерэг тодорхойлогдсон ба илэрсэн үүсгэгчийн 37.5% нь амьсгалын замын синциталь вирус, 20% нь томуугийн A вирус, 12.9% нь адено вирус, 10.6% нь энтеровирус байсан байна [5].

2010/2011 онд амьсгалийн замын өвчин үүсгэгч вирусүүд болох томуугийн A вирус, коронавирус, метапневмовирус нь өвлүйн саруудад; амьсгалын замын синциталь вирус нь хаврын сар; адено вирус, риновирус нь жилийн туршид эргэлтэнд байсан нь бас бидний өмнөх судалгааны үр дүнтэй тохирч байна.

Бусад судалгааны дүнтэй харьцуулахад амьсгалын замын халдвартын 1-5% нь адено вирусээр үүсгэгдэг ба адено вирус нь жилийн туршид эргэлтэнд байсан [6], риновирус нь жилийн туршид халдварт үүсгэх ба халдвартын оргил ўе нь хаврын улирал, намрын сүүлээр байсан [7], хүний метапневмовирус зонхилон өвөл хаврын саруудад тохиолдох ба амьсгалын замын синциталь вирусийн халдвартай давхцах юмуу өмнө нь өвчлөл үүсгэх [8] бөгөөд нийт амьсгалын замын өвчний 6.9% нь энэ вирусээр сэдээгдэг, коронавирус нь амьсгалын замын өвчлөлийн 5-30%-ийг үүсгэдэг [9] зэрэг нь манай үр дүнтэй дүйж байна.

Мультиплекс бх-ПГУ-ын арга нь эмнэлзүйн нэг сорьцон дахь вирусүүдийн хамсарсан халдвартыг нэг цаг үед илрүүлэх боломжтой юм. Манай судалгаанд авсан нийт сорьцны 7% нь хоёр вирусээр хам халдвартасан байна. Бидний өмнөх судалгаагаар 8.2% нь хоёр вирусээр хам халдвартасан байсан [4]. Мөн Jong-Han Lee, Jin-Kyong нарын хийсэн бидэнтэй төстэй судалгаанд 6.8%-тай хамсарсан халдварт тохиолдсон байна[10].

Судалгааны II хэсэгт мультиплекс бх-ПГУ-ын арга болон хибрид эсийн өсгөврийн арга хоёрын мэдрэг болон өвөрмөц чанарыг харьцуулан үзэхэд мультиплекс бх-ПГУ-ын мэдрэг болон өвөрмөц чанар, эерэг болон сөрөг үр дүнгийн үзүүлэлт нь бүгд 100% байсан бол хибрид эсийн өсгөврийн хувьд мэдрэг чанар нь 41%, өвөрмөц чанар нь 100%, эерэг үр дүнгийн үзүүлэлт 100%, сөрөг үр дүнгийн үзүүлэлт 82% байна. Иймээс мультиплекс бх-ПГУ-ын арга нь R-mix хибрид эсийн өсгөвөртэй харьцуулахад мэдрэг чанар болон сөрөг үр дүнгийн үзүүлэлтээрээ давуу байна.

Гадны бусад орнуудад хийгдсэн бидний хийсэн судалгаатай төстэй судалгаануудад мультиплекс ПГУ-ын арга нь уламжлалт аргууд болох эсийн өсгөвөр, дархан туяаралт бичил харуурын арга зэргээс илүү мэдрэг болох нь харагдаж байна. W. Y. Lam, Apple C.

M. Yeung нар 303 эмнэлзүйн сорьцонд дээрх аргуудаар оношлогоо хийж үзэхэд вирус илрэлт мультиплекс ПГУ-ын аргын хувьд 48.5%, эсийн өсгөврийн хувьд 20.1%, дархан туяаралт бичил харуурын аргаар 13.5% байсан байна. Мөн J. Mahony, S.Chong нарын хийсэн мультиплекс ПГУ-ыг аргыг эсийн өсгөвөр/дархан туяаралт бичил харуурын аргатай харьцуулсан судалгаагаар мультиплекс ПГУ нь дээрх аргаас 42%-аар илүү вирус илрүүлж байсан [11]. Melanie W. Syrmis, David M. Whiley, Marion Thomas, M. Mackay нарын судалгаанд амьсгалын замын халдварт бүхий 598 өвчтөний хамар залгиурын арчдасанд мультиплекс бх-ПГУ болон дархан туяаралт бичил харуурын аргаар амьсгалын замын эмгэг төрөгч үзэхэд мультиплекс бх-ПГУ-ын аргаар нийт 598 сорьцны 202(33.7%)-д вирус эерэг тохиолдсон бол дархан туяаралт бичил харуурын аргаар 179(29.9%) нь эерэг байсан байна. Мультиплекс бх-ПГУ-ын арга нь бүх вирусийн хувьд дархан туяаралт бичил харуурын аргаас мэдрэг байсан байна. [12]

### Дүгнэлт

Мультиплекс бх-ПГУ-ын шинжилгээг ТТӨ-ний үүсгэгч тодорхойлох байнгын шинжилгээ болгох нь зүйтэй.

### Номзүй

1. Darmaa B, Tsatsral S, Naranzul T, Enkhsaikhan D, Burmaa A, Nymadawa P. (**2009**): Influenza virus strains circulating in Mongolia in 2003-2007, *Mongolian Journal of Health Science*, 6(1):8-19.
2. J. Mahony, S. Chong, F. Merante, S. Yaghoubian (2007): Development of a Respiratory Virus Panel Test for Detection of Twenty Human Respiratory Viruses by Use of Multiplex PCR and a Fluid Microbead-Based Assay, *J. Clin. Mic* 45(9):2965-2970
3. Tsatsral.S, Maitsetseg.Ch, Darmaa.B, Nymadawa.P,(2010):Dynamics of respiratory viruses circulating in Mongolia in (**2008-2009**), *Mongolian Journal of Infection Disease Research*, 1(38):8-11
4. Sung RY, Chan PK, Tsen T, Li AM, Lam WY, Yeung AC, Nelson EA. (**2009**): Identification of viral and atypical bacterial pathogens in children hospitalized with acute respiratory infections in Hong Kong by multiplex PCR assays. *J Med Virol*, 81(1):153-9.
5. Griffin, M.R., F.J.Walker, M.K.Iwane, G.A.Weinberg, M.A.Staat, and D.D. Erdman. (**2004**): Epidemiology of respiratory infections in young children: insights from the new vaccine surveillance network. *J Pediatr. Infect. Dis* ,23:S118-S192
6. American Academy of Pediatrics. (**2003**): Adenovirus infections, p. 190-192. Red book 2003. Report of the Committee on Infectious Diseases, 26th ed . *American Academy of Pediatrics*, Elk Grove Village, IL
7. James B. Mahony, Regional Virology Laboratory, St. Joseph's Healthcare Hamilton, and Department of Pathology and Molecular Medicine, McMaster Uni

- versity, Hamilton, Ontario, Canada. (2008): Detection of respiratory viruses by molecular methods. *J Clinical Microbiology*, 21(4): p.716-747
8. Mackay, I.M., S. Bialasiewicz, Z. Waliuzzaman, G.R. Chidlow, D.C. Fegredo, S. Laingam, P. Adamson, G. B. Harnett, W. Rawlinson, M. D. Nissen, and T. P. Sloots. (2004): Use of P gene to genotype human metapneumovirus identifies 4 viral subtypes. *J.Infect. Dis.* 190:1913-1918.
9. Vabret, A., T. Mourez, S. Gouarin, J. Petitjean, and F. Freymuth.(2003): An outbreak of OC43 coronavirus respiratory infection in Normandy France. *J Clin. Infect. Dis.* 36:985-989.
10. Jong-Han Lee, Jin-Kyong Chun, Dong Soo Kim, Yongjung Park, Jong Rak Choi and Hyon-Suk Kim, (2010): Identification of Adenovirus, Influenza virus, Parainfluenza virus and Respiratory syncytial virus by Two kind of Multiplex Polymerase Chain Reaction and a Shell Vial Culture in Pediatric Patients with Viral Pneumonia. *J. Yonsei. Med.* 51(5):761-767
11. Britta Grondahl, Wolfram Puppe, Andrea Hoppe, Inka Kuhne, Josef A. I. Weigl, and Heinz-Josef Schmitt(1999): Rapid Identification of Nine Microorganisms Causing Acute Respiratory Tract Infections by Single-Tube Multiplex Reverse Transcription-PCR: Feasibility Study. *J.Clin.Mic.* 37:1-7
12. Melanie W. Syrmis, David M. Whiley, Marion Thomas, Ian M. Mackay, Jeanette Williamson, David J. Siebert, Michael D. Nissen, and Theo P. Sloots(2004): A Sensitive, Specific, and Cost-Effective Multiplex Reverse Transcriptase-PCR Assay for the Detection of Seven Common Respiratory Viruses in Respiratory Samples. *J Mol.Diagnostics. vol* 6, no 2.

Талархал: Энэхүү судалгааны тандалтын хэсгийг санхүүжүүлсэн “Томуугийн тандалтын сүлжээг бэхжүүлэн хөгжүүлэх” Монгол-АНУ-ын хамтарсан төсөл IU51IIP000331 болон сорьц цуглуулахад туслашaa γзүүлсэн ТХТН-γγΔЭД талархсанaa илэрхийлье.

*Танилшаж, нийтлэхийг зөвшөөрсөн сэтгүүлийн зөвлөлийн гишүүн,  
анагаах ухааны доктор Р.Түүл*



Товч мэдээ, ажиглалт

**Адууны томуугийн A(H3N8) вирусийн  
халдварт оношлогдлов**

2011 оны 7 дугаар сарын 05-нд Хүй долоон худаг орчмын уяачдын уяж байгаа морьдод ханиах, хамраас усархаг, өтгөн идээтэй гоождос гарах шинж тэмдэг илэрсэн тул адуунаас авсан дээжинд Улсын Мал Эмнэлэг Ариун Цэврийн Төв Лабораторийн малын гоц халдварт өвчний оношлогоо, тандалтын лабораториод шинжилгээ хийхэд адууны томуугийн A(H3N8) хэвшлийн вирусийн халдварт болохыг оношлов.

Мөн Улаанбаатар хот, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар аймгуудаас дээж ирүүлсэн байна. Адууны томуу гарсантай холбогдуулан уг өвчинтэй тэмцэх зааврын дагуу арга хэмжээ авах, тандалт хийж өвчлөл, тархалтын талаар бодитой мэдээлэл цуглуулах, үзлэг шинжилгээ хийх ажлыг зохих шатны мал эмнэлгийн газруудад өгч ажиллуулах шаардлагатай байна.

**Д.Батчулуун**

**Хепацивиrus нохойд амьсгалын замын  
цочмог халдварт сэдээдгийг ирүүлэв**

Хүний хепатитийн C вирус (HCV - HCV: hepatitis C virus) нь нэг утаслаг PHX агуулсан, бөмбөлөг вирус бөгөөд флавивирусийн овгийн хепацивирусийн

төрөлд хамааруулдаг юм. Энэ вирус хүнд архаг хепатит сэдээдэг ба одоогоор эсийн өсгөвөрт болон хүнээс өөр амьтанд халдвартуулж чадаагүй байгаа билээ [1]

Гэтэл саявтар АНУ-ын хэсэг судлаачид амьсгалыни замын цочмог халдварт (АЗЦХ) бүхий нохойн хамрын арчдаснаас нэг төрлийн вирус ирүүлсэн нь хэд хэдэн генийнхээ нуклеотидын дарааллаар ХСВ-тэй ижил төрхтэй байсан тул нохойн хепатитын вирус (HXB – CHV canine hepatitis virus) хэмээн нэрлэжээ [2]. АЗЦХ-ын 5 дэгдэлтийн үед цуглуулсан 33 нохойн хамрын арчдсанда НХВ-ийн хеликазын ген ирүүлэх пример ашиглан бх-ПГУ тавьж үзэхэд 60-67%-д нь эерэг гарсан нь энэ вирус нохойн популяцид АЗЦХ үүсгэх нь элбэг байж магадгүй гэж үзэхэд хүргэжээ.

Энэ шинэ олдвор нь амьсгалын замын вирус судлачлад бас нэг шинэ вирус судлах зам нээж буй бол, хепацивиrus судлаачдад хүний хепатитын судалгааны нэг шинэ загвар нээж байгаагаараа эрдэмтдийн анхаарлыг ихээхэн татаж байна.

**Номзүй:**

1. Hepatitis C virus, [http://en.wikipedia.org/wiki/Hepatitis\\_C\\_virus](http://en.wikipedia.org/wiki/Hepatitis_C_virus), accessed on August 10, 2011;

2. Kapoor, A., Simmonds, P., Gerold, G. Et al (2011): Characterization of a canine homolog of hepatitis C virus, PNAS, 108 (28);11608-11613;

**П.Нямдаваа**

**Австралил Хендра вируст халдварт эрэс  
нэмэгджээ**

Энэ оны 6 дугаар сараас эхлэн Австралийн зүүн эргийн муж улсуудад Хендра (Hendra) вируст халдвартын 12 бичил дэгдэлт гарч 78 адuu өвчлөж, 5 нь үхсэн [1] нь энэ вирусийг анх 1994 онд Австралийн Квинсленд муж улсын төв Брисбен хотын ойролцоо Хендра тосгонд ирүүлэн бичсэнээс [2] хойш бүртгэгдсэн бүх дэгдэлт, хамрагдсан адууны нийлбэр тооноос даваад байгаа тул Австралийн мал эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн албад нэмэлт арга хэмжээ авч эхэлсэн байна [3].

Малайзид гахайнаас ирүүлсэн [4] Нипа (Nipah) вирустэй хамтатган Хендра вирусийг Paramyxoviridae овгийн Henipavirus хэмээн нэрлэсэн шинэ төрөл болгон ангилаад байгаа юм. Энэ вирусийн байгалийн эзэн нь Pteropodidae овгийн нэгэн зүйл дулаан орны сарьсан багваахай гэж үзэж байгаа бөгөөд адуунаас хүнд ахуйн хавьтлын замаар дамжин халдаж, 50% хүртэлэндэгдэлтэй өвчин үүсгэх боломжтой аж. Хүний өвчин нь 5-14 хоногийн нууц үеийн дараа ТТӨ хэлбэрээр эхлээд дараа нь дагжих, хүчтэй толгой өвдөх, толгой эргэх, унтамхай болох зэрэг шинж тэмдгүүд давамгайлж, энфецилтийн нас бардаг байна [5].

Энэ удаагийн дэгдэлтийн үеэр хийсэн идэвхитэй тандалтын үр дүнд Хендра вирусийн эсрэгбиенийг гэрийн тэжээвэр нохойд анх ирүүлсэн нь энэ вирусийн халдан тархах амьтдын зүйлийн тоог нэмэгдүүлсэн тул судлаачид, малын болон нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг сээрэмжлэх арга хэмжээ авахад хүргэж, зарим талаар мал дагасан бизнесийн үйл ажиллагаанд саад учруулж эхлээд байгаа аж [6-8]. Энэ удаагийн дэгдэлтийн үеэр хүний өвчлөл, эндэгдэл бүртгэдээгүй байгаа юм байна [1, 3]. Гэвч ажил төрөл, аялал жуулчлааар Австрали болон Малайз, Энэтхэг, Индонез г.м. Зүүн-өмнөд азийн дулаан орноор зорчих хүмүүс Хендра болон Нипа вируст халдварт гарч буй буюу гарч байсан нутаг дэвсгэрээр аялахгүй байх, адуй, гахай, нохой зэрэг мал, амьтанд шүүд хүрэлцэхгүй байх зэрэг болгоомжлох арга хэмжээ авах нь зүйтэй.

**Номзүй:**

1. Hendra virus outbreak 2011, <http://www.abc.net.au/news/specials/hendra-virus/> accessed on August 14, 2011;

2. Murray, K., Selleck, P., Hooper, P. et al., (1995): A morbillivirus that caused fatal disease in horses and humans, Science, 268: 94-97;

3. Call for urgent action amid hendra virus speke, <http://www.abc.net.au/news/2011-07-25/call-for-urgent-action-amid-hendra-virus-spike/2808598> accessed on August 14, 2011;

4. Chua, K.B., Bellini, W.J., Rota, P.A. et al. (2000): Nipah virus: a recently emergent deadly paramyxovirus, Science, 288: 1432-1435;

5. Henipavirus, <http://en.wikipedia.org/wiki/Henipavirus> accessed on August 16, 2011;

6. Deadly horse virus found in dog, <http://www.google.com/hostednews/afp/article>

**П.Нямдаваа**

## Бодрол бясалгал

Ричард Престон

### ГОЦ АЮУЛАЙ БҮС (Вируст халдвартын тухай бодит түүх)

Үргэлжлэл  
Түрүүч нь манай сэтгүүлийн  
2011 оны №3(40) дугаарт

Эбола вируст цусархаг чичрэг бол халдвартавсан 10 хүн тутмын 9 нь эндэж төгсдөг аюулт өвчин. Шинжлэх ухааны адал явдалт бүтээлээр мэргэжсэн АНУ-ын зохиолч Ричард Престоны 1994 онд нийтлүүлсэн "The Hot Zone" хэмээх зохиол бол энэ аюулт өвчинийг судласан үнэн түүх дээр үндэслэсэн чансаатай бүтээл бөгөөд манай сайн вирус судалчдын нэг, доктор Э.Пүрэвдаваагийн орчуулгаар 2010 онд "Гоц аюулт бүс" нэрээр "Адмон" хэвлэлийн газар хэвлэсэн билээ.

R.Престоны энэ бүтээл бол байгалийн голомтот шинэ халдвартай анх тулгарахын аюул осол, аймшигийн тухай чин үнэнээр нь бичсэнээрээ нийтэд алдаршсан бөгөөд дэлхийн 30 шахам орны хэлээр орчуулагдаж, Дастин Хоффман нарын АНУ-ын кино одод тоглосон "Тахалт дэгдэл" (Outbreak) хэмээх Холливудын аймшигийн киноны зохиолын эх болсон юм. R.Престоны энэ бүтээл зөвхөн сонирхолтой уран зохиол төдий бүс, гоц аюултай халдварт өвчинтэй гэнэт тулгарах үед мэдүүштэй сургамж арвинтай тул АНУ-ын Вүүдрөү Вильсоны Сан(Woodrow Wil-

son Foundation)-гийн ажилтан Э.Голденкранц энэ зохиолыг дээрхи сангаас жил бүрийн зун зохион байгуулдаг биологийн багш нарын зуны сургуулийн сургалтын материал болгон 2004 онд найруулсан нь одоо интернетээр чөлөөтэй ашиглаж болох хичээл болсон байна (R.Престоны тухай дэлгэрэнгүй мэдээллийг түүний вэб-сайт <http://richardpreston.net> болон интернетийн "Википедиа" тайлбар толийн өгүүлүүдээс ([http://en.wikipedia.org/wiki/Richard\\_Preston](http://en.wikipedia.org/wiki/Richard_Preston), [http://en.wikipedia.org/wiki/The\\_Hot\\_Zone](http://en.wikipedia.org/wiki/The_Hot_Zone)) авна уу ).

Халдварт өвчинтэй тэмцэх Монголын үндэсний холбоо R.Престоны энэ ном бол халдварт өвчинтэй тэмцэх ажил, үйлст оролцдог хүн бүрийн уншвал зохих бүтээл хэмээн үзэж буй тул доктор Э.Пүрэвдаваагийн зөвшөөрснөөр сэтгүүлдээ цувралаар нийтлүүлэхээр шийдсэн юм.

Энэ номын монгол эхийг "Интерном" дэлгүүрээс худалдан авч болохоос гадна [drpurrev@gmail.com](mailto:drpurrev@gmail.com) хаягаар орчуулагчтай харилсан олж авч болно.

#### Сэтгүүлийн зөвлөл

### Нэгдүгээр дэвтэр ЭЛГОН ҮҮЛЫН СҮҮДЭР

ЭМЧ ӨВЧИЛЛӨӨ  
1980 оны 1 дүгээр сарын 15

Сувилагч, асрагч нар, өвчтөн зөөвөрлөдөг тэрэг түрсээр гүйж ирээд, Шарль Монег өргөн, дээр нь хэвтүүлж, эрчимт эмчилгээний тасагт хүргэнгүйтээ, чанга яригчаар эмч дуудаж, өвчтөн цус алдаж байгааг мэдэгдлээ. Шем Мусоек гэдэг zaluuhan эмч ирж, цус алдаж байгаа өвчтөнд туслахаар яаравчлав. Наргия шогч зантай энэ эмч, Найробийн эмнэлгийн хамгийн залуу, хамгийн сайн эмч нарын нэг бөгөөд

олон цагаар тасралтгүй ажиллаж чадлаг, маш их хөдөлмөрч, яаралтай тусlamжийг үнэхээр чадварлаг үзүүлдэг туршлагатай мэргжилтэн юм.

Шем Мусоек эмчийг ирэхэд, Шарль Моне тэргэн дээр хэвтэж байсан бөгөөд маш их цус алдсан нь харваас илэрхий ч, чухам ямар шалтгаанаас болж цус алдсаныг нь төсөөлөх арга байсангүй. Өвчний шалтгааныг тодруулах гэж оролдох цаг ч байсангүй. Өвчтөн арай чамай амьсгалж байснаа сүүлдээ амьсгалахаа бүр больчихлоо. Түүний уушгинд цус орсноос амьсгал нь түгжирчээ. Мусоек эмч өвчтөний судсыг барьж үзлээ. Судас нь сулхан, маш удаан цохииж байв. Энэ хооронд, нэг сувилагч ларингоскоп гэдэг багаж барьсаар гүйж ирлээ. Зөөлхөн резин хоолой бүхий энэ багажийг хүний амьсгалын замыг

чөлөөлж онгойлгоход хэрэглэдэг юм. Мүкосе эмч өвчтөний толгой талд зогсоод, цээжнийх нь агшиг, тэлэх хөдөлгөөнийг сайн ажиглахын тулд, цамцыг нь урж яраад, нүүр рүү нь тонгойн, нүдруү нь эгц харав.

Хамар, ам нь нил цус болсон Шарль Моне ув улаан нүдээрээ Мүкосе эмчийг гөлрөвч, нүднийх нь алим хөдөлгөөнгүй болж, хүүхэн хараа нь өргөсжээ. Энэ бол тархины гэмтлийн шинж бөгөөд өвчтөн огт ухаангүй байгааг харуулдаг юм.

Мүкосе эмч, резин бээлий өмсөж ч амжсангүй, шуудхан л өвчтөний амьсгалын замыг чөлөөлөхөөр, толгойг нь гэдийлгэн цагаан мөгөөрсөн хооловд нь ларингоскопо шургуулахаар зэхэв. Тэр, эхлээд өвчтөний аман дахь бөөлжисний үлдэгдэл, салс, цус зэргийг арилгах гэж хэлийг нь хуруугаараа тойруулан арчтал, хар бижирмэгтэй тослог зүйл гаргат нь наалдлаа. Бөөлжис, цусны үнэр өвчтөнөөс ханхлавч Мүкосе эмч иймэрхүү юманда хэдийнэ дассан болохлоор тоосонгүй, ажилдаа л улайлсаар байлаа. Тэр, багажныхаа байрлалыг зөв тохиууллахаар, нүүрээ Чарльз Монетийн нүүрэнд бараг шүргэтэл бөхийгэөд хоолой руу нь шагайв. Тэгээд, өвчтөний хэлийг дарж байгаад, залгиур хооловных нь араар ларингоскопо гулгуулан түлхэж, уушигны харанхуй хөндийг рүү оруулаад, дурангаа шагайн уушгинных нь дотор талыг шалгалаа. Энэ үед, Шарль Моне гэнэт татваганан хөдөлснөө бөөлжчихөв. Хар, улаан өнгийн зүйлс холилдсон бөөлжис багажийг нь дагаад оргилон цацагдсанаа Мүкосе эмчийн нүүрэн дээр шүршин бууж, нүд болон амруу нь урсан орлоо. Эмчийн цагаан халаат, цээж нилдээ бөөлжсөнд будагдаж, хар бижирмэг бүхий өтгөн улаан шингэн судал татан урсч байв.

Эмч Шарль Монегийн толгой гэвтэй хэнбайрлуулаад аман дахь цусыг нь хуруугаараа малтан гаргалаа. Мүкосе эмчийн гар, бугуй, шуу нилдээ цус болсноос гадна өвчтөний тэрэг, өрөөний шал тэр аяараа цусанд будагдлаа. Энэ үед, эрчимт эмчилгээний тасгийн хэдэн сувилагч нүдэндээ ч итгэж чадахгүй, чухам юу хийхээ ч мэдэхгүй, ар талаар нь бужигнацааж байв. Мүкосе эмч, өвчтөний хоолов руу шагайн, багажаа уушгинных нь гүнд оруулан дурандаад, амьсгалынх нь замыг тэр аяар нь бөглөсөн цусыг цэвэрлэлтэл өвчтөний уушки хэрчигнэн, агаар сорж байгаа нь соностсоноо, амьсгалж эхэллээ. Гэвч Шарль Моне нүх сүв болгоноороо маш их цус алдсанаас, биен нь шингэн бараг байхгүй болж, шоконд гүнзгий орсон байв. Түүний биеэр эргэлдэх цус хүрэлцэхгүй болж, судасных нь лугшилт хэт түргэсэн, цусных нь даралтын заалт “тэг” рүү буусаар байв. Иймээс Шарль Монед цус сэлбэх зайлшгүй шаардлагатай боллоо. Мүкосе эмч, сувилагчийхаа авчирсан хүүдийтэй цусыг өлгүүрт тогтоогоод, өвчтөний гарын хураагуур судсанд зүүг нь хатгав. Гэтэл өвчтөний цус хатгасан

зүүг нь даган зогсолтгүй садран урсаад, цус сэлбэж болсонгүй. Мүкосе эмч, Шарль Монегийн гарын судсыг тэмтрэн үзэж байгаад, өөр хэд хэдэн газар дахин дахин хатгаж үзсэн ч болсонгүй. Цус нь бүр ихээр олгойдож байв. Зүү хатгасан газар болгоны судас нь чанаж болгосон хөндий гоймон шиг хэврэг болж, зүүний оромноос цус гоожин гарыг нь даган урсаад, огт бүлэгнэхгүй байлаа. Иймээс, зүү хатгасан жижигхэн нүхээр цус алдсаар өвчтөн нь үхчих вий гэж Мүкосе эмч эмээгээд, Шарль Монед цус сэлбэх гэж оролдохоо болилоо. Өөр арга байсангүй. Энэ хооронд, өвчтөний гэдэснээс цус алдсан хэвээр байсан бөгөөд цусных нь өнгө сүүлдээ хар давирхай шиг боллоо.

Мүкосе эмч өвчтөнийхөө амийг аврах гэж, дэргэдээс нь огтхон ч ходолгүй, чармайн оролдсон боловч дийлсэнгүй., Шарль Монегийн бие улам муудаж, ухаан оролгүй байсаар, өглөө эрт нас барав.

Ернь, тэрчухам ямар өвчинөөс болж үхсэнийг хүмүүс огт мэдэлгүй өнгөрчээ. Аргагүй ээ, энэ бол үнэхээр тайлбарлахын аргагүй үхэл байв. Талийгаачийн цогцост хийсэн шинжилгээгээр бөөр нь гэмтэж, элэг нь үхжсэн байсан нь тогтоогджээ. Гэхдээ, түүний элэг, нас бараахас нь нилээд хэд хоногийн өмнөөс ажиллагаагүй болсон нь ив илхэн байсан бөгөөд өнгө нь шарлан, зарим газраа үйланхай шиг болж, яг л үхээд гурав хоносон цогцосны элэг шиг харагдаж байжээ. Өөрөөр хэлбэл, Моне нас бараахасаа өмнө үхдэл шиг болсон байжээ. Гэдэсний хана гүүжих ховхрох нь, гол төлөв, үхээд удсан цогцосын бас нэг шинж байдаг юм. Шарль Монегийн үхлийн шалтгаан чухам юу байв аа? Бүг мэд. Түүний үхлийн шалтгаан байж болзошгүй маш олон зүйл байсан боловч тэдний дотроос чухам энэ нь гээд сонгоод нэрлэчихмээр зүйл үнэндээ байсангүй. Талийгаачийн бараг бүх эд, эрхтний үйл ажиллагаа алдагдсан, цус нь нөхжирсөн, их хэмжээний цус алдсан, элэг нь зөөлрөөд нухаш шиг болсон, гэдээ дотор нь цусаар дүүрсэн зэргийн аль нь ч үхлийн шалтгаан болж чадахаар байв. Чухам юу болоод өнгөрсөн, ямар төрлийн өвчин байсныг бүрэн тодорхойлох үг, хэллэг эцэстээ эмч нарт дутагдсан учир, үхлийх нь шалтгааныг “Хэт түргэн явтай элэгний дутал” гэж оношлоод, өвчний нь түүхийг хаажээ. Талийгаачийн цогцсыг, оршуулгын журмын дагуу ус нэвтэрдэггүй хүүдийд хийгээд тэр нутагт оршуулсан боловч, хэдэн жилийн дараа намайг Найробид очиход тэр булш хaa байгааг мэдэх хүн байгаагүй билээ.

1980 оны 1 дүгээр сарын 24

Шем Мүкосе эмчийн нүд, амруу нас барсан өвчтний бөөлжис орсноос хойш яг ес хоногийн дараа нуруугаар нь өвдөж эхэлжээ. Үнэндээ, ингэж

өвдөхөөр юм огт болоогүй, урьд нь ч ингэж хүчтэй өвдөж байсангүй. Харин гуч дөхөж байгаа болохлоор, энэ насанд зарим хүний уүс нуруугаар сүрхий өвдөж эхлэх тохиолдол байдаг тул, тийм л юм болж байгаа байх гэж Мусоке эмч бодоод, огт тоосонгүй. Тэрээр өнгөрсөн долоо хоногт маш их ядарч, машинаа ч арайхийн барьж байсан билээ.

Мусоке эмч, эртүүд зүрхний өвчтэй хүний дэргэд бүхэл шөнөжин зогсоогоороо ажиллаж хоносны маргааш нь, хаанаас ч юм бүү мэд хөдөөнөөс цус алдаж ирсэн нөгөө франц хүний дэргэд бас л шөнөжингөө зогсоогоороо ажиллаж хоносон билээ. Хэдэн шөнө дараалан, зогсоо зайгүй ажиллаад сайн унтаж, амарч чадаагүй болохлоор ядарч байгаа биз гэж тэр боджээ. Сүүлдээ бүх биеэр нь өвдөж эхэлсэн боловч, өнөөх өвчтөний бөөлжистэй хутгалдсанаас халдварт авчихсан юм болов уу гэдэг бодол санаанд нь огт орсонгүй.

Нэг өдөр Мусоке эмч толина нүүрээ харж байхдаа, нүдээ улайсныг ажиглажээ. Нүд улайсныг бодоход, хумхаа туссан юм болов уу гэж тэр жаахан гайхаад л өнгөрөв. Гэтэл сүүлдээ халуурч эхэллээ. Энэ нь, гарцаагүй ямар нэг халдварт өвчин түүнд туссаныг харуулж байв. Нуруугаар нь өвддөг байсан бол, одоо хамаг биеийх нь буличин тэсэхийн аргагүй өвдөж эхэлсэн тул хумхаагийн эм уусан боловч дээрдэх шинж илэрсэнгүйд хумхаа өвчинийг эмчилдэг тариа хийж өгөөч гэж Мусоке эмч нэг сувилагчаасаа гүйжээ.

Тэр сувилагч Мусоке эмчийн гарын буличинд тариа хийж өглөө. Тариа хийсэн газар тэсвэрлэхийн аргагүй өвдөж байв. Урьд нь тариа хийлгэхэд хэзээ ч ингэж өвддөггүй байсан болохлоор, энэ явдал нэг л жигтэй санагдсанаас гадна хэзээ ч мартагдахааргүй айхавтар өвдөлт байлаа. Ерийн нэг тариа хийхэд яагаад ингэж сүрхий өвдөж байгаа юм бол гэж Мусоке эмч гайхсаар байв. Удалгүй, хэвлэгээр нь өвдөж эхэлсэнд балнад өвчин туссан юм болов уу гэж бодоод, антибиотик хүрэлцэхүүц тунгаар уусан боловч, тэр нь өвчинийг анагаахад нэмэр болсонгүй. Хэдийгээр, бие өвдөж байсан ч, Мусоке эмч өвчтнүүдээ эмчлэх шаардлагатай байсан тул эмнэлэг дээрээ ажилласаар л байлаа. Эцэстээ, түүний хodoод, буличин зэрэг нь бүр тэсвэрлэхийн аргагүй өвдөж, арьс нь шарлаж эхлэв.

Мусоке эмч хүн мөртлөө өөрийхөө өвчинийг оношложчадалгүй, өвдөлтийг нь тэсвэрлэнажилласаар ажилласаар, сүүлдээ ямар ч тэнхээ чадалгүй болсон тул Найроби хотын эмнэлгийн эмэгтэй эмч Антонио Багшавед биеэ үзүүлмээ. Антонио Багшаве эмч Мусокег анхааралтай гэгч нь үзсэн хэрнээ халуурсан, нүд нь улайсан, бие нь шарласан, хэвлэгээр нь өвдсөн зэргээс үндэслэн тодорхой онош тавих боломж байсангүй. Харин Мусокег цэсний чулуутай юм уу, эсвэл элэгний буглаатай байх гэж боджээ.

Яагаад гэвэл, энэ хоёр өвчиний аль алиных нь үед халуурах, арьс шарлах, хэвлийгээр өвдөх шинжүүд илэрдэг юм. Харин Мусокегийн нүд яагаад улайсан байдаг билээ? Үүнийг Антонио Багшаве эмч хараахан тайлбарлаж чадсангүй. Ямар ч байсан, Мусокегийн элгийг хэт авиаагаар шинжлье гэж Антонио Багшаве эмч шийджээ. Гэтэл, энэ шинжилгээгээр Мусокегийн элэг жаахан томорсноос биш, өөр ямар ч сэжигтэй зүйл илэрсэнгүй. Сүүлдээ Мусоке эмчийн бие тун доройтсон тул түүнийг өрөөнд нь хэвтүүлэн, сувилагч нар ээлжээрээ хонон өнжин асарч байв. Яваандаа түүний нүүр огт хөдөлгөөнгүй, баг өмссөн мэт боллоо.

Антонио Багшаве эмч анхандаа цэсний чулуутай л холбоотой байх гэж бодож байсан өвчин нь одоо үхэлд ч хүргэж магадгүй болсон тул онош тодруулах бичил хагалгаа хийлгэх шаардлагатайг Мусокед зөвлөжээ. Тэгээд, тус эмнэлгийн мэс заслын гол өрөөнд, Имре Лофлер эмчээр ахлуулсан мэс засалчид Мусокед хагалгаа хийн, элэгнийх нь харалдаа зүсч, буличингүүдиг нь яран, хэвлийх нь хөндийг нээтэл, цочирдмоор, бас гайхмаар өөрчлөлт харагдав. Мусокегийн элэг үрэвсэн, хавагнаж хөөгөөд, ув улаан өнгөтэй болсон байсан бөгөөд цэсний чулуу байсангүй. Энэ хооронд, Мусоке цус алдсаар л байлаа. Ямар ч мэс заслын үед, оглосон судаснуудаас цус гоожиж байгаад, удалгүй аяндаа зогсох юм уу, зогсохгүй бол цус тогтоох үйлчилгээтэй гель жаахан түрхэхэд гоожихоо больдогсон. Гэтэл, Мусокегийн судаснуудаас цус гоожод зогсохгүй, огт бүлэгнэхгүй, яг л хемофили өвчтэй хүн шиг болсон байлаа. Эмч нар түүний элгийг цус тогтоогч гелиэр нэлэнхүйд нь бүрхэн цацсан боловч, сэвсгэр хөөсний завсраар цус нь нэвт шүүрэн гоожсоор л байв. Хэвлэлийх нь хөндийд ихээр хуралдсан шусыг эмч нар, байн байн соруулан авч байсан ч, зүслэг хийсэн газраас тасралтгүй гоожих цус дахин хуралдсаар л байлаа. Зүйрлэн хэлбэл, хөрсний тогтоол усны дор нүх ухаад, дорхноо усаар дүүрээд, түвшин нь өөрчлөгддөггүйн адил, өвчтөний цусыг соруулах тутам яах ийхийн зуургүй дахин хуралдсаар байв. Тэр удаагийн мэс заслыг хамт хийлцсэн нэг эмч: “Ёстой тохойгоор татсан цусан дотор ажиллаж байсан шүү” гэж хожим нь хүмүүст ярьсан байж билээ. Тэр үед, эмч нар Мусокегийн элгийг биопсийн зүүгээр хатган, эдээс нь өчүүхэн сорыц авч, хадгалагч уусмалтай шилэнд хийсний дараа, өвчтөнд хийсэн зүслэгээ яаравчлан битүүлж оёжээ.

Мэс заслын дараа Мусокегийн бие эрс муудан, бөөрний дуталд орж, бараг үхэж байгаа хүн шиг харагдаж байлаа. Яг энэ үеэр, түүнийг эмчилж байсан Антониа Багшаве эмч гадаадад явсан тул, Давид Сильверстейн гэдэг эмч, оронд нь эмчлэхээр боллоо. Халдаж халдаж хар халзанд нь гэгчээр, бүр Мусоке эмч өөрөө бөөрний дуталд орж, диализ хийлгэх

шаардлагатай болсон нь тус эмнэлгийг бүхэлд нь түгшүүрийн байдалтай болгож, түүнд хайртай нөхөд нь, мэргэжил нэгт андыгаа алдахаас айж байлаа. Давид Сильверстейн эмч Мусокег ямар нэгэн ховор вирусийн халдвараар өвчилсөн байх гэж сэжиглэж эхлэв. Тэгээд тэрээр өвчтөнөөсөө цус авч, эсийг нь тунгаан, алтан шаргал өнгөтэй, тунгалаг ийлдсийг нь ялгаж аваад, нэлээд олон жижиг шилэнд савлаж хөлдөөлөө. Удалгүй, Давид Сильверстейн эмч тэдгээр ийлдсээс заримыг нь Өмнөд Африкийн Сандрингхэм хот дахь Үндэсний Вирус Судалын Хүрээлэнгийн лабораториид, заримыг нь АНУ-ын Жеоргияа муж улсын Атланта хот дахь Өвчний Хяналт Сэргийлэлтийн Төвийн лабораториид шинжлүүлэхээр илгээгээд, шинжилгээний хариуг нь хүлээж байлаа.

### ОНОШ ТОДРОВ

Давид Сильверстейн эмч, Африкийн Найробих хотод суурьшин, тэндээ ажиллаж, амьдардаг ч гэсэн, АНУ-ын Колумбын тойргийн Вашингтон хотын ойролцоо бас нэг байртай ажээ. Саяхны нэг зүн, зарим ажил төрлөө амжуулахаар түүнийг Америкт ирсэн байхад нь, тэднийхээс холгүй орших нэгэн их дэлгүүрийн цайны газар би түүнтэй уулзсан юм. Тэр удаа бил хоёр нэг жижигхэн ширээнд хамт суушгааж Моне, Мусоке хоёрын өвчний талаар тэр надад ярьж өгсөн билээ. Сильверстейн бол насаар тавь дөхсөн, намхан нуруутай, туранхайвтар биетэй, ширвээ сахалтай, нүдний шил зүүдэг, соргог, түргэн харштай, нэвт шувьт ширтэдэг хүн. Тэрбээр, америк хүн мөртлөө швахили хэлний аялагатай ярьдаг юм. Бид хоёрын тааралдсан тэр өдөр Сильверстейн бат бөх эдээр хийсэн хүрэм, цэнхэр жинс өмссөн байсан бөгөөд арьс нь сайхан борлож, тавлаг амарсан шинжтэй, сэргэлэн харагдаж байж билээ. Тэрбээр, эмч төдийгүй бас нисгэгч хүн бөгөөд голдуу хувийхаа онгоцоор зорчдог ажээ.

Өмнөд Африкт хамгийн томд тооцогдох хувийн нэгэн эмнэлэгт ажилладаг Сильверстейн эмч, өөрөө Найроби хотын нэр хүнтэй хүмүүсийн нэг төдийгүй, Кенийн ерөнхийлөгч Даниел арап Мойн хувийн эмч учраас, түүнийг гадаадад айлчлах болгонд нь дагаж явдаг байлаа. Сильверстейн, авилгалд автсан улс төрчид, ан хийн аялж яваад өвчилсөн жүжигчид, Англи болон Африкийн бие муутай язгууртан гээд л Зүүн Африктаа нөлөө бүхий олон хүнийг бас эмчилдэг төдийгүй, Диана буюу хатагтай Деламерегийн хувийн эмч тул, түүнийг дагаж их аялнаа. Энэ хатагтай, хэдийгээр нас ахиж, зүрхний өвчтэй болсон ч, Кенийн эргийн дагуу далайн гүнээс загас барих дуртай байсан юм. Хатагтайг загас барихаар явах бүрд, Сильверстейн эмч дэргэд нь байж, цусных нь даралт, зүрхнийх нь цохилтыг хянах үүрэгтэй. Сильверстейн бас Берил Маркхэмийн эмч байлаа. Маркхэм бол, Зүүн Африкт нисгэгчээр ажиллаж байсан он жилүүдийхээ дурсамж – “Баруун зүгийн шөнө” хэмээх сонирхолтой ном

бичсэн эмэгтэй бөгөөд Найроби хотын нисгэгчдийн клубээс ер салдаггүй, сал пал хийсэн, зогсоо зайгүй архи уудгаараа нэrd гарсан хүн билээ (“Намайг анх танилцахад л тэрээр архи нийээн залдаг хижээл авгай байсан” гэж Сильверстейн эмч хэлсэн).

Мусоке эмч Сильверстейн эмчийн эмчилсэн алдар цуутны нэг болжээ. Сильверстейн надад ярихдаа: “Би Мусоке эмчид тэнхрүүлэх эмчилгээ л хийж байлаа. Миний хийж чадах юм тэр л байв. Түүнэдээ болох тэжээллэг юм өгч, халуун нь нэмэгдээд ирэнгүйт бушуухан буулгахыг л хичээж байсан юм. Товчхонор хэлбэл, эмчилгээний тодорхой төлөвлөгөө өрөөсөө байхгүй өвчний үед хийвэл зохих үндсэн эмчилгээг л түүнд хийж байсан даа” гэсэн билээ.

Нэг удаа, Сильверстейн эмчийг Найроби дахь гэртээ байхад, шөнийн хоёр цагт утас нь дуугарчээ. Утасдан хүн нь Кенид ажилладаг нэг америк судлаач байсан бөгөөд Өмнөд Африкийн вирус судалчид Мусокегийн цусанд маш сонин юм илрүүлсэн байна гээд, “Түүний цусанд Марбург вирус илрээ. Энэ бол маш ноцтой зүйл. Гэхдээ бид Марбург вирусийн тухай ч нэг их юм мэдэхгүй” хэмээжээ.

Сильверстейн эмч, урьдомнөн, Марбург вирусийн тухай сонсож байгаагүй бөгөөд энэ тухайгаа надад ярихдаа: “Утсаар ярьсныхаа дараа, би буцаад унтаж чадаагүй. Марбург вирус гэж чухам юу болох талаар элдвийг бодож, бараг л сэргүүнээрээ зүүдлэх шахуу юм болсон доо” гэсэн юм. Тэр шөнө Сильверстейн, хамтран зүтгэгч, дотны найз Мусоке эмчийг нь шаналгасан өнөөх сүрхий өвчний талаар нэг бодож, ямар гээч аюултай бичил биетэн эмнэлгийхний дунд чөлөөтэй тархаж байгаа юм бол гэж нэг зөв соор орондоо хэсэг хэвтжээ. Тэгтэл, түрүүний утсаар ярьсан хүний хэлсэн “Бид Марбург вирусийн тухай ч нэг их юм мэдэхгүй” гэсэн үг чихэнд нь дахин дахин сонстсоор байлаа. Сильверстейн унтаж бүр чадаагүй болохлоор нь, шуудхан хувцаслаж, машинаа асаагаад, эмнэлэггүүгээ давхисаар, үүрээр ажил дээрээ иржээ. Ирэнгүйтээ, анагаах ухааны нэг сурх бичиг олоод түүнээс Марбург вирусийн талаар бичсэн зүйлийг хайв.

Энэ вирусийн талаар маш товчхон зүйл бичигдсэн байлаа. Марбург вирус нь, Африкийн бичил биетэн мөртлөө герман нэр авчээ. Энэ вирусийг анх илрүүлсэн газрын нь нэрээр нэрлэсэн байв. Марбург гэлэг нь Германы төв хэсэгт оршдог эртний нэгэн хот бөгөөд ой мод, нугаар хүрээлэгдсэн ногоон хөндийд оршдог, олон үйлдвэртэй хот юм. Марбург хотод, африкийн ногоон сармагчны бөөрний эсийг ашиглан вакцин үйлдвэрлэдэг Берингийн үйлдвэрт энэ вирусийн халдвэр анх 1967 онд гарчээ. Тэр үед, Берингийн үйлдвэр Уганда улсаас сармагчин байнга худалдан авдаг байсан бөгөөд тав, зургаан зуугаар нь, онгоцоор тээвэрлэдэг сармагчны дотор, уг вирус огт мэдэгдэлгүйгээр зөөвөрлөгдөн Германд нэвтэрчээ.

Марбург вирусийн халдварт авсан хоёр, гуравхан сармагчин өвчний нууц үедээ байсан нь хараад мэдэгдээгүй бололтой. Ямар ч байсан, тэдгээр амьтдыг Берингийн үйлдвэрт авчирсны дараахан, тэдний дунд энэ вирусийн халдварт тархаж, зарим сармагчин цус алдан шоконд орон, үхэж эхэлжээ. Удалгүй, Марбург вирус сармагчны хүрээнээс хальж, хүмүүст халдвартлан, улмаар тус хотын хүн амын дотор тархах аюул нүүрлэсэн байна. Энэ бол вирус хэт үржиж олширсны нэг жишээ юм.

Марбургвирусийнхалдвараарөвчилсөнхүмүүсийн дотроос Берингийн үйлдвэрийн сармагчинг тэжээж, байрыг нь цэвэрлэдэг байсан Ф. Клаус гэдэг ажилчинд энэ өвчний хамгийн анхны онош тогтоогджээ. Тэр хүний өвчин 1967 оны 8 дугаар сарын 8-ны өдөр илрээд, хоёр долоо хоногийн дараа нас барсан байна...

Сильверстейн эмчийн олсон нөгөө номонд, Марбург вирусийн талаар ердөө ийм жаахан мэдээлэл бичигдсэн байлаа. Тэр үед, Марбург вирусийн талаар хэвлэгдсэн цорын ганцхан ном нь Марбургийн Их Сургуулиас 1970 онд зохиосон симпозиум дээр хэлэлцсэн илтгэлүүдийн эмхтгэл байв. Сүүлд нь, билтэр номоос дараах мэдээллийг олж авсан юм.

– Сармагчин маллагч П. Хайнрих ээлжийнхээ амралтыг дуусган 1967 оны 8 дугаар сарын 13-нд ажилдаа ороод, 14-нөөс 23-ны өдрүүдэд сармагчин нядалж байсан. Өвчний анхны шинж тэмдэг 8 дугаар сарын 21-ний өдөр илэрсэн.

– Лаборант Л. Ренате 1967 оны 8 дугаар сарын 28-нд халдвартай материал агуулж байсан хуруу шил ариутгах гэж байгаад хагалж, 9 дүгээр сарын 4-ний өдөр өвчилж эхэлсэн гэх мэтээр өнөөх номд бичсэн байлаа.

Марбург вирусийн халдварт өртсөнөөс хойш, долоо хоног орчмын дараачаас толгой өвдөж эхлээд, хүчтэй халуурах, цус нөжирч судас бөглөрөх, цус алдах зэрэг шинжилэрч, өвчтөн уламдордсоор шоконд орон, нас барж байжээ. Марбург хотод халдварт өвчин гарсны дараах хэдхэн хоногийн дотор 31 хүн өвчилсөн 7 нь цусандaa хутгалдан үхсэн тул ёстой нөгөө галав юүлэх гэдэг нь болж байгаа юм болов уу гэж тэндэхийн эмч нар боджээ. Марбург вирусийн халдвараар өвчилсөн 4 хүн тутмаас нэг нь нас барж байсан нь энэ вирус туйлын аюултайг гэрчилж байна. Тэр үед, өвчтөнийг хамгийн орчин үеийн эмнэлэгт эмчилиж, зүрх үүшгүүни үйл ажиллагааг нь дэмжих аппарат багажийг хэрэглэсэн ч гэсэн, өвчлөгсдийн 25 хувь нь нас барж байжээ. Гэтэл энэ вирусийн халдварт гарахаас өмнө хамгийн аюултайд тооцогддог байсан шар чичрэгийн вирусийн халдварын үед өвчтнүүдийг түргэн хугацаанд эмнэлэгт хүргэж амжвал 20 хүн тутмаас нэг нь нас бардаг байжээ.

Марбург вирус бол, филовирусүүдийн дотроос хамгийн анх нээгдсэн нь юм. Филовирус гэдэг нь

“утаслаг вирус” гэсэн угтатай латин үг. Филовирусийн төрөл зүйлүүд өөр хоорондоо адилхан боловч, харин бусад вирусээс огт ондоо. Ихэнх вирус, электрон-микроскопоор чинжүүний үр шиг бөмбөлөг хэлбэртэй харагдаг бол утаслаг вирусийн хэлбэр дүрсийг орооцолдсон олсны тасархай, үс, хорхой, тэр бүү хэл могойтой ч адилтгасан байдаг юм. Филовирус халдвартласан эзнээ сүйрүүлэн цусыг нь садартал гоожуулж байх үедээ цустай нь хамт ялгарсаар л байдаг. Хэрэв яг тэр үед нь өвчтөний цусанд электрон-микроскопын шинжилгээ хийж үзвэл, филовирусууд чанасан гоймон овоолсон юм шиг хэлбэр дүрстэй харагдана. Зарим Марбург вирусийн үзүүр хүйлран гогцоо үүсгэсэн байдаг.

Марбург вирус хүний тархийг туйлын аймшигтай сүйдэлж, төв мэдрэлийн системийг гэмтээдэг ба энэ үед тархинд гарсан өөрчлөлт нь галзуу өвчнийг санагдуулахаар байдгийг герман эрдэмтэд бичжээ. Үнэндээ Марбург вирус галзуугийн вирустай төстэй харагдах тал бий. Хэдийгээр галзуугийн вирус сум шиг хэлбэртэй боловч задраад сунавал утас шиг харагдах бөгөөд хэрэв мушгираад гогцоо үүсгэвэл цагираг хэлбэртэй болж Марбург вирустай адилхан болно. Иймээс зарим эрдэмтэн Марбург вирусийг галзуугийн вирустай төрлийн холбоотой байх гэж үзээд түүнийг “галзуугийн сунасан вирус” гэж нэрлэж байсан удаа бий. Гэвч Марбург вирус биеэ даасан огт өөр бүлэгт багтдаг нь хожим тодорхой болсон билээ.

Шарль Монег нас бараад үдаагүй байхад филовирусийг вирусийн шинэ овог болгон ангилж, Марбург вирустай хамт Эбола чичрэг үүсгэгч хоёр зүйлийн вирусийг уг омогт багтаажээ. Эбола чичрэгийн үүсгэгчид нь Зайрын Эбола вирус, Суданы Эбола вирус хоёр билээ. Филовирусүүдээс арай аюул багатай нь Марбург вирус, хамгийн их аюултай нь Зайрын Эбола вирус юм. Эбола чичрэгээр өвчилсөн 10 хүн тутмын 9 нь үхэж, нас баралтын түвшин 90 хувьд хүрнэ. Өөрөөр хэлбэл, Зайрын Эбола вирус бол хүн төрөлхтнийг жинхэнэ хүйс тэмтрэгч мөн.

Харин Эбола вирусийн төрөл Марбург вирус нь хүний биед радио-идэвхит цацраг шиг нөлөөлөн бүх эс, эдийг гэмтээдэг бөгөөд ялангуяа дотор эрхтэн, холбогч эд, нарийн гэдэс, арьс зэргийг дэндүү хорлонтой гэмтээдэг ажээ. Германд энэ халдвараар өвчлөөд амьд мэнд үлдсэн хүмүүсийн үсний үг үхжиж, яг л цацраг түяанд түлэгдсэн мэт түг тугаараа унаж, зарим нь хожгор, зарим нь халzan болсон байна. Марбург хотод энэ халдвараар өвчилсөн хүмүүс биеийхээ бүх нүх сүв болгоноор цус алдаж байсан бөгөөд нэг эрэгтэй хүнийг нас бараахас нь өмнөхөн авсан гэрэл зураг дээр нүцгэн цээжээ гарган хэвтэх тэр хүний царай нь гөлийгөөд, цээж, гар, нүүр нь цус хурсан толбоор дүүрч, хөхний нь толгойноос цусны дусал бөнжийсөн байж билээ.

Үг халдвараар өвчлөөд амьд үлдэж, өвчин эдгэрэх

үед хүмүүсийн нүүр, гар, хөл, бэлэг эрхтний арьс гуужихаас гадна заримдаа эрэгтэй хүний төмсөг хавдан, зарим хэсэг нь уусч илжирснээс айхавтар шаналдаг ажээ. Халдвартай цогцост задлан шинжилгээ хийхэд тусалдаг байсан нэг хүнд ийм үрэвслийн тун аягүй тохиолдол оношлогдсон байлаа. Үүнээс гадна, Марбург вирус нүдний алимны доторх шингэнд хэдэн сараар хадгалагдаг тухай бичсэн байв. Чухам ягаад энэ вирус хүний төмсөг болон нүдний эдэд илүү сайн үржих амьдардгийг одоо хүртэл тайлбарлаж чадаагүй л байгаа юм. Нэг хүн Марбург вирусийн халдвартыг бэлгийн замаар эхнэртээ халдаасан тохиолдол ч бичигдсэн байнсныг энд бас цухас дурдья.

Марбург вирус хүний уураг тархинд маш хачин нөлөө үзүүлдгийг эмч нар ажиглажээ. Энэ талаар нөгөө номонд бичихдээ: “Ихэнх өвчтөн дүнсгэрдүү болохын зэрэгцээ бага зэрэг хэрцгий авир гаргах юм уу эсвэл юмыг үгүйсгэх хандлагатай болдог байв. Тухайлбал, хоёр ч өвчтөн, хэвтэхээр дороос юм нухаад байна гэж байнга гомдоллог байснаас нэг нь бүр солиорсон нь гарцаагүй тархи гэмтсэний уршиг мөн. Бас О.В.Ханс гэдэг өвчтөнд тархины гэмтлийн ямар ч шинж илрэхгүй, халуун нь буурч, бие нь овоо гайгүй болж байснаа, гэв гэнэтхэн муудаж, даралт нь огцом буурсаар, шокона орон нас барсан аж. Түүний цогцост задлан шинжилгээ хийн, гавлын ясыг нь нээж үзэхэд, тархины нь гол хэсэгт, гарцаагүй үхэлд хүргэх маш их хэмжээний цус харвалт үүссэн байв. Энэ нь, түүний хувьд гадагш цус алдсан бус, харин тархи руугаа цус алдсан хэрэг юм” гэжээ.

Марбург вирусийн оршин амьдарч байдаг байгалийн эх уурхайг нь олохын тулд Марбург хотод аваачсан сармагчингуудын нутаглаж байсан газрыг яг таг олж тогтоо ажлыг Олон улсын анагаах ухааны гол гол байгууллага, тэр үед, яаралтай эхэлсэн байна. Марбург вирус халдварт авсан сармагчныг маш богино хугацаанаа сүйрүүлж байснаас үзэхэд түүний оршин амьдрахад тохирсон эзэн нь сармагчин лав биш бөгөөд уг вирус байгалийн хэвийн нөхцөлд сармагчингуудын дунд тархан орчиж байдаггүй нь илэрхий юм. Иймээс, Марбург вирус өөр нэг амьтны биед удаанаар хадгалагдан амьдардаг байх ёстой. Энэ нь ямар амьтан бэ? Шавьж уу, мэрэгчид үү, аалз уу, аль эсвэл хэвлээр явагчид уу? Чухам хаанаас, тэдгээр сармагчинг барьсан юм болоо? Тэнд л, энэ вирусийн нуугдан амьдардаг нутаг нь байж таарах билээ. Германда Марбург вирусийн халдварт анх дэгдсэний дараахан ДЭМБ-ын ивээл дор байгуулсан судлаачдын баг тэдгээр сармагчинг барьсан газрыг олж тогтоохоор Уганда улсруу нисчээ. Гэтэл Марбургт авчирсан сармагчингуудыг Угандагийн төв хэсгийн энд тэндээс барьсан байсан тул дээрх багийхан вирусийн жинхэнэ эх уурхайг олж чадсангүй.

Халдвартын эх уурхай чухам хаана байсан бэ? гэдэг асуултын хариу олон жилийн турш олдолгүй учир

битүүлэг хэвээр л байлаа. Тэгтэл, 1982 онд Английн нэг малын эмч, Марбургийн халдвартай сармагчинтай холбоотой, нүдээр үзсэн зүйлээ ярж, нилээд зүйлийг тодруулж өгсөн юм. Тэр хүн, одоохондоо нэрээ нуулах нь дээр гэж үзсэн тул, түүнийг би ноён Жонс гэж нэрлэе. Германда, Марбург вирусийн халдварт анх дэгдсэн 1967 оны зүн, өнөөх сармагчингуудыг ачуулсан Энтеbbe хотын гадаад худалдааны газрын мал эмнэлгийн байцаагч нь амралттай байх хооронд ноён Жонс сармагчны эрүүл мэндийг үзэж шалгах ажлыг түр хийж байсан юмсанжээ. Сармагчин худалдаалдаг тэр газрыг сармагчны наймаачин нэг баян эр буюу ноён Жонсын хэлснээр бол нүдэнд дулаахан нэг луйварчин эзэмшдэг байсан бөгөөд жил бүр 13000 орчим сармагчин Европруу наймаалдаг байжээ. Энэ бол маш их тоо бөгөөд ихээхэн мөнгө хүүлдэг байжээ гэсэн үг. Нэг удаа, нөгөө халдвартай сармагчин дунд багтсан амьтдыг шөнийн нислэгээр Лондонруу илгээж, тэндээс Германда хүргэжээ. Гэтэл, удалгүй тэдгээр амьтдын дунд вирусийн халдварт дэгдэж, улмаар хүн амын дунд тархахыг “оролджээ”.

Ноён Жонсыг Английн нэг хотод мал эмнэлгийн зөвлөхөөр ажиллаж байгааг нь би утаастаар байж олж мэдсэн юм. Тэр надад хэлэхдээ: “Тэдгээр сармагчинг ачуулахын өмнө миний хийсэн зүйл гэвэл, тэднийг үзэж шалгасан юм” гэсэн билээ.

“Хэн шалгасан юм бэ?” гэж намайг асуухад Жонс:

“Би шалгасан юм. Сармагчин эрүүл харагдаж байна уу, үгүй юу гэдгийг би үзэж, харж шалгадаг байлаа. Заримдаа, ачуулах гэж байгаа сармагчингаас ганц хоёр нь бэртсэн юм уу, арьс нь зулгарсан байдаг байсан” хэмээн хариулав. Тэр үед, ноён Жонс сармагчинг үзэж шалган, өвчтэй харагдсаныг нь гадаадад гаргахаар ачуулалгүй, түүж үлдээгээд, эрүүл амьтдыг нь онгоцонд ачихаас өмнө, тэднийг алж устгадаг байх гэж боддог байжээ. Нөгөө сармагчингуудыг ачуулснаас хойш, хэдхэн хоногийн дараа Германда халдварт дэгдэж эхэлснийг мэдээд ноён Жонс түгшин сандарснаа надад ярихдаа: “Гадаадад сармагчин гаргах зөвшөөрөлд би гарын үсэг зурсан болохлоор ёстой айсан. Тэр халдвараар хүмүүс өвчилж, нас барсан нь зөвхөн миний л буруугаас болсон гэж одоо хүртэл боддог юм. Ийм харамсалтай явдал болохоос ямар нэг аргаар сэргийлж чадах байсан юм биш үү гэсэн бодол байнга төрдөг дөө. Гэхдээ тэр үед, тийм арга даанч байгаагүй” гэсэн юм. Ингэж хэлэхээс ч аргагүй, үнэн зүйл билээ. Тэр үед, Марбург вирус шинжлэх ухаанд нээгдээ ч үгүй, харахад өвчтэй гэмээргүй хоёр гуравхан сармагчин айхавтар халдварт дэгдээчихэнэ гэж санаанд орохын ч аргагүй үе байсан билээ. Иймээс, ноён Жонсыг буруутгаж зэмлэхийн арга үнэндээ байхгүй.

Ноён Жонсын яриаг цааш сонсох тусам улам түгшүүртэй болж байлаа. Тэр өгүүлэхдээ: “Би

өвчилсөн сармагчингүүдиг алж устгадаг байх гэж анхандаа боддог байлаа. Гэтэл, тэдгээр амьтдыг алж устгадаггүй байсныг сүүлд нь мэдсэн юм. Пүүсийн эзэн өвчтэй сармагчингүүдиг хайрцагт хийлгээд Виктори нуурын дундах нэг жижиг арал дээр аваачиж суллан тавьдаг байжээ. Иймээс, хааяагүй өвчтэй сармагчин давхилсан тэр арал, чухамдаа, сармагчны вирусүүд үүрлэсэн уурхай буюу тахлын голомт болсон гоц аюултай арал болон хувирч болзошгүй болсон байлаа. Түүгээр ч барахгүй, нөгөө пүүсийн эзэн нөхөр сармагчны тоо дутахаар нь тэрхүү аралруу очиж нөгөө амьтдаасаа барьж, тоог нь гүйцээдэг байсан байх. Гэхдээ, хичнээн сармагчин барьсныг нь би яж мэдэх вэ?" гэсэн юм.

Ноён Жонсын бодож байгаагаар Марбург вирус чухам тэр арал дээр анх үүсч, тэндхийн сармагчингүүдийн дотор орчиж байсан учир, тэндээс барьсан зарим сармагчин Германда очоод өвчилсөн байж болох талтай ажээ. Сүүлхнээр нь, ДЭМБ-ын судлаачдын баг халдварын эх уурхайг тогтоохоор тэнд ирэхэд, пүүсийн эзэн "Юм асуухгүй л бол, юу ч бүү хэл!" гэж ноён Жонст зааварлажээ. Тэгтэл, хэн ч түүнээс юм асуусангүй, тэр ч ДЭМБ-ын багийн эрдэмтэдтэй уулзсангүй өнгөрчээ. Дээрх судлаачид сармагчны эрүүл мэндийг хянадаг байсан энэ хүнтэй уулзаагүй явдал нь "Тарвал судлалын үүднээс бол тун муу хэрэг боловч, пүүсийн арилжаа наймааны бодлого талаасаа бол сайн зүйл болсон" гэж ноён Жонс ярьсан юм. Нээрээ л, сэжигтэй арлаас өвчний сэжигтэй сармагчин барьж гадаадад гаргасныг нь илрүүлсэн бол, нөгөө сармагчны наймаачинчажлаасаа зайлцуулагдаж, Уганда улс ч гадаад валютыхаа үнэлж баршгүй эх сурвалжийг алдах байжээ.

Марбург вирусийн халдварт дэгдсний дараахан ноён Жонс түүний хувьд тун чухал байж болох нэгэн зүйлийг эргэн санасан байна. Тэрбээр, 1962 оноос 1965 оны хооронд Уганда улсын зүүн захад орших Элгон уулын налуу энгэрт суурьшин, малын өвчин судалж байжээ. Тэр үед Грек голын дагуу амьдардаг хүмүүс цус алдах өвчинөөр зовж, "арысанд нь сонин тууралт гарч" үхдэг тухай, мөн тэр орчмын сармагчингүүд яг ийм өвчинөөр үхдэг тухай орон нутгийн ахлагч нар түүнд ярьдаг байжээ. Ноён Жонс, тэр яриа үнэн худлыг мэдэх гэж хөөцөлдсөн ч үгүй, тэр өвчний мөн чанарыг судлах бололцоо ч байсангүй өнгөрчээ. Эргээд бодоход, Марбург вирусийн халдварт Германда анх дэгдэхээс бүр өмнө энэ вирусийн нуугдмал халдварт Элгон уулын налуу энгэрүүдэд гарч байсан бололтой.

\* \* \*

Марбург вирусийн халдварын талаарх Ноён Жонсын хувийн үзэл бодол нь харанхуй нүхэнд гар чийдэн тусган гэрэлтүүлэх мэт надад санагдаж билээ. Түүний үзэл бодол нь, халуун орны вирусийн үүсэл,

тархалттай холбоотой томоохон үзэгдлийн талаар явцуухан боловч түгшүүр төрүүлэхүйц ойлголтыг надад өгсөн юм. Түүний хэлснээр бол, Марбург хотод аваачсан сармагчингүүдийн заримыг Виктори нуурын доторх Сесе арлууд гэж нэрлэдэг хэсэг жижиг арлаас барьжээ. Сесе арлуудын дотор ч юм уу эсвэл тэндээс их л ойрхон газар оршдог бололтой. Гоц аюултай тэр арлын нэрийг ноён Жонс огт санахгүй байсан юм. Түүний мэдэж байгаагаар, тэр арал Энтеббед "тун ойрхон" гэнэ. Ямар ч байсан, ноён Жонсын тэр үеийн дарга, нөгөө сармагчны наймаачин Сесе арлууд дээр очиж, тосгоныхонтой наймаа хийж, тэндээс сармагчин худалдан авдаг байжээ. Тосгоныхон сармагчинг тахалтай адил зэвүүцэн үзэж, тэндээс салж байгаадаа баярлах төдийгүй бүр мөнгөөр өгч байгаадаа түйлаас баярсан хөөрдөг тул, сармагчны наймаачин Сесе арлуудаас зэрлэг сармагчин худалдан авч, хэрэв тэр амьтан нь өвчилбөл, Энтеббегийн ойролцоо аль нэг арал дээр суллан тавьдаг байжээ. Тэгж байгаад л, эцэст нь, гоц аюултай арлын зарим сармагчин Европд хүргэгдсэн бололтой.

Виктори нуурын Сесе арлуудруу харсан баруун эргийн, бусдаас зэлүүдхэн, хэсэгнамдор газрын зэгсэн шугуй дунд, Касенсеро хэмээх загасчдын суурин буй. Касенсеро суурин бол ДОХ өвчин дэлхийд анх гарсан газруудын нэг юм. Ер нь, Виктори нуурын баруун хойт эрэг бол ДОХ өвчин анх голомтлон тархсан газрын нэг мөн болохыг тарвал судлаачид тогтоосон билээ. ДОХ өвчнийг үүсгэгч вирус, анх Африкийн хүн дүрст сармагчин, бичнүүдээс үүсч, тэдгээрээс хүн төрөлхтний дунд ямар нэг замаар халдварлан тархжээ. Энэ вирус хүн дүрст сармагчнаас хүнд халдан тархаж, хүний биед дасан зохицож чадахуйц болтлоо дэс дараалсан, түргэн хугацааны мутацид орсон байх гэж бодогдоно. ДОХ-ын вирус хүн төрөлхтөнд аюул учруулж эхэлснээс хойших он жилүүдэд Касенсеро тосгон бүр сүйрчээ. Тэнд оршин суугчдын дийлэх нь энэ вирусийн халдвараар үхэж, Виктори нуурын эргийн дагуух бусад суурингүүд ч газрын зургаас үндсэндээ бүрмөсөн арчигдсан хэмээн ярызгаадаг юм.

Касенсеро тосгоныхон бол загасчид төдийгүй цууд гарсан хулгайн наймаачид байсан бөгөөд одоо ч хэвээрээ билээ. Тэд модон буюу моторт завиар хориотой барааг нуурын наана, цаана гаргахдаа Сесе арлуудыг нуувч газраа болгон ашигладаг юм. Хэрэв өнөөх сармагчны наймаачин Виктори нуурын эргэн тойрноос амьтнаа авдаг байсан бол Касенсеро суурин болон түүний хөрш арлуудын хулгайн наймаачидтай заавал үүлзаг байсан байж таарна гэсэн таамаглал аяндаа төрнө.

ДОХ өвчиний үүслийн талаарх нэг ерөнхий онолоор бол уг өвчин 1960-аад оны эцсээс хүн төрөлхтөнд халдвартасан гэж үздэг. Тэр үед цоо шинэ, ихээхэн ашигтай бизнес Африкт хөгжсөн нь сармагчны наймаа байжээ. Тэндээс л анагаах ухааны судалгаанд ашиглах сармагчинг үйлдвэр хөгжсөн орнуудад худалдаалж эхэлсэн бөгөөд ялангуяа Уганда улс элдэв төрөл, зүйлийн сармагчнаар маш баян байлаа. Тийнхүү, сармагчны худалдаа төв Африкийг бүхэлд нь хамрахыг дагалдан, энэ бизнест оролцдог үндсэн ажилчид, сармагчин баригчид, сармагчин тэжээгчид нь, туйлын олон зэрлэг сармагчид, ховор вирус агуулагч амьтадтай байнга ажилладаг болжээ. Тэдгээр амьтдыг олноор нь, нэг торонд чихэж байлгадаг байснаас, бие биендээ нөлөөлж, вирус дамжин халдвартлахад хүргэжээ. Үүнээс гадна, өөр өөр зүйлийн сармагчинг нэг дор хольж байлгаснаас, нэг зүйлийн амьтныг өвчлүүлэгч вирус нөгөө зүйлд дамжин халдвартлах маш таатай нөхцлийг бүрдүүлсэн байна. Энэ нь, нэг ёсондоо вирус хурданаар хувьсан өөрчлөгдөх байгалийн лаборатори болж, чухам ийм хувьслаар ХДХВ үүсчээ. Сармагчны наймаагаар дамжин ХДХВ хүн төрөлхтөнд халдсан уу? ДОХ өвчин Виктори нуур доторх арлуудаас анх тархсан уу? Эсвэл, гоц аюултай нөгөө арлаас тархсан уу? Бүү мэд дээ. ДОХ өвчин болоод Марбург вирусийн халдвартын үүсэл гарлыг тодруулахыг чармайсан хэнд ч болов учир явдал улам бүдгэрсээр, бүх мөр балран арилах боловч, тэдгээрийн хооронд ямар нэгэн нууц холбоо байна гэдэг нь аяндаа мэдрэгдэнэ. Өөрөөр хэлбэл, энэ хоёр вирус нэг зоосны хоёр тал шиг л санагддаг юм.

\* \* \*

Марбург вирусийн халдварт хүнд илэрснийг мэдмэгцээ Davид Сильверстейн эмч Найроби хотын эмнэлгийг хааж, хөл хорио тогтоох хэрэгтэй гэж Кенийн эрүүлийг хамгаалах байгууллагын дээд удирдлагаас шаардажээ. Эмнэлэг дотор байсан жаран долоон хүн, хөл хорионд хамрагдагсын дийлэнх нь эмнэлгийн ажилчид байв. Хөл хорио тогтоосон хугацаанд эмнэлэгт үзүүлэхээр ирсэн өвчтөнүүд хаалган дээрээс нь л буцхаас өөр аргагүй болжээ.

Шарль Монегийн цогцост задлан шинжилгээ хийсэн эмч нараас гадна, тэр талийгаач, Мусоке эмч хоёрыг асарч байсан сувилагчид, хоёр өвчтөний аливаа шингэн ялгадастай харьцаж байсан асрагч, сувилагч, техникийн ажилчид болоод Мусокед хагалгаа хийсэн мэс засалчид, цөмөөрөө хөл хорионд орлоо. Тус эмнэлгийн эмч ажилчдын ихэнх нь ноён Моне болон Мусоке эмчтэй шууд харьцаж байсан буюу тэр хоёрын цус, бусад шингэнтэй харьцаж байсан нь тогтоогджээ. Мусокед мэс засал хийсэн хоёр эмч “тохойгоо хүртэлх цусан дотор” ажиллаж байснаа тодхон санасаар, хоёр долоо хоногийн турш,

хөл хорионд хөлсөө гоожуулан суухдаа, Марбургийн халдварт хэдийд эхэлдэг юм бол доо хэмээн боддог байжээ.

Тийнхүү, вирусээр дүүрсэн, ганцхан хүнбөмбөг гэмтлийн тасгийн хүлээлгийн өрөөнд явж ороод, тэндээ дэлбэрч, эцэстээ эмнэлгийн бүх үйл ажиллагааг зогсооход хүргэжээ. Талийгаач Шарль Моне нэг ёсондоо усан дороос хөөрөгдөг, холын тусгалтай пуужин мэт Найробийн эмнэлгийг дотроос нь дэлбэлсэн нь тэр билээ.

Шарль Монегоос халдварт авсан Шем Мусоке эмч харин үхлийн аюултай вирустэй үзэлцээд, ялан гарч амьд мэнд үлдэж чадсан юм. Түүнийг өвчлөөд, арав хоносны дараа л байдал сайнаар эргэж эхлэхийг нь эмч нар ажиглажээ. Эхэндээ Мусоке чиг баримжаагаа алдаж, ууртай догшин болоод орондоо тайван хэвтэж чадахгүй, эмээ уух дургүй байлаа. Нэг өдөр сувилагч түүнийг орон дээр нь эргүүлэн хэвтүүлэхийг оролдож байтал Мусоке нүүррүү нь нудрагалаад “Надад таяг байна шүү. Чамайг би болгоод өгье л дээ!” гэж хашгирчээ. Энэ явдал түүний бие сайжирч эхлэх үед болсон бөгөөд нилээд хэд хоногийн дараа халуун нь дарагдаж, нүднийх нь цус харвалт арилаад, ухаан санаа нь хэвийн болж, аажим боловч бүрэн төгс эдгэрчээ.

Найробийн эмнэлгийн тэргүүний эмч нарын нэг Шем Мусоке одоо өөрийг нь эмчилсэн Davид Сильверстейны багийн гишүүнээр ажиллаж байна. Нэг удаа, би түүнтэй ярилцаж, чухам ямар явдал тохиолдсоныглавлахад, Марбургвирусийнхалдвараар өвчилсөн хэдэн долоо хоногт бараг ухаангүй байснаа тэр ярихдаа: “Би зөвхөн бүүр түүрхэн л юм санаж байна. Хамгийн гол нь толгой их эргэж байсан. Мэс засал хийлгэхийн өмнө би дуслын системээ гараасаа санжигнуулсаар өрөөнөөсөө гарч байснаа санадаг юм. Тэгээд нэг мэдэхэд би орон дээр хэвтихсэн, сувилагчид намайг тойроод л эргэлдээд байх шиг санагдсан. Эмч надруу яaran гүйж ирснийг бас санаж байна. Харин тэр үед нэг их өвдөж байсаныг санахгүй юм. Өвчин бүр эхлэж байх үед бүх булчин, ар зоогоор өвдөж байсан л даа” гэж билээ. Тэр үед Шем Мусоке эмчээс өөр Марбургийн вируст халдвараар өвчилсөн хүн тэр эмнэлэг дээр дахин гаралгүй өнгөрчээ.

Ер нь вирус хүн амыг сүйрүүлэхээр бэлтгэж байгаагийн анхны шинж тэмдэг нь янз бүрийн цаг хугацаанд, уг дэвсгэр нутгийн янз бүрийн газарт гарч байгаа халдвартын алаг цоог дэгдэлтүүд байдаг юм. Гэхдээ эдгээрдэгдэлтнээрхэн үедээ, халдвартын бичил дэгдэл маягтай л байна. Найроби хотын эмнэлэгт гарсан, Марбург вирусийн халдварт ч гэсэн ялгаагүй, тусгаарлагдмал орон зайд үүссэн нэг төрлийн онцгой байдал байлаа. Тэр удаагийн тохиолдол бол урьд өмнө нь мэдэгдэж байгаагүй ширэнгэ ойн вирусээр сэдээгдсэн халдвартын бичил дэгдэлт байсан ч, үхлийн аюултай ийм халдварт хүн төрөлхтний дунд тэсрэлт

маягаар дэгдэж, яваандаа тасралтгүй тархах аюул учруулж болох дохио сануулга байсан юм.

Тэр үед Мусоке эмчийн ийлдсийг дэлхийн зарим томоохон лабораторид илгээнээр, тэдгээр лабораторийн бичил биетний цуглуулгад амьд Марбург вирус нэмэгджээ. Тэр вирус Мусоке эмчийн шусанд Шарль Монегийн хар бөөлжиснөөс орсон бол, харин Шарль Монегийн шусанд Китумын агуягаас л орсон байж таарна. Эдүгээ Мусоке омог хэмээн нэрлэгдэх болсон тэрхүү Марбург вирус АНУ-ын Армийн лабораторийн гүн хөлдөөгчид хадгалагдаж байгаа бөгөөд амьтны хүрээлэн гэдэг шиг “гоц аюултай бичил биетний хүрээлэн” болсон тэр газраа үхэшгүй мөнх хадгалагсаар байх нь дамжиггүй.

## ОФИЦЕР ЭМЭГТЭЙ

1983 оны 9 дүгээр сарын 25, 18:00 цаг

Шарль Моне нас барснаас хойш бараг дөрвөн жил өнгөрчээ.

АНУ-ын Мериланд муж улсын Турмонт хэмээх ердийн нэгэн хотод орой болж байлаа. Муж улсын баруун хэсгээр хойноос урагшаа сунайсан Аппалачийн нурууны нэгэн оргил болох Катоктин уулын сэrvэн хийгээд түүнийг бүрхсэн ой мод, тэр аяараа намуухан, алтан шаргал өнгөөр гийгүүлэгджээ. Зүн битгий л дуусаасай гэж мөрөөдсөн охид хөвгүүд, ямар нэг сонин хачин юмтай тааралдах гэж хотын гудамжаар задгай машинтай сэлгүүцэнэ. Боловсорч гүйцсэн алимны үнэр, хатсан навчисны үнэр, талбайд гандсан сүрлийн үнэр холилдон намар цагийн согтоом анхилам үнэр болон агаарт түгжээ. Хотын захад ургасан алимны төгөлд шөнийг өнгөрүүлэхээр шавсан хар тодлын сүрэг моддын мөчирт гуагчина. Тэртээ хойно Геттисбургийн замаар гэрлээ гялбалзуулсан машины цуваа тасралтгүй урсаж харагдана.

Энэ орой хотын төвийн ойролцоо, Виктория хатан хааны үеийн барилгын загвараар баригдсан нэгэн байрны гал тогооны өрөөнд АНУ-ын армийн малын эмч, хушууч цолтой эмэгтэй Нанси Жакс гал тогооныхоо лангууны ард зогсоод хүүхдүүдээ оройн хоол хийж байлаа. Тэр бичил долгионы зууханд тавагтай зүйл тавиад товчлуурыг нь дарав. Ойрдоо хүүхдүүд нь тахианы шарсан мах идээгүй болохлоор өнөө орой дуртай хоолыг нь хийж өгөхөөр бэлтгэж байгаа нь энэ. Нанси Жакс биед чөлөөтэй богино өмд, богино ханцуйтай цамц өмсөөд хөл нүцгэн байв. Түүний хоёр хөл дээр бие хамгаалах урлагаар хичээллэсний үр дүн нь энэ дээ гэсэн шиг баахан сорви тогтжээ. Долгиотсон шаргал үсээ мөрөн дээгүүрээ тайрсан энэ эмэгтэйн ногоовтор нүдийг бүр сайн ажиглавал, хоёр өнгөтэй харагддаг юм. Нүднийх нь эвэрлэг бүрхэвч хуван шар, доторх хүрээ нь ногоовтор өнгөтэй. Гуалиг нуруутай, тамирчин

хүний төрхтэй, түргэн хөдөлгөөнтэй, гар хөлөө савчих зантай Нанси өмнө нь төрсөн нутаг “Газар тариалангийн хатан хаан” гэж алдаршсан Канзас муздаа ажилж байжээ.

Өнөөдөр хүүхдүүд нь бүр ядарчихаад, амарч ч амжаагүй байсан тул оройх нь хоолыг бушуухан хийж өгөхөөр ээж нь ярч байв. Таван настай Жейме охин, ярч байгаа ээжийхээ хөлнөөс нь зүүгдэж, хувцаснаас нь самардан чангаахад Нанси хажуу тийш хазайн, охинихоо гарыг тавиулахад, өнөөх нь дахиад л ээжийхээ нөгөө талаас зүүгдээд авах тул дахиад л зайлхаас өөр аргагүй байлаа. Настай нь харьцуулбал, арай намхан нуруутай Жейме охин, ээжийгээ дуурайсан ногоовтор нүдтэй хүүхэд юм. Энэ үед Нансигийн долоон настай хүү Жейсон зочдын өрөөнд зурагт үзэж байв. Горзгор нуруутай, туранхай биетэй, тайван дөлгөөн зантай Жейсон том болохоороо аав шигээ өндерх болох шинжтэй.

Нансигийн нөхөр Жералд Жакс бас л малын эмч бөгөөд хүн болгон Жерри хэмээн дууддаг юм. Нөхөр нь одоо Техаст сургалтанд оролцож байгаа болохлоор Нанси хүүхдүүдтэйгээ үлдсэн билээ. Жерри түүнрүү утсаар ярьж, Техаст чөтгөр ч тогтохооргүй халуун байгааг хэлээд, эхнэрээ санаж байна, гэртээ байгаа бол сайхнаа гэжээ. Нанси ч нөхрөө санаж байлаа. Жерри тэр хоёр бүр коллежид байхдаа л хамт амьдрахаар шийдсэн бөгөөд тэр цагаас хойш цөөн хэдэн хоногоос илүү хугацаагаар бие биенээсээ холдож байсангүй.

Нанси Жакс, Жерри Жакс хоёр, товчхоноор хэлбэл Жаксууд армийн мал эмнэлгийн “Жижиг нохдын эмч нарын зөвлөл” хэмээх, үздэг нохойнууд шигээ жижигхэн зөвлөлийн гишүүд бөгөөд хоёулаа армийн харуулын ноход, адую, үхэр, хонь, гахай, луус, туулай, хулгана, сармагчин гээд армийн бүх амьтдыг үзэж, эмчилдэг юм. Түүнээс гадна, армийн хоол хүнсийг тэд бас шалгах үүрэгтэй.

Нанси, Жерри хоёр эртний маягийн энэ байраа Форт Детрик хотод ажиллах томилолтоо авсны дараахан ажилд нь ойрхон, ирж очиход амрыг бодож, худалдан авчээ. Гал тогооны өрөө нь дэндүү жижигхэн бөгөөд хананаас нь усны хоолой, цахилгааны утас санжиж харагдана. Тэр өрөөнөөс холгүй, мөргөцөг гаргасан цонхтой зочдын өрөө бий. Зочдын өрөөнд байдаг халуун орны ургамал, тагнай өвсний цуглуулгын дунд Херки гэдэг нэртэй Амазоны нэгэн totiig торонд хийжээ.

Гэнэт тэр toty:

“Ай хөө, ай хөө,

Ажил тараад гэрийн зүг явцгаана хөө” хэмээн хангинатал дуулснаа, “Ээж ээ! Хөөш ээж!” гэж бахардан хашгирав. Тотьны дуу яг л Жейсон ээжийгээ дуудаж байгаа юм шиг сонстсон тул, Нанси эхэндээ мэдэлгүй “Ясан бэ?” гэснээ, хүүг нь toty дууриасныг сая анзаараад, “Гажигтай тархи!” хэмээн амандаа

бүтнав.

Тоть нь Нансигийн мөрөн дээр суух хүслээ илэрхийлж байгаа нь тэр ажээ. Тоть дахиад л “Ээж ээ! Хөөш ээж! Жерри! Жайме! Жайсон!” хэмээн энэ айлын бүх хүний нэрийг дуудан хашгираа. Хэн ч, өөрт нь хариу хэлээгүй тул, “Квай гол дээрх гүүр” хэмээх дуурийн хурандaa Богийн маршийг исгэрснээ, дараа нь “Юу гэнэ ээ? Юу-үү? Ээж ээ! Хөөш ээж!” хэмээн хашгирав.

Тотио торноос нь гаргах зав Нансид үнэндээ байсангүй. Тэр, шаламгай гэгч нь хөдлөн таваг, хоолны мөнгөн хэрэгсэл гаргаж, лангуун дээр тавьж байлаа. Нансигийн гар нь хэтэрхий огцом, түргэн хөдөлгөөнтэйг ажигласан, Форт Детрикийн зарим офицер, түүнийг аюултай нөхцөлд нарийн ширийн ажил гүйцэтгэхэд тохиорхгүй “дэндүү түргэн гартай” гэж шүүмжилдэг билээ. Нанси, бие хамгаалах урлагаар хичээллэж эхэлсэн нь нэг талаар хөдөлгөөнө тайван, уян, хүчтэй болгоно гэж найдсаных, нөгөө талаар эмэгтэй офицерийн хувьд армид ажил мэргэжилдээ ахих гэж оролдоод урам хугарсных байв. Нанси 162 см өндөр нуруутай ч, өөрөөсөө хорь гаруй сантиметр өндөр, том биетэй цэрэг эрстэй зодооны сургууль хийх дуртай. Том биетэй эрсийг жаахан балбаад өгөх нь Нансид тун аятайхан санагдлаг бөгөөд өрсөлдөгчийхөө толгойноос ч дээгүүр өшиглөж чадлаг болсондоо сэтгэл нь тун ханамжтай байлаа. Гэхдээ, гар нь дэндүү тухан болохлоор, гол төлөв, хөлөөрөө тулалдаг юм. Арагшаа эргэлттэй үсрэлтээр дөрвөн давхар бансыг хуга өшиглөж чадах болсон буюу нүцгэн хөлөөрөө ч хүн алаад хаячих дайны чадвартай болсон байв. Нанси, заримдаа, хөлийхөө хуруут гэмтээчихсэн, хамраас нь цус гоожчихсон, эсвэл нүд нь хөхөрчихсөн гэртээ ирдэг удаа бий. Тэхэд нь Жерри толгой сэгсрээд, “Миний мүү эхнэр жаахан өөр өнгөөр өнгөлүүлчихэж” гэж даапаалдаг юм.

Хушууч Нанси Жакс гэрийнхээ бүх ажлыг хийдэг ч гэсэн, нэг гэм нь ийм ажилд тэр үнэндээ дургүй. Шалны бүтээлгэнд шигдчихсэн жимсний чанамалыг арилгах гээд үрж суухад шагнал авчихсан юм шиг сэтгэгдэл төрөхгүй нь мэдээжкээс гадна, тэгээд сууж байх цаг зав ч үнэндээ олдлоггүй юм. Гэхдээ, хааяа хааяахан, гэрээ цэвэрлэх дур гэнэт хүрч, юм хумаа эмхэлж цэгцэлсээр хэдэн цагаар эргэлдэх удаа байлгүй яахав. Тэр бас гэрийнхнийхээ хоол ундыг бүгдийг нь бэлтгэх үүрэгтэй. Өрхийн тэргүүн Жерригийн хувьд, гал тогооны ажилдаанч нэмэргүйгээс гадна мотоцикл, далбаат завь мэтийн хүний санаанд ормооргүй зүйлийг гэв гэнэтхэн худалдаад авчихдаг сонин зантай тул эхнэр нь хааяа түүнтэй зөрнө өө. Жерри, Канзас мужийн Форт Рилем хотод ажиллаж байхдаа эхнэртэйгээ огт зөвлөж ярилгүйгээр далбаат завь худалдан авсан удаатай. Түүгээр ч барахгүй, улаан савхин доторлогоотой, дизель хөдөлгүүртэй, чөтгөр

ч аймаар кадиллак машин бас худалдан авчээ. Эхэн үедээ Нанси нөхөртэйгөө цуг тэр машинаар ажилдаа явдаг байсан боловч, үнийг нь төлж дуусахаас өмнө, өнөөх машин нь замын турш хар утаа савсуулдаг болжээ. Арга буюу нэг өдөр Нанси нөхөртөө: “Хүсээд байвал чи, энэ ямбий машиныхаа улаан савхин бүрээстэй бүх суудал дээр нь ганцаархнаа суугаад, хар утаа савсуулж яв! Харин би, энэ машинд чинь дахиад хэзээ ч суухгүй шүү” гэж хэлснээр асуудал шийдвэрлэгдэж, Жерри нөгөө муу кадиллакаа зараад, “Хонда аккорд” худалдан авчээ.

Жаксынхны байшин болэнхотын эртний загвартай барилгуудын хамгийн том нь. Тоосгоор барьсан, занар дээвэртэй, их бууны асар том цамхагтай, тэр байшигийн өндөр өндөр цонх, пөмбөгөр орой, модон хавтангуудыг америкийн алтлаг өнгийн туулайн бөөр модоор хийжээ. Тэдний байшин замын яг өнцөгт, түргэн тусламжийн цэгийн ойролцоо байдаг учраас шөнө болгон түргэний машины дохио хангинах тэднийг сээрээх нь хэцүү. Энэ байшинг хямдхан худалдаж авсан нь бас учиртай. Тэр үед энэ байшинг зарах гэж зөндөө удаан хүлээсэн байсан бөгөөд хуучин эзэн нь зоорийн давхартай өөрийгөө дүүжилж үхсэн тухай яриа хот даяар түгсэн байв. Жаксынхан энэ байшинг худалдан авсны дараахан нэг өдөр нөгөө амиа хорлосон хүний бэлэвсэн эхнэр тэднийд иржээ. Хуучин байраа харах гэж ирсэн тэр үрчгэр нүүртэй, хөгшин авгай цэнхэр нүдээрээ Нансиg ширтэн: “Охин минь, чи энэ байшинг үзэн ядах болно доо. Би тэгсэн юм шүү” гэжээ.

Жаксынхны байшинд tottinoos гадна бас өөр амьтад бас бий. Зочдын өрөөнд төмөр утсаар хийсэн торон дотор Сампсон гэдэг сүрхий нэртэй аварга мөгий байдаг юм. Тэр мөгий үе үе торноосоо алдууран алга болж, байшигийн эргэн тойроор сэлгүүшэхээс гадна, заримдаа хоолны өрөөн дэх ширээний голын хөндий рүү авирч ороод тэндээ хэдэн хоногоор ч унчихдаг билээ. Хүмүүс хоол идээд сууж байгаа ширээн дотор нь аварга мөгий унтаж байгаа гэж бодохоос заримдаа Нансигийн бие зарсхийдэг юм. Хэрэв үүнийг мэддэггүй хүн оройнхoo хоолыг идэж суутал, гэнэт ширээнээс нь аварга мөгий гараад ирвэл юуны чинь гайхахтай манатай, үхтлээ айна шүү дээ. Нэг удаа тэр мөгий торноосоо зугтаагаад хэдэн өдөр алга болчихжээ. Гэрийхэн хоолныхоо ширээг нүдэж, тоншиж мөгийг айлан гаргах гэсэн боловч нөгөөх нь тэнд байсангүй. Гэтэл нэгэн шөнө Нанси байрныхаа пөмбөгөр орой доторх ажлыхаа өрөөнд сууж байтал байшигийн шувуун нурууны тэндээс мөгий нь гэнэтхэн гарч ирээд, нүүрнийх нь өмнө дүүжлэгдэн, зовхигүй нүдээрээ ширтэхэд цочин хашгиран удаатай.

Тэднийд бас ирланд үүлдрийн сеттер нохой, айредале үүлдрийн теръер нохой бий. Жаксынхан Армийн янз бүрийн албанд томилогдох бүрдээ

гэрийхээ зөөврийн экосистем болсон амьтдаа хайрцганд хийхийг нь хайрцганд хийж, тороонд хийхийг нь тороонд хийгээд нүүдэг байв.

Нанси Жерридээ хайртай. Түүнээс илүү өөрийг нь ойлгодог хүн ертөнцөд байхгүй. Нөхөр нь өндөр нуруутай, хүрц хүрэн нүдтэй, харцага шиг шонхор хамартай, үзэсгэлэнтэй царайтай, цагаасаа эрт бууралтсан үстэй сайхан эр билээ. Нансид нөхрийх нь ү мөнгөн өнгөтэй юм шиг санагдахаас гадна хэл нь бас мөнгөлөг юм шиг бодогддог юм. Жерри өнөөх улаан савхин доторлогоотой кадиллак машиныг худалдан авах гэж мөнгөн хэлээ яасан чадварлаг ашиглаж байсан гээч.

Эхнэр, нөхөр хоёрын хувьд гэрээс гарч олны хөлийн газраар явах нь маш ховор. Тэр хоёр Канзас муж улсын хөдөө нутагт хоорондоо гучин хоёрхон километр зйтай, шувуу нисээд буучихаар газар өссөн боловч хүүхэд байхдаа бие биээ мэддэггүй байжээ. Харин Канзасын Улсын Их Сургуулийн мал эмнэлгийн ангид орсон хойноо хоёулаа танилцаж, хэдхэн долоо хоног үерхээд л ханилан сухад Нанси хорин настай байсан юм. Эхнэр, нөхөр хоёр их сургуулиа дүүргэх үедээ мөнгөөр тарчигхан, бас ч өртэй байсан тул шууд малын эмчээр ажиллаж эхлээ гэхнээ хөрөнгөөр гачигдаж, арга буюу армид ажиллахаар хамтдаа нэрээ бичүүлсэн билээ.

Ажлын өдрүүдэд хоол хийх зав Нансид олдлоггүй болохлоор хагас сайн өдөр болгон дараачийхаа долоо хоногийн хоолыг нэгмөсөн бэлтгэдэг юм. Ингэхдээ, вааран тогоонд үхрийн мах битүү шарах юм уу эсвэл нилээд хэдэн тахиа шараад, хүүдийд хэсэглэн хийж хөлдөөдөг билээ. Тэгээд, орой ажлаасаа ирээд, хөлдөөсөн хоолоо бичил долгионы зууханд халааж бэлэн болгодог юм. Өнөө орой ч, Нанси мөн л ингэж тахианы мах халааж байхдаа, “Ер нь хоолондоо ногоо хольж идэцгээ байз. Лаазалсан ногоон шош холивол яах бол, хүүхдүүд минь уулаасаа шошинд дуртай сан” гэж бодонгоо хөргөгчөө нээж, Леббийн ногоон шош нэг лаазыг гаргав.

Тэгээд Нанси шошныхоо лаазыг нээх гэж онгойлгогч хайн, ганц хоёр шургуулга онгичив. Олсонгүй. Сүүлдэээ тэр, юм хутгадаг халбага, ногоо

арилгагчаас эхлээд элдэв зүйлийн юмс пиг чихээстэй том шургуулгаруу очлоо. “Яршиг, тэр муу лааз онгойлгогчийг чөтгөр аваг!” гэж Нанси бodoх зуураа, мал төхөөрдөг том хутга шургуулганаас гаргав. “Лааз онгойлгоходоо энэ хутгыг хэрэглэж болохгүй шүү, гэмтэй” гэж аав нь түүнд дандаа сануулдаг байсан ч, Нанси тэр зөвлөгөөг нь огт тоодоггүй ажээ. Нанси хутгаараа лааз руу дэлстэл, үзүүр нь төмөрт шигдэн орлоо. Тэгэхлээр нь, хутганыхаа бариулын дээрээс баруун гарыхаа ирмэгээр цохиж байтал, гар нь гэнэтхэн хальтирч, хутганы ирийг даган гулгалаа. Алга нь хутганы ирэнд нилээд гүн зүсэгдсэнээс хорсч эхлэв.

Том хутга ч шалан дээр хангинаан унаж, цусны том том дусал ч лангуун дээр асгарлаа. “Ээ, мүү гөлөг, чамайг!” гэж Нанси хараагаад, баруун гараа шалгатал, алга нь яг голоороо, сүрхий гүн зүсэгдсэн байв. Яс гэмтэж, шөрмөс огтлогдчихоогүй байгаа даа гэж санаа нь зовсон эзэгтэй юу ч болсон цусаа тогтоох гэж шархан дээрээ дараад, угаалтуур руу бөхийн цоргыг нь онгойлгож, гараа усан дор тостол, угаалтуур нь ув улаан өнгөтэй боллоо. Нанси, хуруунуудаа хөдөлгөж үзтэл, зүв зүгээр байсан нь шөрмөс гэмтээгүйг харуулах тул, тийм ч аюултай шарх биш юм гэж болдоо. Тэр, гараа толгой дээрээ өргөсөөр угаалгын өрөөнд орж, шархны лент олоод, цусаа бүлэгнэж эхлэхээр нь зүсэгдсэн шархны ирмэгүүдийг хооронд нь нийлүүлж байгаад нөгөө лентээрээ дарж наалаа. Нанси ер нь цус харж чадлаггүй зантай, өөрийхөө цусыг ч үзэн ядаг билээ. Энэ нь цус чухам ямар аюултай байж болохыг, цусанд юу агуулагдаж байж болохыг сайн мэддэгээс л тэр юм.

Ингээд, ээж нь гараа шархдуулсан болохлоор, өнөө орой хүүхдүүдээ усанд оруулахаа болж, тэднийг үнтуулахаар оронд нь хэвтүүлээд, сурсан зангаараа тэврэн хэвтэв. Энэ шөнө ээжийнхээ өвөрт Жейме унтлаа. Нанси, ер нь хүүхдүүдээ өвөртлөж унтахаас татгалздаггүй бөгөөд Жерриг эзгүй хойгүүр хоёр хүүхдийхээ ойр байдаг зантай. Ялангуяа Жейме аавыгаа эзгүй хойгүүр жаахан ааш гаргадаг учраас өнөөдөр охиноо жаахан аргадаж тайвшруулах хэрэгтэй юм шиг ээжид нь санагджээ.

Англи хэлнээс орчуулсан Э.Пүрэвдаваа



**English abstracts of the original research articles**

**COMPARISON OF DETECTION OF  
RESPIRATORY VIRUSES  
BY A MULTIPLEX REAL-TIME  
PCR ASSAY AND BY THE R-MIX  
READY CELL CULTURE**

*Ch.Maitsetseg<sup>1</sup>, N.Bayasgalan<sup>1</sup>, S.Tsatsral<sup>1</sup>,  
B.Darma<sup>1</sup>, P.Nymadawa<sup>1,2</sup>*

<sup>1</sup>*National Center of Communicable Diseases, Mongolia,*

<sup>2</sup>*Mongolian Academy of Medical Sciences*

**Introduction:** Respiratory viruses are a major cause of human morbidity and mortality globally. In average the influenza virus isolation has yielded only in 9.8% positive results in Mongolia in 2003-2007 [B.Darma et al., 2009]. PCR assays are now becoming routine methods for diagnosis of respiratory virus infections, but the large and increasing number of viral pathogens makes laboratory diagnosis with individual assays challenging. This study has been performed to investigate possibilities to introduce multiplex rt-PCR into routine practice of screening of influenza-like illness (ILI) samples.

**Materials and methods:** 661 nasopharyngeal archival swabs collected in 2010-2011 and kept at -70° C have been selected for this study.

**Nucleic acid isolation:** has been done with ExiPrep™ Viral DNA/RNA kit, Bioneer, Korea according to the manufacturer's instruction.

Detection of the respiratory viruses: 1) has been performed by Fast Real Time PCR System 7500, Applied Biosystems, USA using Respiratory Pathogens Kit, Fast-Track Diagnostics, Luxemburg, according to the manufacturer's instruction, and 2) has been done by Direct Immunofluorescent microscopy using Respiratory Kit and R-Mix (DHI, USA) hybride cell culture according to the manufacturer's instruction.

**Results:** For the 1st part were selected 661 samples collected between October 2010 and July 2011 where no influenza viruses were detected by real-time PCR. In 310(46.9%) samples have been detected 17 types of pathogens with the prevailing detection of respiratory syncytial virus in 59(8.9%) samples, rhinovirus in 45(6.8%) samples, parainfluenzaviruses in 39(5.9%) samples indicating the outbreak has been caused mainly by these agents.

For the 2nd part from 661 nasopharyngeal archival swabs collected in the period from October 2010 to April 2011 have been selected 274 samples and detection of agents were compared by multiplex real-time PCR and R-mix hybrid cell culture. If by multiplex real-time PCR the specificity and sensitivity were 100%, by R-mix hybrid cell culture the sensitivity was 41% and the specificity was 100%.

**Conclusion:** Multiplex real-time PCR method is to be recommended for routine screening of ILI samples.

*Mongolian Journal of Infectious Disease Research Disease Research, 2011,  
№ 4(41):47-52;  
2 Table, 6 Figure and 12 References;*

**“Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн редакцийн зөвлөл**

- Ерөнхий эрхлэгч:** **П.Нямдаваа**, ХӨТМҮХ-ны тэргүүн, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор  
академич, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, 99112306, pumadawa@gmail.com
- Дэл эрхлэгчид:** **М.Алтанхүү**, Монголын вирус судлалын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, анагаах ухааны доктор, 99092337, amurd@magicnet.com
- Г.Батбаатар**, Монголын дархлаа, нян судлалын нийгэмлэгийн тэргүүн, анагаах ухааны доктор, дэл профессор, 99081827 gobi\_bat@yahoo.com
- Г.Зулхүү**, Монголын халдвартын эмч нарын нийгэмлэгийн тэргүүн, анагаах ухааны доктор, дэл профессор, 99196772, zulkhuu@yahoo.com
- Д.Нямхүү**, ХӨСҮТ-ийн ерөнхий захирал, Анагаах ухааны доктор, профессор, 99100155
- Д.Отгонбаатар**, БГХӨСҮТ-ын ерөнхий захирал, анагаах ухааны доктор, клиникийн профессор, 99113549, 632859
- Л.Энхбаатар**, ХӨТМҮХ-ны гүйцэтгэх захирал, анагаах ухааны доктор, 99780134, cmb1691@yahoo.com

Эрхэлсэн нарийн бичгийн дарга:

**Хүндэт гишүүд:**

- Д.Дандийн**,  
Биологийн ухааны доктор, төрийн шагналт, 99881009
- Ч.Долгор**,  
ЭМШУИС-ийн зөвлөх багш, анагаах ухааны доктор, профессор, ардын эмч, 99725670
- Н.Донлог**,  
“Эрүүл мэнд- дархлаажуулалт” төрийн бус байгуулагын гүйцэтгэх захирал, клиникийн профессор, 99948695
- Г.Жамбаа**,  
ЭМШУИС-ийн захирлын зөвлөх, анагаах ухааны доктор, профессор, гавьяат багш, 458010

**Гишүүд:**

- Д.Абмэд**,  
ХӨСҮТ-ийн паразитологийн тасгийн эрхлэгч, биологийн ухааны доктор, 99778211, 454188 abmed99@yahoo.com
- З.Адяасурэн**,  
БГХӨСҮТ-ын зөвлөх, анагаах ухааны доктор, клиникийн профессор, 99166676, adiyas\_z@yahoo.com
- Д.Анхлан**,  
ХБНГУ-ын Мюнстерийн Их сургуулийн Үрэвслийн молекул биологийн төвийн Молекул вирусологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, анагаах ухааны доктор, (45)-251-83-52214, anhlan@uni-munster.te
- Б.Арьяа**,  
АНУ-ын Үндэсний эрүүл мэндийн хүрээлэнгийн Настан судлалын институтийн Дархлаа судлалын лабораторийн тэргүүлэх судлаач, биологийн ухааны доктор, biragina@mail.nih.gov

- О.Баатархүү,**  
ЭМШУИС-ийн халдвартын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, 99188386, baatarkhuu6@yahoo.com
- Ж.Батаа,**  
ХӨСҮТ-ийн Зоонозын халдвартын тасгийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 96012505
- Д.Даваалхам**,  
ЭМШУИС-ийн Эпидемиологи-биостатистикийн тэнхимийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 91990560, dawaalkham@hsum.edu.mn
- Я.Дагваадорж**,  
ЭМШУИС-ийн халдвартын тэнхимийн эрхлэгч, анагаах ухааны доктор, дэл профессор, 91180537, dahg wah@yahoo.com
- Б.Дармаа**,  
ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 99754821
- Т.Дэлгэр**,  
ХӨСҮТ-ийн зөвлөх эмч, клиникийн профессор, хүний гавьяат эмч, 99170153
- Ч.Мөнхшэшэг**,  
ЭМЯ-ны халдварт өвчин, тархвар судлалын мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор, 99136244, munkh828@yahoo.com
- Н.Наранбат**,  
Анагаах ухааны доктор, “Гялс” анагаах ухааны төвийн гүйцэтгэх захирал, 99099471, naranbat@givals.mn
- Ж.Оюунбилэг**,  
НЭМХ-ийн захирал, биологийн шинжлэх ухааны доктор, профессор, 99762000, jobileg@magicnet.mn
- Р.Оюунгэрэл**,  
ХӨСҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор, ravijirouyun@yahoo.com

**Р.Туул**,  
ХӨСҮТ-ийн Улаан бурхны лавлагаа лабораторийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 99093674, r\_tuul@yahoo.com

**Н.Хоролсүрэн**,  
ЭМШУИС-ийн халдвартын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, 99189309, khorolnran@yahoo.com

**Ж.Хулан**,  
МУИС-ын Биотехнологийн сургуулийн багш, биологийн ухааны доктор,

**Н.Хүрэлбаатар**,  
ЭМЯ-ний төрийн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор, профессор, 99196665, khurel@nccd.goy.mn

**Б.Цацрагт од**,  
ХӨСҮТ-ийн эрдэм шинжилгээ хариуцсан дэл захирал, анагаах ухааны доктор, 88031009

**С.Цогтсайхан**,  
ЭМШУИС-ийн Бичил амь-дархлаа судлалын тэнхимийн эрхлэгч, анагаах ухааны доктор дэл профессор, tsog-San@yahoo.com

**Н.Цэнд**,  
ХӨСҮТ-ийн зөвлөх, анагаах ухааны доктор, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан 88858929

**Д.Цэрэнноров**,  
БГХӨСҮТ-ын дэл захирал, биологийн ухааны доктор, 99883159, 99069998 dnorov\_99@yahoo.com

**Ч.Эрдэнэчимэг**,  
ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-тай тэмцэх албаны тасгийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 99263767, ch\_erdenechmg@yahoo.com

Редакцийн хаяг:

Улаанбаатар, Төв шуудан ш/х 119,

“Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн редакцийн зөвлөл

Эрхэлсэн нарийн бичгийн дарга Л.Энхбаатар, ХӨСҮТ, Захиргааны байр, Амьсгалын замын вирус судлалын лаборатори

E-mail: cmb1691@yahoo.com; Утас:455847

Хэвлэлийн дизайнер: С.Эрдэнэпүрэв

Цаасны хэмжээ: А4

Хэвлэсэн тоо: 300ш

“СПИЙД ВЕЙ” ХХК-д хэвлэв.